

# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР



# 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




Холбоо барих

70376471, 70376483, 70373770

darkhan@gazar.gov.mn

Дархан сум, 8-р баг, 17-р хороолол
Ардын эргэн чөлөөний 5-504

**НЭГ. ГАЗРЫН ХАРИЛЦАА:**

**1.1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ, ӨМЧЛӨЛ**

1.1.1. Газар зохион байгуулалт төлөвлөлт:
1.1.2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө сурталчлах:
1.1.3. Газар өмчлөл
1.1.4 Газрын кадастр, бүртгэлийн чиглэл

**1.2. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ**

1.2.1. Геодезийн байгын цэг тэмдэгтийн хадгалалт, хамгаалалт:
1.2.2. Байнгын ажиллагаатай станц /CORS/:
1.2.3. Байр зүйн зураглалын болон гүйцэтгэлийн зураг, шугам сүлжээ инженер геодезийн ажлууд:
1.2.4. Монгол орны газар зүйн нэрийн тодруулалт хийх, мэдээллийн сан үүсгэх:
1.2.5. Хаяг дугаар олгох, хаягийн зургийг хэрэглээнд нэвтрүүлэх:

**1.3. ГАЗРЫН МОНИТОРИНГ**

1.3.1. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны чиглэлээр:
1.3.2. Аймгийн хэмжээнд атаршиж орхигдсон тариалан болон атаршсан газрын судалгаа:
1.3.3. Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх

**1.4. ГАЗРЫН ТАТВАР ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭ**

1.4.1. 2022 оны ногдол, нэхэмжлэл
1.4.2. Газрын дуудлага худалдаа
1.4.3 Авлигатай тэмцэх чиглэл

**ХОЁР. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ:**

**2.1 ХОТ БАЙГУУЛАЛТ**

2.1.1 Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт
2.1.2 Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан
2.1.3 Барилга байгууламж ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулсан
2.1.4 Барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон
2.1.5 Баригдаж буй барилга байгууламжуудад хяналт шалгалт хийсэн
2.1.6 Барилга угсралт, техник хяналт

**2.2 БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЛАБОРАТОРИ**

2.2.1 Барилгын материалын үйлдвэрлэлийн мэдээллийн сан, баяжуулалт
2.2.2 Тохиролын гэрчилгээ
2.2.3 Барилгын материалын тусгай зөвшөөрөл
2.2.4 Барилгын материалын үйлдвэрлэлийн мэдээ, тайлан
2.2.5 Хяналт шалгалт

**2.3 ДЭД БҮТЭЦ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ**

2.3.1 Барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл
2.3.2 Барилга байгууламж ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулсан талаар
2.3.3 Архитектур төлөвлөлтийн даалгавар
2.3.4 Жижүүрийн хөтлөлтийн тайлан
2.3.5 Газар чөлөөлөлт

**ГУРАВ. ЗАХИРГАА УДИДЛАГА:**

**3.1. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ**

3.1.1. Мэдээлэл технологийн талаар үйл ажиллагаа:

**3.2. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ**

3.2.1. Өргөдөл шийдвэрлэлт:
3.2.2. Архивын үйл ажиллагаа:

**3.3. САНХҮҮ ТӨСӨВ**

3.3.1. Үйл ажиллагааны зардал
3.3.2. Үйл ажиллагааны орлого
3.3.3. Шилэн данс
3.4.4. Санхүү нягтлан бодох бүртгэл
3.1.2. Нярав

**3.4. ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ**

3.4.1. Сургалт, зөвлөгөөн

**3.5. БУСАД АЖИЛ**

## НЭГ.ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛ

### 1.1 ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ӨМЧЛӨЛ

#### 1.1.1. Газар зохион байгуулалт төлөвлөлт:

❖ Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 28 дугаар тогтоолоор, Шарын гол сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 24 тогтоолоор, 2022 оны 17, 18 дугаар тогтоолоор тодотгол нийт 3 удаа, Хонгор сумын ИТХ-ын 2022 оны 15-б, 2022 оны 22 дугаар тогтоолуудаар нийт 2 удаа, Орхон сумын ИТХ-ын 2021 оны 10 дугаар тогтоолоор тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

❖ 2022 оны тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтээр Шарын гол сум 55 арга хэмжээ төлөвлөж 53 арга хэмжээ хэрэгжүүлэн хэрэгжилт 96,3 %, Хонгор сум 191 арга хэмжээ төлөвлөж 150 арга хэмжээ хэрэгжүүлэн хэрэгжилт 78,5 %, Орхон сум 13 арга хэмжээ төлөвлөж 11 арга хэмжээ хэрэгжүүлэн 85 %, Дархан сум 28 арга хэмжээ төлөвлөж 22 арга хэмжээ хэрэгжүүлэн хэрэгжилт 78,6 %-ийн хэрэгжилттэй аймгийн нийт дүнгээр тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт **84.6** хувьтай хэрэгжсэн байна.

❖ 2022 онд Дархан-Уул аймгийн хэмжээнд шинээр

- Дархан суманд аймгийн Засаг даргын 7 удаагийн захирамжаар 11 иргэн, хуулийн этгээдэд 33,8 га, Дархан сумын Засаг даргын 2 удаагийн захирамжаар 12 иргэн, хуулийн этгээдэд 0,85 га газар нийт 23 иргэн, хуулийн этгээдэд 34,65 га газрыг эзэмшүүлэх,
- Хонгор суманд тус сумын Засаг даргын 46 удаагийн захирамжаар 146 иргэн, хуулийн этгээдэд 306,5 га газар эзэмших, 1 удаагийн захирамжаар 3 хуулийн этгээдэд 0,075 га газар ашиглах
- Шарын гол суманд тус сумын Засаг даргын 12 удаагийн захирамжаар 50 иргэн, хуулийн этгээдэд 33,5 га газар эзэмших,
- Орхон суманд тус сумын Засаг даргын 13 удаагийн захирамжаар 55 иргэн, хуулийн этгээдэд 61,91 га газар эзэмших, 1 хуулийн этгээдэд 0,01 га газрыг ашиглахаар тус тус шийдвэр гарсан байна.
- Аймгийн хэмжээнд нийт 76 удаагийн захирамжаар 437,56 га газрыг 274 иргэн аж ахуй нэгж байгууллагад шинээр эзэмшүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан “Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих” цогц арга хэмжээний хүрээнд Орхон суманд нийт 1153.1 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэхийг дэмжих тухай тогтоолыг сумын ИТХ-аар хэлэлцүүлж 2022 оны 18 дугаар тогтоолоор батлуулсан.



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ОРХОН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 06 сар 20 өдөр Дугаар 18 Орхон

Атар газрыг тариалангийн
газарт шилжүүлэхийг дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Есдүгээр Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1.Тус сумын 1153.1 га газрыг тариалангийн газарт шилжүүлэхийг дэмжсугэй.

2.Тариалангийн газарт шилжүүлэх атар газрын нэр, солбицлын цэгийг 1 дүгээр хавсралтаар, кадастрын зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

3.Тогтоолыг аймгийн Засаг даргад хүргүүлэхийг сумын Засаг дарга (Б.Алтансарнай)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал хариуцсан хороо" (Ц.Нацагдорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.ХУЛАН

45220103S



Сумын ИТХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн Есдүгээр Хуралдааны 18 дугаар тогтоолын 1-р хавсралт

Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх жагсаалт, солбицол

| № | Сумын нэр | Багийн нэр | Газрын байршил | Газрын хэмжээ /га/ | Газрын зориулалт | Солбицол |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Орхон | Баян-Өлзийт | Баян-Уул | 21.7 | Тариалангийн газар | X=585122.231 Y=5523259.749<br>X=584612.418 Y=5523575.064<br>X=584826.480 Y=5524047.744<br>X=585327.271 Y=5523443.382 |
| 2 | Орхон | Баян-Өлзийт | Баян-Уул | 7.1 | Тариалангийн газар | X=584483.394 Y=5523750.497<br>X=584051.814 Y=5523243.305<br>X=584050.518 Y=5523251.905<br>X=584048.579 Y=5523264.458<br>X=584047.511 Y=5523278.244<br>X=584045.654 Y=5523280.640 |
| 3 | Орхон | Баян-Өлзийт | Баян-Уул | 6.9 | Тариалангийн газар | X=584906.768 Y=5523216.297<br>X=584905.985 Y=5523213.067<br>X=584520.028 Y=5523748.788<br>X=584540.431 Y=5523746.567<br>X=584553.281 Y=5523744.633<br>X=584567.795 Y=5523741.975 |
| 4 | Орхон | Баян-Өлзийт | Баян-Уул | 1 | Тариалангийн газар | X=584855.482 Y=5523089.537<br>X=584850.039 Y=5523080.738<br>X=584843.505 Y=5523070.756<br>X=584836.974 Y=5523061.340<br>X=584832.533 Y=5523055.224<br>X=584818.162 Y=5523036.845 |
| 5 | Орхон | Баян-Өлзийт | Баян-Уул | 1.3 | Тариалангийн газар | X=583645.501 Y=5522570.557<br>X=583851.792 Y=5522525.851 |

*Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэхийг дэмжсэн Сумын ИТХ-ын тогтоол / Зураг 2 /*

### 1.1.2 Газрын дуудлага худалдаа төсөл, сонгон шалгаруулалтын талаар

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2022 онд нийт 36 нэгж талбарт газрын дуудлага худалдаа зохион байгулах төлөвлөгөөтэй

Үүнд: Дархан сум 5, Орхон сум 5, Хонгор сум 22, Шарын гол сум 4 нэгж талбар байна.

Үүнээс аймгийн Засаг даргын 2022.03.04-ний өдрийн 01-А/49 дүгээр захирамжаар Дархан сумын 5 нэгж талбарт цахим дуудлага худалдааг 2022.04.08-ны өдөр зохион байгуулсан боловч 1 оролцогч хүсэлт ирүүлж, дуудлага худалдаа хүчингүй болсон.

Орхон, Шарын гол сумдууд тус бүр 4 нэгж талбарт сумын Засаг даргын 2022.11.30-ны өдрийн 01-А/188, А/163 дугаар захирамжуудаар 2022.12.30-ний өдөр, цахим дуудлага худалдааг зохион байгуулна.

Төсөл сонгон шалгаруулалт аймгийн хэмжээнд болоогүй.

### 1.1.3 Газрын төлбөр, татвар, орлого бүрдүүлэлтийн талаар

Газрын төлбөрийн тухай хуулийн 6.3-д 2021.07.07-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж "сум, дүүргийн" гэснийг "аймаг, нийслэлийн" гэж өөрчлөлт оруулсон бөгөөд 2022.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаатай холбогдуулан Дархан-Уул аймгийн хэмжээнд "Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утга"-ыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 9 дүгээр хуралдаанаар 2022.03.21-ний өдөр хэлэлцэн баталсан бөгөөд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5846-т бүртгэгдсэн. Газрын төлбөрийн цахим систем /2022.06.16/-д тогтоолыг шинэчлэн бүртгэж, төлбөрийн итгэлцүүрийг шинэчилсэн.

Аймгийн хэмжээнд 8448 гэрээнд 1.6 тэрбум төгрөгийн ногдол нэхэмжлэл үүсгэж татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна. Үүнээс 4100 нэгж талбарын 1,350

тэрбум төгрөгийн төлөлтийн мэдээлэл хүлээн авсан. Орон нутгийн төсөв 81.2 хувиар биелсэн байна.

Аймгийн хэмжээнд 490 барьцааны гэрээ бүртгэж, тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. Үүнд: Дархан сум 274, Хонгор 186, Орхон 26, Шарын гол 4 байна.

| Д/д | Сумын нэр | Барьцаанд бүртгэсэн |
|---|---|---|
| 1 | Дархан сум | 274 |
| 2 | Хонгор сум | 186 |
| 3 | Орхон сум | 26 |
| 4 | Шарынгол сум | 4 |
| **Нийт** | | **490** |

Газрын биржийн цахим системээр нийт 579 үнийн мэдээ цуглуулж, газрын үнэлгээний системд оруулсан. Үүнд: Дархан сум 243, Орхон сум 154, Хонгор сум 155, Шарын гол сум 27 үнийн мэдээ оруулсан байна.

| Д/д | Сумын нэр | Үнийн мэдээ |
|---|---|---|
| 1 | Дархан сум | 243 |
| 2 | Хонгор сум | 155 |
| 3 | Орхон сум | 154 |
| 4 | Шарынгол сум | 27 |
| **Нийт** | | **579** |

### 1.1.4 Газрын кадастр, бүртгэлийн чиглэлээр

Газрын кадастрын бүртгэлийн чиглэлээр Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд 7300 нэгж талбарын цахим хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүртгэж, улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд бүртгэсэн байна. Үүнээс:

| **Сумын нэр** | **Цахим хувийн хэрэгт бүртгэсэн** |
|---|---|
| Дархан сум | 4956 |
| Хонгор сум | 1466 |
| Орхон сум | 725 |
| Шарынгол сум | 153 |
| **Нийт** | **7300** |




Цахим хувийн хэрэг бүртгэсэн байдал **График.1**

Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд 5274 ирсэн цахим хүсэлтийг тухай бүр хянаж газрын кадастрын нэгдсэн цахим системээр дамжуулан шийдвэрлэсэн байна. Үүнээс:

| Сумын нэр | Цахим хүсэлт |
|---|---|
| Дархан сум | 3896 |
| Хонгор сум | 899 |
| Орхон сум | 370 |
| Шарынгол сум | 109 |
| **Нийт** | **5274** |




Цахим хүсэлт ирсэн байдал: **График.2**

**<u>Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн цахим системд нөхөн бүрдүүлэх ажлын хүрээнд:</u>**

Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн цахим системд бүртгэгдээгүй нэгж талбарыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/253 тоот албан бичгээр ирүүлсэн нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлийн дагуу Аймгийн хэмжээнд 2026 нэгж талбарыг Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн цахим системд бүртгэн ажилласан байна.




**График.3**



Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн цахим системд бүртгэгдээгүй нэгж талбарын нөхөн бүрдүүлэлт хийхээс өмнөх, дараах байдлыг харьцуулсан **зураг. 1**

Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ нийт 4290 хэвлэсэн. Үүнээс Гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээ 3451, Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ 859, дундын мэдээллийн сангаар дамжуулан Э дугаар авч газар эзэмших эрхийн гэрчилгээ бичиж гэрээ байгуулсан байна.

Геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудаар шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт хэмжилт хийлгэсэн 347 иргэн, аж ахуйн нэгжийн хашаа болон үл хөдлөх хөрөнгийн кадастрын зургийг газрын кадастрын мэдээллийн системд оруулж кадастрын зураг гаргаж өгсөн.

Хонгор, Орхон, Шарын гол сумын газрын кадастрын мэдээллийн санд алдаатай орсон 54 нэгж талбарыг засаж зөв болгон мэдээллийн санд бүртгэж оруулсан байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан “Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих” цогц арга хэмжээний хүрээнд Орхон суманд төмс хүнсний ногоо, тариалангийн талбай шинээр бий болгох боломжтой газрын хээрийн судалгаа, хэмжилтийг хийж нийт 1153.1 га атар газрын кадастрын зургийг хийж судалгааг Дархан-уул аймгийн ХХААГ-т хүргүүлсэн.




*Атар газрын тариалангийн газарт шилжүүлэх газрын мэдээлэл. /Зураг 3/*

## 1.2 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР

### 1.2.1. Геодезийн байгын цэг тэмдэгтийн хадгалалт, хамгаалалт:

GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцад тулгуурлан GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцад тулгуурлан Геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд **62** улаан шугам болон **40** гүйцэтгэлийн зураглал, **165**-н иргэн аж ахуйн нэгжийн хашаа болон үл хөдлөх хөрөнгийн кадастрын зургийг хийж гүйцэтгэсэн.

### 1.2.2. Байнгын ажиллагаатай станц /CORS/:

Дархан–Уул аймгийн Дархан суманд байрлах GNSS-ийн байнгийн ажиллагаатай стацад тулгуурлан:

- 1 дүгээр улиралд: ГЦТ-811, 5707, 828, 5480 цэгүүд дээр “Ёлт сүрвэй” ХХК-ний CHCNav i80 rover маркийн 2 долгионы GPS багажийг ашиглан
- 2 дугаар улиралд: ГЦТ-012, 704, 5480, 5707 цэгүүд дээр
- 4 дүгээр улиралд: Гр 035, 012, 5409, 060, 4380, 056, 5876 цэгүүд дээр бодит агшины RTK хэмжилт хийж гүйцэтгэн 192.168.20.24 /Geodesy/ GNSS Дархан хавтсанд байршууллаа. Хэмжилтийг 2010 оноос хойш ГХБХБГ-т ашиглаж ирсэн Tremble маркийн 2 долгионы GPS багажаар хийж гүйцэтгэсэн.

### 1.2.3. Байр зүйн зураглалын болон гүйцэтгэлийн зураг, шугам сүлжээ инженер геодезийн ажил

2022 оны 03 сарын 15-18-ны хооронд зохион байгуулагдсан “Орон зайн өгөгдөл мэдээллийг бүрдүүлэгч байгуулагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулах хэрэглээнд нэвтүүлэх” сургалтанд хамрагдсан.







Геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн хийсэн 40 гүйцэтгэлийн зураглалыг актаар хүлээн авч 1:1000 масштабтай байр зүйн зурагт:

- дулааны шугам 445.4м,
- цэвэр усны шугам 307.9м,
- ариутгах татуургын шугам 457м,
- холбооны кабель 377.2м,
- цахилгааны шугам 2611,5м,
- авто зам 1167,3м,
- дугуйн зам 2826,1м,
- явган зам 14464,8 м шинэчлэн оруулж мэдээг Abel-ээр ГЗБГЗЗГ-ын ГЗЗ хэлтсийн мэргэжилтэн Ундармаад хүргүүлсэн.

### 1.2.4. Монгол орны газар зүйн нэрийн тодруулалт хийх, мэдээллийн сан үүсгэх:

Геодезийн цэг тэмдэгтийн тооллогыг 2 жилд нэг удаа хийж байгаа бөгөөд 2019 онд хээрийн судалгаа тооллогын ажил хийгдсэн.

Сумдын газрын даамалуудын өгсөн мэдээг нэгтгэн Дархан сум 48, Орхон сум 12, Шарын гол 4, Хонгор сум 60 нийт 125 цэг, 6 устсан цэгийн мэдээллийг цахим санд бүртгэлээ.

“Баян бридж” ХХК-нь Дархан сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах /Ньюрк/ толгой дээр саравч барихдаа геодезийн байнгын цэг тэмдэгт ГЦТ-055-ийг устгаж хэмжилт хийх нөхцлийг алдагдуулсан байна.






***Гэмтээгүй байх үеийн зураг*** ***Түрж гэмтээсэн үеийн зураг***

Геодезийн байнгын цэг тэмдэгтийг бэлтгэх, газарт бэхлэх, хэмжилт хийх ажлын төсөв

| д/д | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ мян. төг | Тайлбар, үндэслэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Улсын геодезийн ба өндрийн сүлжээний байнгын цэг тэмдэгтийг бэлтгэж суулгах | репер | 1 | 93 700 | 93 706 | Зардлын тооцоог Монгол Улсын БХБЯ-ны сайдын 2021 оны 123 тушаалаар баталсан “Геодези, зураг зүйн жишиг үнэ” БД 81-103-21-ыг баримтлан хийв. |
| 2 | Хиймэл дагуулийн технологоор улсын геодезийн сүлжээний солбицол тодорхойлох хэмжилт хийх | цэг | 1 | 418 282 | 418 282 | |
| 3 | Нивелирдлэг хийж өндөр дамжуулах | км | 1.7 | 72 632 | 123 474 | |
| **Нийт дүн** | | | | | **636 462** | |

Геодезийн байнгын цэг тэмдэгтийг зөөж шилжүүлэх, хэмжилт хийхэд гарах зардлыг тооцоог гаргаж хүргүүллээ. Зардлын тооцоог Монгол Улсын БХБ-ын сайдын 2013 оны 45 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Геодези, зураг зүйн жишиг үнэ” БД 81-103-13-ыг баримтлан хийв.

43 дугаар тогтоолоор батлагдсан Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийг геопортал программд 2003 онд батлагдсан 660 газар зүйн нэртэй тулгаж бүртгэж, баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. 191 газар зүйн нэрийг геопортал мэдээлэн санд бүртгэлээ.



*Геопортал программ хангамжид бүртгэл хийсэн УИХ-ын 43 дугаар тогтоолоор батлагдсан*

*Дархан –Уул аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн жагсаалт*

Дархан-Уул аймгийн 4 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 3.3 мянган км.кв талбайд нийт 1841 газар зүйн нэрийг тодоруулах ажил хийгдэх шаардлагатай байгаагаас Дархан сумын газар зүйн нэрийн тодоруулалтын ажилд 1.0 сая төгрөгийг зөвхөн бичиг баримт боловсруулах, зураг хэвлэх ажилд зориулахаар баталсан нь хээрийн тодоруулалтын ажил хийх зардалд хүрэлцэхгүй байгаа тул хээрийн тодоруулалтын ажил хийгдээгүй.

Дархан сумын ГЗН салбар зөвлөлийн хурлыг 2022 оны 10 сарын 03-ны өдөр 14 цагт Дархан сумын Засаг даргын орлогч П.Ихбаярын өрөөнд хийсэн. Дархан сумын газар зүйн нэрийн тодоруулалтын ажлыг хийхэд шаардагдах хөрөнгө орон нутгийн төсөвт суугаагүй байна. Иймд энэ ажлыг хийж гүйцэтгэх мөнгө санхүүгийн асуудлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулах саналыг Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэхээр тогтсон.

БХБ сайдын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 123-р тушаалаар батлагдсан “геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ БД81-103-21” -ийн баримтлан Дархан-Уул аймгийн Дархан сум 1.8 сая, Орхон сум 3,7 сая, Шарын гол сум 1.8 сая, Хонгор сум 82,3 сая газар зүйн нэрийн тодоруулалтын ажлын төсвийг гарган ХОХБТХ-т хүргүүлсэн. /171 тоотоор/

**1.2.5. Монгол орны газар зүйн нэрийн тодруулалт хийх, мэдээллийн сан үүсгэх:**

Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах хаяг дугаар олгогдоогүй авто гаражийн судалгааг гаргаж 103 авто гаражийг хаягжуулж мэдээллийн нэгдсэн системд байршуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.




Хонгор сумын 1 дүгээр багт шинээр мал бүхий иргэдэд олгосон **82** нэгж талбарт шинээр хаяг дугаар олгож Хонгор сумын ИТХ-ын тогтоол гаргуулж баталгажуулсан ба малтай иргэдийн суурьшуулах бүсэд 177 солбицол хатгаж 82 нэгж талбарыг шохоо асгаж тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

  

Орхон сумын нутаг дэвсгэрт гахай шувууны аж ахуй эрхлэх иргэн аж ахуйн нэгжид олгох газрын улаан шугамыг тавьж тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн ба нийт 190 солбицолыг газарт шилжүүлж 47 нэгж талбарыг шохой асгаж тэмдэгжүүлсэн.

  

Хаягийн зургийн дагуу **191** иргэн, **49** аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Хаягжуулалт" төслийн хүрээнд Дархан сумын 5,15, багуудын нутаг дэвсгэрт хийгдэх гудамж өргөн чөлөө болон барилга байгууламжийн хаягийн тэмдэг үйлдвэрлэх, байршуулах ажлын даалгаварыг хүргүүлсэн. Үүний дагуу 15 дугаар багийн 10-р хэсгийн /Асгат/ гудамжны хаягийг үйлвэрлэж байршуулах ажил хийгдсэн.

Шуудангийн нэгдсэн кодын мэдээллийн санд шинэчлэлт, баяжуулалт хийх ажлын хүрээнд Дархан сумын баг, хорооны зохион байгуулалтанд өөрчлөлт орсон эсэхийг харуулсан хилийн цэсийн зураг, иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил ашиглалтанд байгаа газар болон үл хөдлөх эд хөрөнгийн байршлын зургийг Монгол Улсын Харилцаа Холбооны зохицуулах хороонд хүргүүлсэн.

  

*Зургийг amgalan.ts@crc.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.*

Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа 18 гомдол мэдээлэлд дурдагдсан газрын байршлыг харуулсан зургийг гаргаж хүргүүлсэн.



*Шалгагдаж байгаа газрын байршлыг харуулсан зургууд*

Шуудан хүргэлтийн ажилчид зориулан Дархан сумын 15 дугаар багийн 1-10-р хэсгийн хаягийн зургийг авах хүсэлтийг ирүүлсэн " Монгол шуудан" ХХК-ны хүсэлтийн дагуу 1-10-р хэсгийн хаягийн 13 ширхэг зургийг А4 форматаар / шинэ, хуучин / хэвлэн хүргүүлсэн.

БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/489 дугаар тушаалаар "Шарын гол сумийн төвийн хүн амын унд-ахуйн төвлөрсөн ус хангамжийн" эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоосон солбицол, Шарын гол сумын ИТХ-ын 2021 оны №23 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын солбицолуудыг давхцуулан шалгаж байршил болон давхцалыг харуулсан зураг 4 ширхэг зургийн хамт Шарын гол сумын Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн.



*Давхацлыг харуулсан зургууд*

"Багийн нэрийг УИХ-аар батлуулахад БХБЯ-ыг шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажиллах" ажлын хүрээнд ГЗБГЗЗГ-аас судалгаа хийж УИХ-д танилцуулсан ажлын тайланд Дархан-Уул аймгийн Дархан сумын Өргөө /17/, Малчин /18/ багуудаас бусад 1-16-н баг нь оноосон нэр байхгүй зөвхөн багийн дугаар баталсан нь Үндсэн хууль, Монгол хэлний тухай, Геодези, зураг зүйн тухай, Газрын тухай хуулиудыг зорчиж байна гэж дурдагдсан.

Иймд багуудад оноосон нэр олгох ажлыг багийн ИНХ-аар хэлэлцүүлэн нэрийн саналаа ирүүлэх тухай албан бичгийг багуудын Засаг дарга нарт хүргүүлж 16 багийн оноосон нэрийн саналыг хүлээн авч нэгтгэн Дархан сумын Засаг дарга, сумын газар зүйн нэрийн салбар зөвлөлд албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсын Их хурлын 2022 оны намрын чуулганаар Дархан-Уул аймгийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг хэлэлцэх учраас багуудад "оноосон нэр олгох" асуудлыг

шийдвэрлэх боломжгүй гэсэн үндэслэлээр одоог хүртэл Аймгийн болон сумын ИТХ-аар хэлэлцүүлж чадаагүй.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ТӨВИЙН 1-16 ДУГААР БАГИЙН ИРГЭД БОЛОН БАГИЙН ИНХ-ААС ИРҮҮЛСЭН ОНООСОН НЭРИЙН САНАЛ

| д/д | Одоо мөрдөгдөж байгаа багийн дугаар | Санал болгосон багийн оноосон нэр | Багийн ИНХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны тэмдэглэлийн огноо, дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | 1 дүгээр баг | “Чулуут” 1-р баг | 2021.11.08 №12 | |
| 2 | 2 дугаар баг | “Ухаа хошуу” 2-р баг | 2021.10.26 №019 | |
| 3 | 3 дугаар баг | “Хараа” 3-р баг | 2021.10.29 №11 | |
| 4 | 4 дүгээр баг | “Ган зам” 4-р баг | 2021.12.15 №08 | |
| 5 | 5 дугаар баг | “Давхар” 5-р баг | 2021.11.13 №01 | |
| 6 | 6 дугаар баг | “Хөгжил” 6-р баг | 2021.12.05 № Н/30 | |
| 7 | 7 дугаар баг | “Баян Уул” 7-р баг | 2021.11.10 | |
| 8 | 8 дугаар баг | “Наран” 8-р баг | 2021.12.28 №02 | |
| 9 | 9 дүгээр баг | “Хээтэй” 9-р баг | 2021.12.09 | |
| 10 | 10 дугаар баг | “Баянхан” 10-р баг | 2021.11.09 №02 | |
| 11 | 11 дугаар баг | | | |
| 12 | 12 дугаар баг | “Соёмбо” 12-р баг | 2021.12.14 №02 | |
| 13 | 13 дугаар баг | “Билүүт” 13-р баг | 2021.11.29 | |
| 14 | 14 дүгээр баг | “Бурхант” 14-р баг | 2021.10.29 № 4/28 | |
| 15 | 15 дугаар баг | “Мангирт” 15-р баг | 2022.01.30 №05 | |
| 16 | 16 дугаар баг | “Найрамдал” 16-р баг | 2021.11.04 №24 | |
| 17 | 17 дугаар баг | “Өргөө” 17-р баг | | Хуучин нэршлээрэй |
| 18 | 18 дугаар баг | “Малчин” 18-р баг | | Хуучин нэршлээрэй |

Хаягийн мэдээллийн системд Дархан, Хонгор , Орхон, Шарын гол сумдын нийт 11973 нэгж талбар, 994 байшин, 850 гудамж, нэгж талбар болон барилгын 12823 орц гарцны мэдээлэл шалгах, засварлах хянасан төлөвт шилжүүлэх, 103 авто гаражийг хаягжуулж мэдээллийн нэгдсэн системд байршуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Хаягийн зургийн дагуу 191 иргэн, 49 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Хаягжуулалт” төслийн хүрээнд Дархан сумын 5,15 багуудад хийгдэх өргөн чөлөө, гудамж болон барилга байгууламжийн хаягийн тэмдэг үйлдвэрлэх байршуулах ажлын даалгаварыг боловсруулж хүргүүлсэний дагуу 15 дугаар багийн “Асгат”-ын гудамжны хаягийн тэмдэг үйлдвэрлэх байршуулах

“Дархан даллах” ХХК-ний гомдол, санал хүсэлтийн дагуу Дархан сумын 5 дугаар баг 20-р хороололд байрлах тус компианы эзэмшлийн газарт зорчих хэсгийг гарган хэмжилт хийж кадастрын зургийг хүргүүлсэн.

Зураглалыг гаргахдаа тухайн орчинд шинээр хийгдсэн явган хүний зам болон авто машины зорчих хэсгийн газрыг хасаж тухайн компианы эзэмшлийн газрыг боломжтой тал руу шилжүүлэх замаар талбайн хэмжээг өөрчлөхгүйгээр /1186 м2 / хийж гүйцэтгэлээ.

Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас ирсэн албан бичгийн дагуу Ашигт малтмал газрын тосны газраас хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт хийх ажлын хүрээнд 243 дугаар тогтоолоор батлагдсан 6.5 сая гектар талбайн зургийг /shp file/ мэдээллийн санд оруулж усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалтай байгаа эсэхийг шалгалаа. Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Зулзагын гол дагуу байрлах 5-н нэгж талбар Засаг даргын захирамжаар орон нутгийн хамгаалалтанд авсан хамгаалалтын бүстэй давхцаж байгааг харуулсан зургийг гаргаж хүргүүлсэн.




Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны 10 сарын 26-ны өдрийн А/176 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын ГУХ-ийн дарга Г.Нямдорж, геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхчулуун нар Дархан-Уул аймагт геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт хийлээ. Хяналт-шинжилгээ үнэлгээг “ Гео од”, “Ёлт сүрвэй”, “Эхлэх цэг хангай” ХХК-ууд хамруулан доорхи чигллээр хийж гүйцэтгэсэн.

*1.Суурь нөхцөл шаардлага хангаж буй эсэх.*

Тухайн аж ахуйн нэгжүүд өөрийн офиссын байранд иргэн, аж ахуйн нэгжийг хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна.Үүнд:

- “Гео од” ХХК нь Дархан сум 10 дугаар баг 13-р байранд
- “Ёлт сүрвэй” ХХК нь Дархан сум 9 дүгээр баг 4/2-р байранд
- “Эхлэх цэг хангай” ХХК нь Дархан сум 12 дугаар баг 15-р байранд

*2.Багаж, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа*

Тухайн аж ахуйн нэгжүүдийн ашиглаж байгаа хэмжилтийн багажийн бүрэн бүтэн байдал болон геодезийн хэмжил зүйн лабораторид баталгаажуулалт хийлгэсэн эсэхийг шалгасан.

*3.Хүний нөөцийн мэдээлэл*

“Гео од” ХХК: 3-н хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

- Газар зохион байгуулагч инженер-1
- Геодезийн инженер -1
- Кадастрын инженер -1

“Эхлэх цэг хангай” ХХК: 9-н хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

- Газар зохион байгуулагч инженер-3
- Кадастрын инженер -3
- Гэрээт ажилчин -1
- Туслах ажилчин -2

“Ёлт сүрвэй” ХХК: 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

- Кадастрын инженер -1
- Геодезийн инженер -1
- Газар зохион байгуулагч инженер-1 бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

“ГЕО ОД” ХХК








“ЭХЛЭХ ЦЭГ ХАНГАЙ” ХХК












ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн хяналт-шинэжилгээ хийх хяналтын хуудасыг шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж таглуулан ирүүлсэн хяналтын файлыг 192.168.20.24 \Geodesy\ Amarzaya  Хяналт шалгалт хавтсанд байршуулсан.

Дархан-Уул аймагт байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого хийх ажлын хэсэгт орж ажиллаа. Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын нутаг дэвсгэрт байрлах 24 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хэмжилт хийж солбицолыг нь тогтоож баталгаажуулсан.








*Түүх, соёлын өвд бүртгэгдсэн дурсгалууд*

## 1.3. ГАЗРЫН МОНИТОРИНГ

### 1.3.1 Газрын хянан баталгаа, мониторинг, газар нөхөн сэргээх, хамгаалах чиглэлээр

*Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглах*

Landsat-8 OLI/TIRS хиймэл дагуулын мэдээнээс 2019, 2020 оны 6, 8, 10 саруудын 11 сувгын мэдээ бүхий 2  планшэйтийн Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийг багтаасан растер мэдээг татаж авсан. 2021 оны мөн саруудын мэдээг татаж авсаны дараа ENVI 4.7 программ дээр таван сувгын мэдээг ашиглан  ургамлан нөмрөгийн индекс болох  NDVI–г бодуулж харьцуулалтыг харуулсан зураг хийсэн.




*Зураг-1 Зайнаас тандан судлалын аргаар боловсруулалт хийсэн байдал*

Mongolian data cube- https://mongolia.sibelius-datacube.org –аас 2018 болон 2021 оны мэдээг татаж Дархан-Уул аймгийн хэмжээнд сувгийн нийлэмж үүсгэн, ургамлын индекс зураглаж түүнийг тооцоолон ургамалжилтын харьцуулсан зураг хийсэн.

***Төлөвлөгөөт хянан баталгаа***

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ЗДТГ-ын захиалгаар 2021 онд хийгдсэн 3.32 га газрын захиалгат хянан баталгааны ажлын дүгнэлтийг 2022.02.16-ны өдөр хянаж байнгын шинжээчээр батлуулсан.



*Зураг-2 Шарын гол сумын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг байнгын шинжээчээр баталгаажуулсан бадал*

Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэрт Чанарын Улсын хянан баталгаа хуучин суурьшлын бүсийн 340.76 га, 2022 онд шинээр өмчлүүлэх 3.6 га хуучин сщсуурьшлын бүсийн 344.36 га нийт 720 га талбайд Орхон сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолоор санхүүжилтийг шийдвэрлэн дүгнэлтийг 2022.07.28-ны өдөр баталгаажуулсан.



*Зураг-3 Орхон сумын улмын хянан баталгааны ажлыг байнгын шинжээчээр баталгаажуулсан бадал*

### 1.3.2 Газар нөхөн сэргээх, хамгаалах

2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 28 дугаар тогтоолоор батлагдсан 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эвдэрч эзэнгүй орхигдсон газрын судалгааг гаргаж үүнээс **2424** метр квадрат газрын нөхөн сэргээлтийг Дархан-Уул аймгийн БОАЖГазартай хамтран Дархан кареръ ХХК-аар дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийлгэсэн.



*Зураг-5 Дүйцүүлэн хамгаалах газрын кординатыг тогтоож Дархан карьерь ХХК-ны удирдлагад танилцуулж байгаа байдал*

**Захиалгат хянан баталгаа:** Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын даргын 2022 оны 05.03-ны өдрийн 1/822 тоот албан бичгийн хүрээнд хянан баталгааны ажлыг эрчимжүүлэн ажиллаж газар эзэмших эрх шилжих бүрт иргэн аж ахуй нэгж байгууллагуудаар хийлгүүлэж ажиллаж байна.

Мөн 2022.05.20-ны өдөр байгууллагын https://www.darkhan.gazar.gov.mn сайтад, фэйсбүүк пэйж, Дархан-Уул аймгийн дөрвөн сумын газрын даамлуудын цахим хуудсаар олон нийтэд энэ талаар сурталчлан ажиллав.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн цахим системээр 2022.01.01-2022.12.11-ний өдрийн байдлаар захиалгат хянан баталгааны 484 тайланг хянаж баталгаажуулсан.

2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 1/2283 тоот тушаалаар батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Дархан-Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн эрх бүхий 3 байгууллагад хийж гүйцэтгэсэн.



*Зураг-7 Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг мэргэжлийн гурван байгууллагад хийв*

### 1.3.3 Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах:

2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг тусгахаар сумын даамлуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ-ын Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хэсгийг байгуулах чиглэлийг сумын даамлуудад өгч, 8

дугаар  сарын эхний 7 хоногт аймгийн хэмжээнд нийт 27 цэгт хийж гүйцэтгэсэн. Тайланг 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр 609 албан тоотоор ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд бэлчээрийн мониторингийн 29 цэгтэй бөгөөд энэ жил 27 цэгийн үр дүнг газрын кадастрын нэгдсэн системд оруулах ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.

2020 оноос хойш 27 цэгт хийж 2 цэгийн мэдээллийг автоматаар бичиж тайланд илгээж байсан ба уг 2 цэг нь устаж тариалангийн талбайд орсон байна. Ирэх жил байнгын мониторингийн цэгийн тоог нэмэгдүүлж ажиллах төлөвлөгөө гаргаж 4 болон 5 дугаар зэрэглэлийн доройтолтой газруудыг зураглаад байна.




*Зураг-8  Дархан Уул аймгийн бэлчээрийн фото мониторингийн байнгын цэг*

Дархан сум 2016 оноос хойш бэлчээрийн фотомониторинг хийгдээгүй, мөн Дархан хотыг 2020-2035 он хөгжүүлэх хот хөгжлийн төлөвлөгөөнд бэлчээрийн газрыг ногоон байгууламж, хот тэлэх бүсэд болгож төлөвлөсөн, орон нутгийн улирдлагууд мал бүхий иргэдийг хотоос гаргах бодлого барьж ажиллаж байгаатай холбоотой фотомониторинг хийдэггүй.

Манай аймгийн хувьд сэргэх чадавхийн I түвшинд буюу байгалийн унаган төрхөө алдаагүй  2 цэгийн 9414.89  га бэлчээрийн газар байгаа нь нийт газар нутгийн 6,5%-ийг, II түвшинд буюу маш богино хугацаанд сэргэх боломжтой  11 цэгийн төлөөлж буй 68258,2 га бэлчээрийн газар байгаа нь нийт газар нутгийн 46,98%-ийг, сэргэх чадавхын III түвшинд буюу сэргэх боломжтой (5-10 жил шаардагдана) Экосистемийн үйлчлэлүүд нэлээд алдагдсан төлөвтэй 7 цэгийн төлөөлж буй 13130,2 га бэлчээрийн газар байгаа нь нийт газар нутгийн 18,04%-ийг, сэргэх чадавхын IV түвшинд буюу унаган зүйл ургамлууд устаж, түрэгч ургамал нэмэгдэн, ус зүйн өөрчлөлтийн улмаас нөхөн сэргээлтийн арга хэмжээ авахгүйгээр сэргэх боломж муу (10-с дээш жил шаардлагатай) төлөвтэй 4 цэгийн төлөөлж буй 25888,24 га бэлчээрийн газар нь аймгийн нийт бэлчээрийн 9,04%-ийг, сэргэх чадавхын V түвшинд буюу хөрсний алдагдал, давсжилт, элэгдэл эвдрэл хүчтэй илэрсэн, унаган төлөвт нь оруулах боломжгүй болж цөлжсөн  3 цэгийн төлөөлж буй 28574.52 га бэлчээрийн талбай нь нийт бэлчээрийн 17,8%-ийг эзэлж байна.

***Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх чиглэлээр***

Дархан-Уул аймгийн хэмжээнд  Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж, газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлын зохион байгуулан ажиллаж байна.




| | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дархан сум | 204 | 2446 | 3362 | 3823 | 4022 | 4732 | 5330 | 5870 | 6582 | 7411 | 7842 | 7992 | 8259 | 8387 | 8485 | 8715 | 8788 | 8886 | 8931 |
| Орхон сум | 8 | 85 | 468 | 530 | 535 | 546 | 564 | 604 | 681 | 977 | 1564 | 1837 | 2290 | 2458 | 2512 | 2784 | 2905 | 2935 | 3182 |
| Хонгор сум | 77 | 174 | 408 | 435 | 438 | 448 | 468 | 530 | 559 | 585 | 758 | 805 | 923 | 1023 | 1071 | 1174 | 1207 | 1253 | 1293 |
| Шарын гол сум | 11 | 59 | 313 | 372 | 421 | 460 | 513 | 730 | 781 | 855 | 931 | 945 | 975 | 992 | 1036 | 1079 | 1116 | 1116 | 1165 |
| Аймгийн хэмжээнд | 300 | 2764 | 4551 | 5160 | 5416 | 6186 | 6875 | 7734 | 8603 | 9828 | 11095 | 11579 | 12447 | 12860 | 13104 | 13752 | 14016 | 14190 | 14571 |

Дархан сум  Орхон сум  Хонгор сум  Шарын гол сум  Аймгийн хэмжээнд

***Зураг 5. Аймгийн хэмжээнд газар өмчлүүлсэн байдал /2003-2021 он/***

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн  нутаг дэвсгэрт 2003-2021 ондуудад  нийт **14571** иргэнд  1606.87 га газрыг тус тус өмчлүүлсэн байна.

Аймгийн хүн амын тоо харьцуулбал **14.1** хувьтай байна. Тус тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлж ажилласан.

2022 онд “Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох тухай” аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021-10-01 -ны өдрийн 69 дүгээр тогтоол батлагдан гарч аймгийн нутаг дэвсгэр дэх 26 байршилд иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаа.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хуучин хашааны газарт 445 иргэнд 33,94 га газрыг өмчлүүлэхээр тусгуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Тайлант хугацаанд буюу 2022 онд иргэнд газар өмчлүүлэх ажлыг аймгийн хэмжээнд нийт 75 иргэн 5,3  га газар өмчлүүлсэн  болно.

***Хүснэгт 3. Газар өмчлөлийн хэрэгжилт***

| сумын нэр | Төлөвлөсөн | | | | Хэрэгжилт | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шинээр | | Хуучин сууршлийн бүсэд | | Шинээр | | Хуучин сууршлийн бүсэд | | |
| | Иргэний тоо | Талбайн хэмжээ /га-аар/ | Иргэний тоо | Талбайн хэмжээ /га-аар/ | Иргэний тоо | Талбайн хэмжээ /га-аар/ | Иргэний тоо | Талбайн хэмжээ /га-аар/ | |
| **Дархан сум** | | | 195 | 13,87 | | | 53 | 5,6 | 27,1% |
| **Шарын гол сум** | 20 | 1,4 | | | 20 | 1,4 | 6 | 0,56 | 100% |
| **Хонгор сум** | | | 143 | 13,9 | | | 123 | 15,7 | 86% |
| **Орхон сум** | | | 81 | 5,66 | | | 81 | 5,66 | 100% |
| **Нийт** | | | **419** | **33,94** | | | **263** | **27.52** | **78.2%** |

***<u>Хамтран өмчлөх эрхээсээ татгалзаж, дахин шинээр газар өмчлөх эрх үүсэх</u>***

Дархан-Уул аймгийн хэмжээнд хамтран өмчлөх эрхээсээ татгалзаж, шинээр газар өмчлөх эрхээ сэргээлгэхийг хүссэн 194 иргэний өргөдлийг хүлээн авч сумын Засаг даргын 4 удаагийн захирамжаар асуудлыг шийдвэрлэсэн.

***<u>Өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэх</u>***

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт орсноос хойш аймгийн хэмжээнд газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр аймгийн хэмжээнд хүсэлт гаргасан 124 иргэнд газар өмчилж аваагүй лавлагаа, цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авилгатай тэмцэх газарт нотлох баримт 182 албан тоотоор лавлагаа, мэдээллийг гаргаж хүргүүлсэн.

Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн **1500** иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.

***<u>"Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулсан ажлын хүрээнд:</u>***

Аймгийн хэмжээнд Хонгор суманд 2, Дархан суманд 3, Орхон суманд 2, Шарын гол суманд 2 нийт давхардсан тоогоор 10 удаа сумдын засаг даргын тамгын газар, аймгийн татварын хэлтэс, хөдөлмөр халамж үйлгээний газар, улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран " Нээлттэй хаалга"-ны өдөрлөг зохион байгуулан нийт 2448 иргэн, хуулийн этгээдэд газрын харилцаатай холбоотой мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч, гарын авлага тарааж, egazar.gov.mn цахим системийн ач холбогдол, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд цахимаар санал өгөх, газрын төлбөр, татварын ногдуулалт, төлөлт, нөхөн бүрдүүлэлтийн баримт бичиг хүлээн авч, шинэчилсэн бүртгэлд хамруулах, кадастрын зурган мэдээллээр үйлчлэх зэрэг нийт 13 төрлийн үйлчилгээг үзүүлж ажилласан.

| № | Сумын нэр | огноо | Үйлчилгээ авсан иргэн хуулийн этгээдийн тоо |
|---|---|---|---|
| 1 | Дархан сум 18 баг | 2022.04.08-10 | 1949 |
| 2 | Хонгор сум | 2022.04.08 | 106 |
| 3 | Шарынгол сум | 2022.04.09 | 75 |
| 4 | Орхон сум | 2022.04.10 | 143 |
| 5 | Хонгор сум | 2022.09.19 | 38 |
| 6 | Шарынгол сум | 2022.10.05 | 45 |
| 7 | Орхон сум | 2022.10.14 | 24 |
| 8 | Дархан сум | 2022.10.10 | 68 |
| **Нийт** | | | **2448** |









Дархан-Уул аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас болон фэйсбүүк, www.Egazar.gov.mn цахим хуудсаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад ил тод нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

E-gazar.gov.mn сайтад иргэдэд үйлчлэх хуваарийн дагуу цахим бүртгэл дээр хувиар гаргаж мэргэжилтэнүүд ээлж ээлжээр ажилласан.




***<u>Зөрчилтэй нэгж талбарын зөрчил арилгах үйл ажиллагааг зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн ажлын хүрээнд:</u>***

Мэдээллийн санд бүртгэгдээгүй Зөрчилтэй нэгж талбар давхаргын хүснэгтэн мэдээлэлд засвар хийж статусыг 20 болгон зөрчил арилгасан тайлбарыг **349** нэгж талбарт оруулсан.

Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн цахим системд газар ашиглалтын зориулалт буруу бүртгэсэн зөрчлийг арилгаж зөрчилтэй нэгж талбарын давхаргын хүснэгтэн мэдээлэлд засвар зөрчил арилгасан тайлбарыг **67** нэгж талбарт оруулсан.




Дархан суманд 2022 оны 12 дугаар сарын байдлаар 62 иргэн, аж ахуй нэгж байгууллагад хугацаатай шаардах хуудас хүргүүлэн Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-т заасны дагуу газар чөлөөлөх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулан ажилласан.





| Зөрчил гаргасан байдал | Зөрчил арилгасан байдал |
| --- | --- |
|  |  |

| Зөрчил гаргасан байдал | Зөрчил арилгасан байдал |
| --- | --- |
|  |  |

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр дур мэдэн газар эзэмшиж, ашиглаж хууль тогтоомж зөрчсөн, сумын нутаг дэвсгэрийн суурьшлийн бүсэд зөвшөөрөлгүй буусан мал бүхий иргэдийн газрыг албадан чөлөөлөх ажлыг Дархан сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/120 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2 удаа шаардах хуудас хүргүүлж хугацаандаа нүүгээгүй айлуудыг Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-т заасны дагуу албадан газар чөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаа.

Уг ажиллагаанд ажлын хэсэгт орсон Дархан сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Захирагчийн ажлын алба, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газрын холбогдох албан тушаалтан, албан хаагч хамтран ажиллаа.

Албадан буулгах ажиллагааг Дархан-2 өртөө буюу Дархан сумын Малчин баг Ужим булагт зөвшөөрөлгүй өвөлжөө, саравч барьсан мал аж ахуй эрхлэж буй олон жил суурьшсан 5 өвөлжөөний 6 өрх айлд Засаг даргын захирамжийг танилцуулж дахин 5-15 хоногийн хугацаатай мэдэгдэлийг хүргүүлэн зөвшөөрөлгүй хашаа, саравчыг албадан буулгалт хийсэн.









Суурьшлийн бүсэд зөвшөөрөлгүй буусан мал бүхий иргэдийн газрыг албадан чөлөөлсөн байдал:

Дархан сумын 1,2,3 багийн нутаг дэвсгэрт үерийн далан дагуулж тавьж буй авто замын трассын дагуу өмчлөлийн газрын хашаа барилга орсон айлуудад газар чөлөөлөх хугацаатай мэдэгдэх хуудас өгч ажилласан. Нийт 5 айлд мэдэгдэл хүргүүлж газар чөлөөлөх арга хэмжээг авч ажиллаа.




Мөн Дархан сумын 7-р багт тавигдсан Шинэ хуучин дарханыг холбосон авто замын трасст орсон 4 айлын хашааг татуулах мэдэгдэл хуудасыг Барилга захиалагчийн холбогдох мэргэжилтэнтэй хамтран ажиллаа.





Дархан-Уул аймгийн засаг даргын 7 удаагийн захирамжаар 33,8 га газрыг 11 иргэн, аж ахуй нэгж байгууллагад  шинээр   эзэмшүүлсэн байна.

Дархан сумын засаг даргын 2 удаагийн захирамжаар 12 иргэнд 0,85 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, 1 иргэнд сүм хийдийн зориулалтаар эзэмшүүлсэн байна.

Хонгор сумын Засаг даргын 46 удаагийн захирамжаар 306,5 га газрыг  146 иргэн, аж ахуй нэгж байгууллагад шинээр  эзэмшүүлсэн байна. Хонгор сумын Засаг даргын 1 удаагийн захирамжаар 0,075 га газрыг  3 аж ахуй нэгж байгууллагад шинээр  ашиглуулах захирамж гаргасан байна

Шарын гол сумын Засаг дарга 12 удаагийн захирамжаар 34,5 га газрыг 50 иргэн, аж ахуй нэгж байгууллагад шинээр эзэмшүүлсэн байна.

Орхон сумын Засаг даргын захирамжаар 9 удаагийн захирамжаар 61,91 га газрыг 55 иргэн, аж ахуй нэгж байгууллагад шинээр эзэмшүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 76 удаагийн захирамжаар 437,56 га газрыг 274 иргэн аж ахуй нэгж байгууллагад шинээр эзэмшүүлсэн байна.

## 1.4 ГАЗРЫН ТӨЛБӨР, ТАТВАР, ҮНЭЛГЭЭ

### 1.4.1. 2022 оны ногдол, нэхэмжлэл

Аймгийн хэмжээнд 8448 гэрээнд 1.6 тэрбум төгрөгийн ногдол нэхэмжлэл үүсгэж татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна. Үүнээс 4100 нэгж талбарын 1,350 тэрбум төгрөгийн төлөлтийн мэдээлэл хүлээн авсан. Орон нутгийн төсөв 81.2 хувиар биелэж байна.

Аймгийн хэмжээнд 490 барьцааны гэрээ бүртгэж, тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. Үүнд: Дархан сум 274, Хонгор 186, Орхон 26, Шарын гол 4 байна.

| Д/д | Сумын нэр | Барьцаанд бүртгэсэн |
|---|---|---|
| 1 | Дархан сум | 274 |
| 2 | Хонгор сум | 186 |
| 3 | Орхон сум | 26 |
| 4 | Шарынгол сум | 4 |
| **Нийт** | | **490** |

Газрын биржийн цахим системээр нийт 579 үнийн мэдээ цуглуулж, газрын үнэлгээний системд оруулсан. Үүнд: Дархан сум 243, Орхон сум 154, Хонгор сум 155, Шарын гол сум 27 үнийн мэдээ оруулсан.

| Д/д | Сумын нэр | Үнийн мэдээ |
|---|---|---|
| 1 | Дархан сум | 243 |
| 2 | Хонгор сум | 155 |
| 3 | Орхон сум | 154 |
| 4 | Шарынгол сум | 27 |
| **Нийт** | | **579** |

### 1.4.2. Газрын дуудлага худалдаа

Дархан-Уул аймгийн хэмжээнд 36 нэгж талбарт газрын дуудлага худалдаа зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнд: Дархан сум 5, Орхон сум 5, Хонгор сум 22, Шарын гол сум 4 нэгж талбар байна. Үүнээс аймгийн Засаг даргын 2022.03.04-ний өдрийн 01-А/49 дүгээр захирамжаар Дархан сумын 5 нэгж талбарт цахим дуудлага худалдааг 2022.04.08-ны өдөр зохион байгуулсан боловч 1 оролцогч хүсэлт ирүүлж, дуудлага худалдаа хүчингүй болсон. Орхон, Шарын гол сумдууд тус бүр 4 нэгж талбарт сумын Засаг

даргын 2022.11.30-ны өдрийн 01-А/188, А/163 дугаар захирамжуудаар 2022.12.30-ний өдөр, цахим дуудлага худалдааг зохион байгуулна.

2022.02.11

| № | Сумын нэр | Төлөвлөсөн нэгж талбар | Талбайн хэмжээ /га/ | Дуудлага худалдааны анхны үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Дархан | 5 | 2.3 | 495,230,400.00 |
| 2 | Орхон | 5 | 2.9 | 28,528,000.00 |
| 3 | Хонгор | 22 | 126.8 | 924,814,600.00 |
| 4 | Шарын гол | 4 | 0.2 | 2,013,000.00 |
| | Нийт | **36** | **132.1** | **1,450,586,000.00** |

2022 онд зохион байгуулах төсөл сонгон шалгаруулатлын нэгж талбарын тоо, талбайн хэмжээ, орлогын төлөвлөгөө

2022.02.11

| № | Сумын нэр | Төлөвлөсөн нэгж талбар | Талбайн хэмжээ /га/ | Дуудлага худалдааны анхны үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Дархан | 1 | 1550 | |
| | Нийт | **1** | **1550** | **-** |

- Газрын төлбөрийн тухай хуулийн 6.3-д 2021.07.07-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж "сум, дүүргийн" гэснийг "аймаг, нийслэлийн" гэж өөрчлөлт оруулсон бөгөөд 2022.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаатай холбогдуулан Дархан-Уул аймгийн хэмжээнд “Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утга”-ыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 9 дүгээр хуралдаанаар 2022.03.21-ний өдөр хэлэлцэн баталсан бөгөөд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5846-т бүртгэгдсэн. Газрын төлбөрийн цахим систем /2022.06.16/-д тогтоолыг шинэчлэн бүртгэж, төлбөрийн итгэлцүүрийг шинэчилсэн.
- 2022 онд аймгийн хэмжээнд 36 нэгж талбарт газрын дуудлага худалдаа зохион байгуулах, Дархан сумын хэмжээнд байгаа 1300 гаруй гаражийн судалгааг гаргаж багийн Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд ГАРАЖуудын хаалгыг нэг ижил СААРАЛ өнгөөр будуулах, хаалганы гадна хүрээг цагаанаар будуулах, эмульсдэх нэгдсэн хаягжуулалтын ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд 280 гаражид хаяг олгож, будуулсан байна. Мөн 9, 12-р багийн нутаг дэвсгэрт байрлах гаражуудын хувийн хэргийг нэг бүрчлэн архиваас татаж танилцан, шинэчилсэн бүртгэлд орсон эсэхийг шалгаж шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:
- 12-р багт 179 гаражийн мэдээлэл манай байгууллагын архивын мэдээллийн санд бүртгэлтэй байна. Үүнээс 5 иргэнд хугацаа сунгах тухай утсаар мэдэгдэж, 13 гэрээг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан, 9 гэрээний кадастрын зураг байхгүй, байршил тодорхойгүй, утасны дугааргүй тул шинэчлэх боломжгүй байна.

- 9-р багт 349 гаражийн мэдээлэл манай байгууллагын архивын мэдээллийн санд бүртгэлтэй байна. Үүнээс 4 иргэнд хугацаа сунгах тухай утсаар мэдэгдэж, 4 гэрээг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан, 6 гэрээний кадастрын зураг байхгүй, байршил тодорхойгүй, утасны дугааргүй тул шинэчлэх боломжгүй байна.
- Газар өмчлөлийн 2070 нэгж талбарын хөрөнгийн бүртгэлийг нэг бүрчлэн аймгийн Татварын удирдлагын нэгдсэн системд илгээж, газрын татварын нэхэмжлэлийг үүсгэсэн.
- Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 28 дугаар тогтоолын дагуу Дархан сумын 5-н байршилд Газрын дуудлага худалдааг 2022 оны 04-р сарын 08-ны өдөр зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2022.03.04-ны өдрийн 01-А/49 дүгээр захирамж гаргуулж, газрын биржийн цахим систем /www.mle.mn/-д байршуулсан. Аймгийн Засаг даргын 2022.04.05-ний өдрийн 01-А/89 дүгээр захирамжаар газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, 2022.04.08-ний өдөр зохион байгуулсан. Дуудлага худалдаанд Сайнбуян овогтой Туяабаяр /РД: ТЯ80110421/ оролцох хүсэлт ирүүлсэн бөгөөд дуудлага худалдаа явуулах журмын 9.11 дэх хэсэгт заасны дагуу 1 оролцогч ирсэн тул дуудлага худалдаа явагдаагүй болно.
- Газрын харилцааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Нээлттэй хаалганы өдөрлөгийг 2022 оны 04 дүгээр сарын 08, 09, 10-ний өдрүүдэд 3 хоног зохион байгууллаа. Дархан-Уул аймгийн хэмжээнд нийт 2273 иргэн, хуулийн этгээдэд газрын харилцаатай холбоотой мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч, гарын авлага тарааж, egazar.gov.mn цахим системийн ач холбогдол, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд цахимаар санал өгөх, газрын төлбөр, татварын ногдуулалт, төлөлт, нөхөн бүрдүүлэлтийн баримт бичиг хүлээн авч, шинэчилсэн бүртгэлд хамруулах, кадастрын зурган мэдээллээр үйлчлэх зэрэг нийт 13 төрлийн үйлчилгээг үзүүлж ажиллаа.

Тус өдөрлөгийн онцлог нь өргөн хүрээнд нийтийг хамарсан, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад ойр байх үүднээс аймгийн хэмээний нийт 26 баг бүрт хүрч ажилласан нь үр дүнтэй ажил болсон.

1. Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл Ди Би Эс /DBS/ телевизээр Нээлттэй өдөрлөг зохион байгуулах, газрын цахим систем egazar.gov.mn-ийг сурталчлан тус системээс хэрхэн мэдээллээ шалгах, газрын биржийн цахим системээр газрын дуудлага худалдаанд хэрхэн оролцох талаар “Шууд ярилцлага”–д 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр мэдээлэл өгсөн. / https://fb.watch/ckR623IQQR/ /









2. Орон нутгийн радио FM_NICE 89.1-ээр 2022.04.08-2022.04.10-ний өдрүүдэд цаг тутмын 55 минутад Газрын харилцааны нээлттэй өдөрлөг болох зар сурталчилгаа явуулсан.

3. Аймгийн хэмжээний 26 багийн Засаг даргатай уулзаж, газрын цахим систем egazar.gov.mn-ийг сурталчлан таниулж, “Газрын харилцааны хөгжил-Багаас эхтэй” уриалга дэвшүүлж, багийн төвүүд дээр ажиллаж цагийн хуваарийг батлан гаргаж хуваарийн дагуу ажилласан.






## 1.4.3 Авлигатай тэмцэх чиглэл

*Шүүх болон сонсох ажиллагааны талаар:*

2019 оны аймгийн аудитын газраас хийсэн нийцлийн аудитад орсон газруудад захиргааны ерөнхий хуулийн дагуу Сонсох ажилагааг энэ онд 17 иргэн, хуулийн этгээдэд дахин хийсэн. Аймгийн засаг даргаар хүчингүй болгосон захирамж 28-ийг гаргасан. Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан 14 хэргээс бүгд хариуцагчийн талд шийдвэрлэгдсэн. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан 11 хэрэг байна. Үүнээс нэхэмжлэгчийн талд 2 хэрэг шийдэгдсэн бөгөөд дээд шатны шүүхэд гомдол гаргахаар ажиллаж байна. 2 хэрэг дээр эвлэрсэн буюу хариуцагчийн талд гарсан 7 хэргийн шүүх хурал болоогүй байна.

*АТГ-төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар*

Жил бүрийн 12 дугаар сарын 09-ний өдөр тохиодог Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан 10-н албан хаагчидад “Би авлига авахгүй би авлига өгөхгүй” сэдвийн дор Газрын удирдлагын хэлтсийн дарга Г.Нямдорж сургалт зохион байгуулж, иргэдэд зориулан


ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

БИДНИЙ ТУХАЙ | МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ | ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ | ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ | ИЛ ТОД БАЙДАЛ | ХОЛБОО БАРИХ

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭЛЭЛ

| № | Үйл ажиллагааны нэр | Файлыг татах холбоос |
|---|---|---|
| 1 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын ашиг сонирхлын зөрчлөөс урьчилан сэргийлэх ёс зүйн дүрэм | Файлыг татах |
| 2 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2017 оны Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө | Файлыг татах |
| 3 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2017 оны Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт | Файлыг татах |
| 4 | 2017 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт | Файлыг татах |
| 5 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2018 оны Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө | Файлыг татах |
| 6 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2018 оны Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт | Файлыг татах |
| 7 | Авлигатай тэмцэх газрын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 1/3753 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт | Файлыг татах |

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
ТУХАЙН ЖИЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
ШИЛЭН ДАНС
САНХҮҮГИЙН МЭДЭЭ
ХҮНИЙ НӨӨЦ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
Secure Connection Failed
An error occurred during a
E-DARKHAN

авлигатай тэмцэх газрын радио шторкийг ашиглан 1.57 минутын видео болгон зурагжуулж цахим хуудас /darkhan.gazar.gov.mn/ болон өөрийн пэйс /Дархан-Уул аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар/ группдээ байршуулж танилцууллаа. Нийт 28 хүн үзсэн байна. Мөн байгууллагын цахим хуудас /darkhan.gazar.gov.mn/ хуудсанд АТГ-ын бэлдсэн бүх радио шторкуудыг оруулж ажиллаа.

2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргаар батлуулсан. 8 зорилт, 45 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна. Аймгийн Залуучууд театрын их танхимд Авлигатай тэмцэх газраас иргэд, аж ахуй нэгж байгууллагад зориулан зохион байгуулсан сургалтын талаарх мэдээ мэдээллийг байгууллагын фэйсбүүк цахим хуудсаар түгээж, үйл ажиллагааг нь дэмжиж, нэгдэн орж ажилласан. Анх төрийн албанд ажилд орж буй албан хаагчдад зориулсан цахим сургалтад 8 албан хаагчийг хамруулсан. Аймгийн Залуучууд театрт 2022/04/29-нд төрийн 11 байгууллагуудад зориулан Авлига, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийн нээлтэд байгууллагын нийт албан хаагчид оролцлоо. Эхний хагас жилийн байдлаар АТГ-аас сургалтын төлөвлөгөөний дагуу 2022.02.22-нд удирдлагуудад зориулсан цахим сургалтад хэлтсийн дарга, ахлах, хүний нөөцүүд хамрагдсан, дараа өдөр нь 23-нд “zoom”-р зохион байгуулагдсан давтан сургалтад нийт 12 албан хаагчдыг хамруулсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 4 албан хаагчдын 2021 оны ХАСХОМ-ийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХЭЗХэлтэст 2022.02.21-ний өдрийн №81 албан тоотоор хүргүүлсэн. ЭБАТ-наар томилогдсон Б.Золбаясахын нэмэгдэлд өөрчлөлт оруулах газрын даргын Б/09 тушаалыг гаргаж аймгийн ЗДТГ-ын ХЭЗХэлтэст хүргүүллээ. Байгууллагын удирдах, ахлах, ЭБАТ хариуцсан 4 албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө гаргуулж, https://meduuleg.iaac.mn/AOS/Login сайтад баталгаажуулсан. Газрын дарга, Ерөнхий архитекторын үүрэгт ажлыг түр орлон гүйцэтгэж буй Х.Олонбаярыг мэдүүлгийг Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХэлтсээс хянаж оруулсан.

1-р сард 7, 2-р сард 15, 3-р сард 7, 4-р сард 6, 5-р сард 7, 8-р сард 6, 9-р сард 7, 10-р сард 7, 12 сард 7 нийт 10 удаагийн 69 албан хаагчдын Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч https://meduuleg.iaac.mn/AOS/Login сайтад оруулж бүртгэсэн. Нэг албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй тул мэдэгдлийг бөглүүлж сайтад бүрэн оруулаа. Аймгийн ХЗХ болон АТГ-ын хамтарсан шалгалтыг журамын дагуу бүртгэлийг шалгуулж зөрчил гаргаагүй болно.

*Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар*

1. УИХ-ын 2020 /04/29-ний 02-р тогтоол “Төрийн үйлчилгээг цахимд шилжүүлэх” чиглэл
2. МУЗГ-ын 2022 оны 192-р тогтоолын дагуу Газрын даргын Б/12 тушаалаар ТҮ ангилалд ажиллаж буй 6 албан хаагчдын цалингийн санд өөрчлөлт оруулж, хүний нөөцийн мэдээллийн санд бүртгэсэн.
3.ТАЗ-ийн 2021/01/03-ны Мэдэгдэл, 2021/02/23-ны 01/530 “Хууль хэрэгжүүлэх тухай” БХБЯамны 2021/05/25-ны 3/1978 Зөвлөмж, тайлан Захиргаа удирдлага-5, Газрын удирдлагын хэлтэст-25, Барилга хот байгуулалтын хэлтэст-9 нийт 39 чиглэл, болон зөвлөмжийг хэрэгжүүлж, хяналтад авсан. ГЗБГЗЗГ-ын дарга, Аймгийн Засаг даргын 01 албан даалгаваруудын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр 95%-тай биелүүлж ажилласан

2022 оны бүтэн жилийн байдлаар Газрын даргын 61 тушаалын төслийг боловсруулж, хянаж батлуулсан. А-тушаалын тоо 34, Б-тушаалын тоо 27 гаргасан байна. 2022 оны 05 дугаар сарын 30 өдрийн А/15 тоот даргын тушаалаар баталлаа. Хөдөлмөрийн

дотоод журмыг шинэчлэн төслийг албан хаагчдад танилцуулж, саналыг авч ажилласан. Газрын даргын 2022 оны газрын даргын А/15 тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. мөн 0-10 насны хүүхэдтэй албан хаагчдыг хүүхдээ өглөө, орой авхад 30 минутын чөлөө олгох тухай шинэ заалт оруулж батлуулсан. 2022 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Газрын дарга Д.Батчулуун, Аймгийн Засаг дарга Б.Азжаргал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай нараар батлуулсан. Нийт 51 зорилт, 118 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна.

Төрийн захиргааны албан хаагчийн 16 гүйцэтгэлийн төлөвлөгөө, 4 хөдөлмөрийн гэрээг шинэчлэн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгжийн даргаар батлуулж, нийт албан хаагчдын эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг байгууллагын ХШҮ Багаас үнэлсэн. Сар бүрийн ажлын төлөвлөгөөний дагуу 4 сумын даамлаас газрын харилцаатай холбоотой мэдээ, тайланг тогтмол авч нэгтэн аймгийн ХБТХОХэлтэст хүргүүлж ажиллалаа. Байгууллагын ХШҮ Баг болон ГУХэлтсээс 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг эхний хагас жилийн ажлыг эрчимжүүлж шахан хэрэгжилтийг хангуулж ажилласан. аймгийн болон ГЗБГЗЗГ-ийн даргын албан даалгаваруудын хэрэгжилтийг ханган ажилласан.
2022 оны Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан. Үүнд: 1-р зорилт, 3 арга хэмжээний хэрэгжилт 100%, 2-р зорилт, 20 арга хэмжээний хэрэгжилт 30 %, 3-р зорилт 3 арга хэмжээний хэрэгжилт 100%, 4-р зорилт, 10 арга хэмжээний хэрэгжилт 40%.
Хагас жилээр Нийт 4 зорилт, 35 арга хэмжээний хэрэгжилт 65%

ТАЗөвлөлийн 7, 4, 10 дугаар саруудад зохион байгуулсан цахим сургалтад хагас жилийн байдлаар 18 удаа 7 хоног бүр хамт олноор цахимаар оролцсон. “Төрийн захиргааы удирдлага ба гүйцэтгэлийн төлөвлөлт” сэдвээр ГУХ-ийн дарга Г.Нямдорж, ЗХАХМэргэжилтэн Б.Золбаясах нар 2022/04/20-21-ний өдрүүдэд Удирдлагын академид 16 цагийн багц сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. Мөн мэргэжилтэн Ү.Оюундарь удирдлагын академийн төрийн албан хаагчийн сургалтанд хамрагдсан. 2022 оны 05 дугаар сарын 30 өдрийн А/14 дүгээр тоот тушаалын 1 дугаар хавсралтаар газрын даргаар батлуулсан.. 2022 оны 05 дугаар сарын 30 өдрийн А/14 дүгээр тоот тушаалын 1 дугаар хавсралтаар газрын даргаар батлуулсан. 4 зорилт 33 арга хэмжээг төлөвлөн 100% хэрэгжүүлсэн.

2022 оны 1 сарын 01-ний өдрөөс 12 сарын 12-ны өдрийн хооронд абле программд нийт 1305 албан бичиг /хариутай 1015/, 340 өргөдөл /хариутай 288/ ирсэнээс 788 албан бичиг, 257 өргөдөл шийдвэрлэн, 227 албан бичиг, 31 өргөдөл хяналтанд бүртгэжээ. ГХБХБГ-аас 2021 оны 1 сарын 01-ний өдрөөс 12 сарын 12-ны өдрийн хооронд нийт 860 албан бичиг явуулж, 61 ширхэг даргын тушаал батлагдсан байна.

Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг 1-р улиралд аймгийн ЗДТГ-н ТЗУХ-т 2022.03.23-ны өдрийн 152 албан бичгээр хүргүүлсэн. 2022.10.07-ны №651 албан бичгээр 3-р улирлын мэдээг хүргүүлсэн. 2022.12.16-нд өдөр 4-р улирлын мэдээг хүргүүлсэн. Мөн сар тутмын мэдээг байгууллагын тайланд нэгтгэж нийтэд ил тод нээлттэй хүргэж байна.

## ХОЁР. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

### *2.1.1.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт*

| ЗАЛУУС ХОРООЛЛЫН ДЭД БҮТЦЫН АЖИЛ | | |
|---|---|---|
| **№** | **ЗАЛУУС-1 ХОРООЛОЛ** | **САНХҮҮЖИЛТ** |
| 1 | Залуус-1 хорооллын цэвэр, бохир усны шугамын ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 4,071,000,000₮ |
| 2 | "Залуус-1" орон сууцны төслийг дулааны эх үүсвэрээр хангах шинэ дулааны станцын барилга байгууламж, шугам сүлжээний ажлын зураг төсөл | 500,000,000 ₮ |
| 3 | Залуус-1 хорооллын бохир усны насос станц барих ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 450,000,000 ₮ |
| 4 | Залуус-1 хорооллын дулаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 14,502,000,000₮ |
| 5 | Залуус-1 хорооллын ус дулаан дамжуулах төв барих ажил 10 ширхэг /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 5,997,000,000 ₮ |
| 6 | Залуус-1 хорооллын цахилгаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 2,099,700,000 ₮ |
| | **ЗАЛУУС-2 ХОРООЛОЛ** | |
| 7 | Залуус-1,2 хорооллын холбоо дохиоллын ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 1,011,400,000 ₮ |
| 8 | Залуус-2 хорооллын дулаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 6,282,000,000 ₮ |
| 9 | Залуус-2 хорооллын ус дулаан дамжуулах төв барих ажил 3 ширхэг /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 1,799,000,000 ₮ |
| 10 | Залуус-2 хорооллын цахилгаан хангамжийн ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 8,654,400,000 ₮ |
| 11 | Залуус-2 хорооллын цэвэр усны усан сан 500м3 барих ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 250,000,000 ₮ |
| 12 | Залуус-2 хорооллын цэвэр, бохир усны шугамын ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/ | 2,410,700,000 ₮ |
| **Нийт санхүүжилт** | | **47,080,750,000** |

Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар 2, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар 2, үйлдвэрийн цогцолборын ажлын даалгаврыг хянаж баталгаажууоан боловсхуулав. Үүнд.

- Орхон, Хонгор сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар
- Дархан сумын 15-р багт баригдах Залуус1, 2 хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний даалгавар
- Хонгор сум 1-р багт баригдах Дархан арьс ширний цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний даалгавар

*Дархан сум 15-р баг “Залуус-1 хороолол”*



Улсын болон орон нутгийн төсвийн 120,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 25 байршилд 75,5 км авто замыг Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шинээр баригдсан.




Архитектур төлөвлөлтийн даалгавар 45 –ыг цахимаар 34 уламжлалт байдлаар боловсруулж БХБХ-н дарга болон аймгийн ерөнхий архитекторт хянуулан хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Үүнээс Дархан суманд дуудлага худалдаагаар олгогдох 5 нэгж талбар, Шарын гол суманд дуудлага худалдаагаар олгогдох 5 нэгж талбарын архитектур төлөвлөлтийн даалгаврыг төлөвлөсөн. АЗДТГ, ХОХБХ, ОНӨГ –уудын захиалгаар гүйцэтгэж байгаа сургууль, цэцэрлэгийн болон бусад ажлуудын архитектур төлөвлөлтийн даалгаварыг шуурхай судлан цаг тухайд нь гаргаж ажиллаа. 2022 оны 1 сарын 1 ээс барилга эхлүүлэх зөвшөөрлийг online хэлбэрээр олгодог болсны дагуу Архитектур төлөвлөлтийн даалгаврыг online хэлбэрээр гаргаж байгаа бөгөөд 57 хүсэлт ирснийг судлаж 45 Иргэн, ААН-н архитектур төлөвлөлтийн даалгавар гарсан байна.



БАТЛАВ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР ............ /Х.ОЛОНБАЯР/

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

Дугаар № АТД-45-23/21

2021 оны 03 сарын 19-ны өдөр Дархан

| | |
|---|---|
| Үндэслэл | "Минжпроперти" ХХК-н 2021 оны 3-р сарын 4-ны өдрийн 21/167 албан тоот Барилгын ажил эхлүүлэх хүсэлт |
| 1. Барилга байгууламжийн байршил тогтоосон газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ | Дархан Уул аймгийн Дархан сум Аймгийн Засаг даргын захирамж- н 2019/03/12- нд 04501-01-А/79/2019 тоот захирамжаар Дархан сумын 14-р багт 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц- ний зориулалтаар 6628 м2 газрыг газар эзэмшигч Минжпроперти ХХК Ганболд 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн. |
| 2. Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал | Орон сууц |
| 3. Барилгажих талбай / төлөвлөлтийн талбайгаар/ | 35.6 x 12.5 хэмжээтэй хотхонд төлөвлөгдсөн 10 давхар орон сууц |
| 4. Барилгын төрөл, давхрын тоо | 10 давхар |
| 5. Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө | Дархан хотын ерөнхий төлөвлөгөө<br>Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө |
| 6. Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл | Ерөнхий төлөвлөгөөний өмнөд бүс |
| 7. Эдэлбэр газар | 6628 |
| Үүнээс -Барилгажих талбай | 4639-с Хотхонд төлөвлөгдсөн барилга |
| - Ногоон байгууламж, зам талбай | 1989 |
| -Авто зогсоол | Эзэмшил газрын 30%-аас дээш |
| 8. Барилгажилтын улаан шугамын зай | - Хороолол доторх авто замаас 6 метрээс багагүй зайд төлөвлөх<br>- Барилга хоорондын зай, шугаман байгууламжын тусгаарлах зурвасуудыг норм дүрмийн дагуу төлөвлөх.<br>- Барилга угсралтын ажил эхлүүлэхийн өмнө барилгын улаан шугамыг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар тавиулж ГХБХБГазраар хянуулсны дараа газар шорооны ажлыг эхлүүлэх. |
| 9. Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага | - Орчны барилга байгууламжуудтай уялдуулж төлөвлөх.<br>- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж шинээр төлөвлөгдсөн хотын авто замын сүлжээнд холбогдохоор төлөвлөлтийн шийдлийг боловсруулах.<br>- Олгогдсон газарт ИШС байрлаж байгаа тохиолдолд түүний тусгаарлах зурваст барилга байгууламж төлөвлөхгүй байх.<br>- Галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой зай |

ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ



| | |
|---|---|
| | хэмжээ, норм дүрмийг төлөвлөлтөд баримтлах. |
| 10. Талбайн өндөржилтөд тавигдах шаардлага | Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгуудтай уялдуулж талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх. |
| 11. Архитектур төлөвлөлтийн шаардлага | - Газар хөдлөлтийн 7-8 баллын бүсэд хамааргдана.<br>Архитектур төлөвлөлтөнд онцгой анхаарч, барилга хоорондын зай, барилгын фасад, архитектурын шийдлийг хажуугийн барилгууд болон орчинтой зохицуулан, тухайн орчны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийж батлуулан, төлөвлөлтийг уялдуулан гүйцэтгэх<br>Тухайн орчны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийж батлуулан, төлөвлөлтийг уялдуулан гүйцэтгэх.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц гарц, тээврийн хэрэгслийн зогсоол төлөвлөх. |
| 12. Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага | Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдохоор өгөгдсөн техникийн нөхцөлийн шаардлагыг хангах. |
| 13. Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ) | - Барилга угсралт, газар шорооны ажлын үед ил далд үерийн суваг, гадаргуугийн усны урсацыг хааж шороо овоолох, барилгын материал хураахыг хориглоно.<br>- Талбайн зохион байгуулалтын төсөл болон ажил гүйцэтгэх төслийг хийж батлуулах. |
| 14. Захиалагчийн нэр, хаяг, утас | Хуулийн этгээдийн оноосон нэр: Минж Проперти ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 4259068, Холбоо барих утас: 99025200, Цахим шуудан: buya223@yahoo.com, Хаяг: Дархан Уул аймаг Дархан сум 2-р хороолол 14-р баг 46-р байр 1 давхар |
| 15. Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл | -Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх.<br>- Тухайн газарт эрүүл ахуйн улсын байцаагчийн шаардлагатай дүгнэлт гаргуулах.<br>- Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэж ажлын зураг хийхэд хөрсний бүтцээс хамаарсан, хөрсний шилжилтийг тооцож газар шорооны ажил эхлэх, газар доорхи болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр ажлын зургийг боловсруулан батлуулж газар шорооны ажил эхлэх.<br>- Гадна тохижилт, зам талбайд гэрэлтүүлэг хийж тохижуулах, зөвшөөрөлгүй хашаа хайс барьж архитектур, хот байгуулалтын орон зайг алдагдуулахыг хориглох ба авто зам болон явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар төлөвлөлтийг боловсруулах.<br>- Төлөвлөлтийг ОБГазартай зөвшилцөх |

Онцгой нөхцөлд:

1. Барилга барих явцад хуралдан буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндөгдвөл нөхөн сэргээх.

2. Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.

ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЦАХИМ СИСТЕМ

Зураг төслийн хүрээнд Иргэн, ААН-н загвар зураг /эскиз зураг/ 33-г судлаж Ерөнхий архитектор болон БХБХ-н хэлтэсийн даргад хянуулан шийдвэрлэж баталгаажуулллаа.

### *2.1.2.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан*

✓ Агентлаг, Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд болон бусад тайлангуудад хамрагдах өөрийн мэдээллийг боловсруулж цаг тухайд нь гаргаж өгөв.

✓ Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд оруулах хязгаарлагдмал хэрэгцээ, тусгай хэрэгцээ, нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийн судалгаа, дурсгалын хөшөө, баримал, усан оргилуур, төв автозамын мэдээллийг Хот байгуулалтын кадастрын хэлтэст хүргүүлж Дархан-Уул аймгийн Дархан сумын томоохон ногоон байгууламж, дурсгалын хөшөө, баримал, усан оргилуурын мэдээллийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд оруулав.

| № | Сумдын нэр | Барилга байгууламж | Ногоон байгууламж | | Хөшөө баримал |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэгж талбар | Талбайн хэмжээ /$м^2$/ | |
| 1 | Дархан сум | 801 | 376 | 778512 | 20 |
| 2 | Шарын гол сум | 63 | 109 | 22827 | 5 |
| 3 | Хонгор сум | 37 | 78 | 24761 | 3 |
| 4 | Орхон сум | 21 | 34 | 9758 | 5 |
| | Нийт | 922 | 597 | 835858 | |

Автозамын байршлыг маягтын дагуу бүртгэж хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн хариуцсан мэргэжилтэн хүргүүлж цахим системд оруулсан.

Дархан-Уул аймгийн хэмжээнд ногоон байгууламж, хөшөө дурсгал, усан оргилуур, төв автозамын мэдээллийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн цахим сайтад 87% тай оруулсан.

*Хот байгуулалтын кадастрын мэдээллийн цахим системд*
*Ногоон байгууламж*





*Хот байгуулалтын кадастрын мэдээллийн цахим системд*
*Зам талбай, гэрэлтүүлэг*



*Хот байгуулалтын кадастрын мэдээллийн цахим системд*
*Барилга байгууламж*



- ✓ Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд дутуу бүртгэл оруулсан барилга байгууламжийн мэдээлэл нөхөн оруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.
- ✓ Газрын удирдлагын хурлаар Иргэн, ААН-н хүсэлтээр зориулалт өөрчлүүлэх, кадастрт өөрчлөлт оруулах асуудлыг Аймгийн ерөнхий архитекторт хянуулан танилцуулж хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэв.
- Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд газрын нөхөөн сэргээлт мод тарих Иргэн, ААН-н газрын байршлыг тодорхойлж газрыг гэрээнд ашиглуулахаар 250 га газрыг хуваарилан зураг хавсаргаж ажилласан.







### *2.1.3.Барилга байгууламжийн ашиглалтад оруулахкомиссыг зохион байгуулсан*

Засгийн газрын 2011 оны 212-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын  2021 оны 01-А/313 тоот томилогдсон захирамжийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн 33 барилгад ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- “Дархан өргөө” политехникийн коллежийн 2 давхар, 24*18 хэмжээтэй өргөтгөлийн барилга
- “Сая сая болор” ХХК-ний 6кВ-ын гадна цахилгааны агаарын шугам 100кВА чадалтай АТП дэд станцын цахилгаан хангамжийн усгралтын ажил





- Дархан-Уул аймаг Хонгор сум Зулзагын голын амралтын бүсэд иргэн Б.Банзрагчийн 6/04кВ дэд станц 63кВА чадалтай

- "Бурхант эко асфальт" ХХК 6кВ цахилгааны агаарын шугам, 630кВА цахилгааны дэд станцын угсралтын ажил
- Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай эмнэлэгийн тоног төхөөрөмж, их засварын ажил






- "Газар буудай" ХХК-ний оффис, үйлчилгээний барилга



- Улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2200 хүний суудалтай спорт цогцолборын гадна цахилгааны шугамын ажил





- Хонгор сумын нутаг дэвсгэрт баригдсан 111 ширхэг гадна гэрэлтүүлэг барилга

- Дархан сум, 13-р баг, Эрд хул ХХК -ийн газрын тосоы агуулахын гадна цахилгаан хангамж
- 2200 хүний суудалтай спорт цогцолборын гадна цахилгааны шугамын барилга




- Иргэн Ц.Даландэлгэрийн үйлчилгээний зориулалттай зоорьтой, 5 давхар үйлчилгээний барилга





- “Газ ойл нефть” ХХК-ний Олон төрөлт түлш түгээх станц барилга




- “Баян бридж” ХХК-ний үйлчилгээтэй 54 айлын орон сууцны барилга





- Орхон сум, 1-р багийн нутаг дэвсгэрт баригдсан 9-р цэцэрлэгийн өргөтгөлийн 15*17м хэмжээтэй барилга




- Дархан сум, 3-р баг, “Херо хүдэр” ХХК-ний төмрийн хүдэр нойтон баяжуулах үйлдвэр





Дархан сумын 1,4,7,12,16-р багуудад Япон улсын буцалтгүй тусламжаар хийгдсэн 9206-МОН төслийн 5 ширхэг контейнер тохижуулж суурилуулалтын ажил




Дархан сум, 31-р хорооллын гадна цэвэр ус, бохир, цахилгаан хашаажуулалтыг ажил




Хуучин дарханы спорт ордон




Мал бүхий иргэдийн суурьшлийн бүсийн гадна цахилгаан ажил





Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн дэлгэрэнгүй судалгаа / 2022.12.12 /

| **№** | **Барилга байгууламжийн нэр** | **Зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт** | **Барилгын ажлын захиалагч, хөрөнгө оруулагчийн мэдээлэл** | **Барилгын зураг төсөл зохиогчийн мэдээлэл** | **Барилгын ажил гүйцэтгэгчийн мэдээлэл** |
|---|---|---|---|---|---|
| | | **Дүгнэлтийн огноо** | **Нэр** | **Нэр** | **Нэр** |
| | 2 | 29 | 32 | 35 | 40 |
| 1 | Сая сая болор ХХК-ний 6кВ-ын гадна цахилгааны агаарын шугам 100кВА чадалтай АТП дэд станцын цахилгаан хангамжийн усгралтын ажил | 2021.09.03 | Сая сая болор ХХК | Ажнай буянт ХХК | Цац эрчис ХХК |
| 2 | Дархан-Уул аймаг Хонгор сум Зулзагын голын амралтын бүсэд иргэн Б.Банзрагчийн 6/04кВ дэд станц 63кВА чадалтай | 2021.11.15 | Б.Банзрагч | Ариун мөнх гэрэл ХХК | Цац эрчис ХХК |
| 3 | Бурхант эко асфальт ХХК 6кВ цахилгааны агаарын шугам, 630кВА цахилгааны дэд | 2021.07.26 | Бурхант эко асфальт ХХК | Ариун мөнх гэрэл ХХК | Цац эрчис ХХК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | станцын угсралтын ажил | | | | |
| 4 | Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай эмнэлэгийн тоног төхөөрөмж, их засварын барилга | | “Эрүүл мэндийн яам” | “Балданс” ХХК | “Эйч Ар Ви Констракшн” ХХК |
| 5 | “Газар буудай” ХХК-ний 15*21, 12*18 хэмжээтэй оффис, үйлчилгээний барилга | 2020.06.03 | Газар буудай ХХК | Конар ХХК | “Кидан констракшн” ХХК |
| 6 | Хонгор сумын нутаг дэвсгэрт баригдсан 111 ширхэг гадна гэрэлтүүлэг барилга | 2020.12.01 | БХБЯ | “Ялгуун баян” ХХК | “Магнус сентурион констракшн” ХХК |
| 7 | 2200 хүний суудалтай спорт цогцолборын гадна цахилгааны шугамын барилга | 2019.04.17 | Биеийн тамир, спортын улсын хороо | Барилга байгууламж ХХК | Дархан хэрлэн ХХК |
| 8 | Дархан сум, 13-р баг, Эрд хул ХХК -ийн газрын тосноы агуулахын гадна цахилгаан хангамж | 2021.12.06 | Эрд хул ХХК | Монцахир ХХК | Ноён сайхан ХХК |
| 9 | Иргэн Ц.Даландэлгэрийн үйлчилгээний зориулалттай зоорьтой, 5 давхар үйлчилгээний барилга | 2016.11.07 | Иргэн Ц.Даландэлгэр | Итгэлт өргөө ХХК | Хүслийн цамхаг ХХК |
| 10 | Дархан-Уул аймаг Хонгор сум 35кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/6кВ -ын 1600кВА хүчин чадалтай дэд станц | | ДСЦТС ХК | ДСЦТС ХК | ДСЦТС ХК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | “Газ ойл нефть” ХХК-ний Олон төрөлт түлш түгээх станц барилга | 2022.02.15 | “Газ ойл нефть” ХХК | “Жи Ти инженеринг” ХХК | “Өү Эйч Ди инженеринг” ХХК |
| 12 | Баян бридж” ХХК-ний үйлчилгээтэй 54 айлын 23 машины дулаан зогсоол, агуулахтай барилга | 2020.07.08 | “Баян Бридж” ХХК | “Баян төхөм шандат” ХХК | “Баян Бридж” ХХК |
| 13 | “Сигма Эс” ХХК-ний 25 айлын 9 машины дулаан зогсоол, 2 агуулахтай барилга | 2021.05.28 | Сигма-Эс ХХК | Автокад ХХК | Сигма-Эс ХХК |
| 14 | “Дархан төгөлдөр” ХХК-ний 1 цагт 60м3 хүчин чадалтай бетон зуурмагны узелийн барилга | 2022.03.13 | “Дархан төгөлдөр” ХХК | “Баян төхөм шандат” ХХК | “Мандала резиденс” ХХК |
| 15 | “Хэрлэн зураглал” ХХК-ний 2 орцтой, 108 айлын зоорьтой 9 давхар, 18 автомашины дулаан зогсоолтой нийтийн орон сууцны барилга | 2019.08.22 | Хэрлэн зураглал хХК | “Баян төхөм шандат” ХХК | Хэрлэн зураглал хХК |
| 16 | "Өгөөж гурил" ХХК-ний 2 орцтой, 79 айлын зоорьтой 9 давхар, 8 автомашины дулаан зогсоолтой нийтийн орон сууц | 2017.01.17 | Өгөөж гурил ХХК | Карказ зураг ХХК | Гэрэлт гартаам ХХК |
| 17 | Орхон сум, 1-р багийн нутаг дэвсгэрт баригдсан 9-р цэцэрлэгийн өргөтгөлийн 15*17м хэмжээтэй барилга | 2021.04.12 | Дархан-Уул аймгийн ЗДТГ | Автокад ХХК | Дархан трейд ХХК |
| 18 | Аргал ойл ХХК 25х4=100м3 багтаамжтай | 2019.10.07 | Аргал ойл ХХК | ММ архитектур ХХК | Юнайтэд бэст инженеринг ХХК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шатахуун түгээх станц | | | | |
| 19 | 31-р хорооллын гадна ИШС | 2020.05.19 | Захирагчийн ажлын алба | “Хэрлэн зураглал” ХХК | “Дархан ус суваг” ХК |
| 20 | “Монрок” ХХК-ний 6кВ-ны ЦДАШ, 6/0,04 кВ 400 кВа, 100 кВа дэд өртөөний барилга | 2022.05.11 | “Монрок” ХХК | Ариун мөнх гэрэл ХХК | Дархан хэрлэн ХХК |
| 21 | Хонгор сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн 13м*23м хэмжээтэй барилга | | Дархан-Уул аймгийн ЗДТГ | Автокад ХХК | Өсөх буянт тулга ХХК |
| 22 | “Баян бридж” ХХК-ний 17 дулаан машины зогсоолтой 108 айлын нийтийн орон сууцны барилга | 2021.06.11 | “Баян Бридж” ХХК | “Баян төхөм шандат” ХХК | “Баян Бридж” ХХК |
| 23 | “Эм жи эл туннель системс” ХХК-ний 25.5м x 17.8м хэмжээтэй, 9 машины дулаан зогсоолтой, 42 айлын нийтийн орон сууцны барилга | 2015.03.11 | “Эм жи эл туннель системс” ХХК | Ноёпдын туурь ХХК | “Чонот девелопмент” ХХК |
| 24 | “Херо хүдэр” ХХК-ний 24м*36м хэмжээтэй нойтон баяжуулах үйлдвэрийн барилга | - | “Херо хүдэр” ХХК | “Идеал групп” ХХК | “Цамхагт Ундраа” ХХК |
| 25 | Дархан сум, 13-р баг, дулааны худаг ТК80-ТК94 худгийн хоорондох дулааны шугамын шинэчлэлтийн ажил | 2021.01.10 | Дархан-Уул аймгийн ЗДТГ | ЗТК ХХК | Цагаан зуун ХХК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 26 | Малтай иргэдийг суурьшуулах шинэ суурьшлийн бүсийн 0,4кВ, 6кВ-ын агаарын шугам, 250 кВа дэд өртөөний гадна цахилгаан хангамжийн ажлын барилга | 2021.12.10 | Дархан-Уул аймгийн ЗДТГ | Ариун мөнх гэрэл ХХК | Дархан хэрлэн ХХК |
| 27 | Аюултай хог хаягдлын 15м х 21м хэмжээтэй зоорьгүй нэг давхар агуулахын барилга | 2020.07.01 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | “ХБХДТ” ХХК | “Брэнд шилдэг” ХХК |
| 28 | Тосгон чиглэлийн гадна дулааны шугам, 480 хүүхдийн сургуулийн барилгын гадна дулааны хангамжийн барилга | 2020.06.17 | Дархан-Уул аймгийн ЗДТГ | “Инж байгууламж” ХХК | “Өгөөмөр баян булаг” ХХК |
| 29 | Хүслийн хотхоны 33м х 16м хэмжээтэй, 12 давхар, 14 машины дулаан зогсоолтой, 108 айлын нийтийн орон сууцны барилга | 2021.09.14 | “Миракллэнд” ХХК | “Дотлайн” ХХК | “Гантиг Өргөө” ХХК |
| 30 | “Минж проперти” ХХК-ний Парк таун-2 хотхоны 8-р ээлжийн Л блокын 2 орцтой, 10 давхар, 16 машины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 60 айлын нийтийн орон сууцны | 2021.09.01 | Минж Проперти ХХК | “Ди Ти Би” ХХК | Хүслийн цамхаг ХХК |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 31 | 480 хүүхдийн сургуулийн барилга А блок 29*12м-2 давхар, Б блок 25,6*9,8м-2 давхар, В блок 32*21,75 3 блок бүхий спорт заал, урлагийн заалтай | 2020.05.22 | Дархан-Уул аймгийн ЗДТГ | Автокад ХХК | Минж Проперти ХХК |
| 32 | “Цагдаагийн газрын өргөтгөл”-ийн барилга | 2021.06.28 | Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар | “Баян төхөм шандат” ХХК | Инерци ХХК |
| 33 | А блокын барилга тэнхлэгээрээ 33.4м х 30.0м хэмжээтэй, Б блок нь барилга нь тэнхлэгээрээ 26.55м х 24.0м хэмжээтэй зоорьгүй 2 давхар “Хуучин Дархан спортын ордон”-ны зориулалттай барилга | 2021.04.23 | Дархан-Уул аймгийн ЗДТГ | Автокад ХХК | “Хөшиг Уул” ХХК |
| 34 | “Барил трейд” ХХК-ний 1цагт 60м3 хүчийн чадалтай бетон зуурмагны үйлдвэрийн зориулалттай барилга | 2022.05.13 | “Очир ган бетон” ХХК | “Баян төхөм шандат” ХХК | Бурхант ган ширэм ХХК |

***Ашиглалтад орсон барилга байгууламжуудыг зориулалтаар ангилвал:***




### *2.1.4.Барилга байгууламжийг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаар:*

Засгийн газрын 2021 оны 213 дүгээр тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг **23** барилга байгууламжид олгосон. Үүнд:

- Сургууль, цэцэрлэг – 6
- Үйлдвэр, үйлчилгээ – 11
- ИШСүлжээ – 20
- Нийтийн орон сууц – 9
- ШТС – 5
- Хатуу хог хаягдал - 1
- Эмнэлэг - 1
- Спорт заал - 4
- Гэрэлтүүлэг – 4



**Дэлгэрэнгүй ангилж харвал:**

- Дархан сум, 15-р багт 960 хүүхдийн сургуулийн барилга
- Дархан-Уул аймаг, Хонгор сум, 1-р баг, Их оч ХХК-ны агуулахын барилгын 6кВ ЦДАШ, 6/0.4кВ-ын 25кВА дэд станц цахилгаан хангамж
- Дархан сум, 3, Өргөө, 7, 12, 16-р багуудад Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл
- “Баян бридж” ХХК-ний 108 айлын 2-р ээлжийн нийтийн орон сууцны барилга
- “Батур хайрхан” ХХК-ний үйлдвэрийн барилга
- Иргэн Ц.Ганбаярын 18*34 хэмжээтэй 1 давхар зоорьтой, 10 давхар нийтийн орон сууцны барилга
- Иргэн Д.Зоригтбаатарын 108-н айлын нийтийн орон сууцны барилга
- "Газ ойл нефть"" ХХК-ний Олон төрөлт түлш түгээх станцын өргөтгөл, шинэчлэлт"
- “Минж проперти” ХХК-ний Парк таун-2, М блок, үйлчилгээтэй 60 айлын орон сууцны барилга
- Өсөх урам ХХК-ний үйлчилгээний барилга
- “Очир дархан” ХХК-ний үйлчилгээтэй 54 айлын нийтийн орон сууцны барилга
- иргэн С.Ганзориг, Д.Батбаяр нарын амины орон сууцны дулааны шугам
- Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын өргөтгөлийн барилга
- Иргэн Д.Бат-Оршихын 90 айлын орон сууцны барилга
- Дархан сумын 5.6.7-р баг дулаан дамжуулах сүлжээний ТК27-ТК39 худгийн хооронд дулааны шугамын шинэчлэлтийн ажил
- “ЦЦТО” ХХК-ний 9-н давхар 54 айлын нийтийн орон сууцны барилга
- “Монбамбай” ХХК-ний 36*18 хэмжээтэй, 1 давхар зоорьтой, 6 давхар үйлчилгээтэй 45 айлын орон сууцны барилга
- "Стронгер" ХХК-ний 156 айлын нийтийн орон сууцны барилга
- Дархан сумын 13-р баг ТК-80-ТК-94 дулааны худаг хоорондох шугам шинэчлэлтийн ажил
- “Дэлгэрэх бат дэвжих” ХХК-ний худалдаа үйлчилгээний А,С блок 36.0*80.0м, В блок 120.0*40.0м хэмжээтэй цогцолбор барилга
- Дархан-Уул аймаг, Хонгор сумын "Спорт заалны барилга"
- Дархан-Уул аймаг, Хонгор сум, 2-р баг, Монрок ХХК-ны уул уурхайн кэмпний гадна цахилгааны 6кВ-ын ЦДАШ, 6/0.4кВ-ын 100кВ дэд өртөөний цахилгаан хангамжийн ажил
- Дархан-Уул аймаг, Хонгор сум 1-р баг Үерийн ус зайлуулах сувгийн багц ажил
- Дархан-Уул аймаг, Дархан сум 15-р баг Үерийн ус зайлуулах сувгийн багц ажил
- “Ган дизель ундрага” ХХК-ний авто сэлбэг, засварын газар
- Дархан төгөлдөр ХХК -ны бетон зуурмагийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн суурийн ажил
- Дархан-Уул аймаг, Хонгор сум, 2-р баг, Монрок ХХК-ны уул уурхайн гадна цахилгааны 6кВ-ын ЦДАШ, 6/0.4кВ-ын 400кВ дэд өртөөний цахилгаан хангамжийн ажил
- Дархан-Уул аймаг, Хонгор сум, 3-р багт баригдах 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга
- Дархан-Уул, Орхон сум, 1-р баг, чулуут тохой Ж.Отгонбаатар төмс хүнсний ногооны усалгаатай тариалангийн 6кВ ЦДАШ, 50кВ дэд станц
- Дархан-Уул аймаг, Орхон сум 1-р баг 37-р суваг 0 тоот иргэн К.Мягмарсүрэнгийн төмс хүнсний ногооны усалгаатай тариалан 10кВ ЦДАШ, 50кВ дэд станц

- Дархан-Уул аймаг, Хонгор сум 1-р баг иргэн Т.Наранчимэгийн цэвэр усны худгийн цахилгаан хангамжийн 6кВ ЦДАШ, 63кВ дэд станц
- Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 12*18 хэмжээтэй өргөтгөлийн барилга
- Дархан-Уул аймаг, Дархан сум 12-р баг, Батцагаан буянт ХХК-ны 30х15, 15х15, 2 блок 7 давхар эмнэлэгийн барилга
- "Цайхун" ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны өргөтгөл 40.6*20.6м хэмжээтэй.
- Дархан-Уул аймгийн Дархан сумын 1,7,8-р, Малчин багуудад хийгдэх Багц-4 гадна гэрэлтүүлэгийн ажил
- Дархан-Уул аймгийн Дархан сумын 2,3,5-р багуудад хийгдэх Багц-3 гадна гэрэлтүүлэгийн ажил
- Дархан-Уул аймгийн Орхон сум 35/10кВ-ын Жимс дэд станцын шинэчлэлт
- Дархан-Уул аймаг, Шарын гол сум, Дархан баг чиглэлийн дулааны шугамын өргөтгөл
- Дархан-Уул аймаг, Дархан сум , Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэлтийн ажил
- “Мираклլэнд” ХХК-ний “Шинэ алхам” дунд сургуулийн спорт заалны өргөтгөлийн А блокын 42м*22,5м хэмжээтэй барилга
- “Мираклլэнд” ХХК-ний “Шинэ алхам” дунд сургуулийн өргөтгөлийн Б блокын 40м*22,5м хэмжээтэй усан бассейн 3 давхар барилга
- “320 хүүхдийн сургуулийн барилга” 70,95м*31,75м хэмжээтэй 2 давхар П хэлбэртэй барилга
- 7-р цэцэрлэгийн өргөтгөлийн 45м*21м хэмжээтэй 100 хүүхдийн 2 давхар цэцэрлэгийн барилга
- “Ти эм ойл” ХХК-ний шатахуун түгээх станцын 120м3 хүчин чадалтай барилга
- Дархан-Уул аймаг, Хонгор сум 1-р баг иргэн С.Энхтүвшингийн үйлдвэр, үйлчилгээний газрын 6кВ ЦДАШ, 100кВ дэд станц
- “Их Идрүүн” ХХК-ний үйлчилгээний 19,3м * 18,5м хэмжээтэй зоорьтой 9-н давхар үйлчилгээний барилга
- “Ногоо боловсруулах, савлах цехийн барилга” 20*18 хэмжээтэй зоорьгүй нэг давхар барилга
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн өргөтгөл “Спорт заалны барилга”
- “Мон суль” ХХК-ний Шатахуун түгээх станцын барилга
- Дархан-Уул аймаг, хонгор сумын төвийн цэвэрлэх байгууламжийн засвар шинэчлэлтийн ажил
- “Шунхлай петролиум” ХХК-ний шатахуун түгээх станцын барилга
- “Номин реалтор” ХХК-ний 36м х 60м хэмжээтэй зоорьгүй 2 давхар үйлчилгээний барилга
- Дархан-Уул аймаг Дархан сум 15-р баг хабитат, мангирт чиглэлийн 2 дугаар контурын ажил
- Дархан сум 15-р баг үерийн ус зайлуулах сувгийн ажил Багц 2
- Дархан сум 6.15-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх хотын гэрэлтүүлэг Багц 2
- “Ногоо боловсруулах, савлах цехийн барилга” 20*18 хэмжээтэй зоорьгүй нэг давхар барилга
- Мэдээлэл холбооны “Дархан дэд төв”-ийн 45.0м х 15.0м, 30.0м х 15.0м хэмжээтэй 2 блок, Г хэлбэртэй, Зоорийн давхаргүй 2 давхар, техникийн давхартай
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 6-р баг Монсуль ХХК ШТС-ын 6кВ-ын ЦДАШ, 6/04-ын 50кВа дэд станцын цахилгаан хангамж
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг Монсуль ХХК ШТС-ын 6кВ-ын ЦДАШ, 6/04-ын 50кВа дэд станцын цахилгаан хангамж
- “Ти эм ойл” ХХК-ний шатахуун түгээх станцын 120м3 хүчин чадалтай барилга

- Дархан сумын 13 баг, 15-р багт нийт 1171 гэрэлтүүлэг
- Дархан тойрог схем”-ийн 110кВ-ын ЦДАШ, 110/35/10кВ-ын 2х16 МВА чадалтай дэд станцын барилга

**Дархан-Уул аймагт баригдаж ашиглалтад орж байгаа орон сууцны барилгын эрэлт, нийлүүлэлтийн судалгаа / 2022.12.12-ны өдрийн байдлаар /**




| | 1м2 доод үнэ | 1м2 дээд үнэ |
|---|---|---|
| 2012 он | 1.000.000 төг | 1.100.000 төг |
| 2013 он | 1.050.000 төг | 1.200.000 төг |
| 2014 он | 1.100.000 төг | 1.300.000 төг |
| 2015 он | 1.200.000 төг | 1.350.000 төг |
| 2016 он | 1.300.000 төг | 1.650.000 төг |
| 2017 он | 1.400.000 төг | 1.800.000 төг |
| 2018 он | 1.600.000 төг | 1.950.000 төг |
| 2019 он | 1.650.000 төг | 1.950.000 төг |
| 2020 он | 1.700.000 төг | 2.450.000 төг |
| 2021 он | 1.800.000 төг | 2.600.000 төг |
| 2022 он | 1.850.000 төг | 3.000.000 төг |

Дархан-Уул аймгийн хэмжээнд 12 байршилд 1314 айлын нийтийн орон сууцны барилга баригдаж байна. Шинээр баригдаж байгаа орон сууцны 1м2 үнэ 1.850.000-3.000.000 төгрөгний хооронд борлуулагдаж байна.
Мөн 2022 оны 12-р сарын байдлаар 8 байршилд 585 айлын орон сууцны барилга ашиглалтад орж борлуулагдсан байна.



### 2.1.5.Баригдаж байгаа барилга байгууламжуудад хяналт шалгалт хийсэн талаар:

Аймгийн хэмжээнд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан 63 иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид Аймгийн мэргэжлийн хяналтын газар хамтран хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилласан.






Барилга, хот байгуулалтын яамны дэд сайдаар ахлуулсан, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай хамтран Дархан Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-тэй шинээр томилогдсон удирдлагатай танилцуулан мэдээллийг солилцож ажилласан.



## 2. БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ,ЛАБОРАТОРИЙН ЧИГЛЭЛЭЭР

### *2.2.1 Барилгын материалын үйлдвэрлэлийн мэдээллийн сан баяжуулалт:*

Дархан-Уул аймаг нь барилгын материалын үйлдвэрийн бааз суурь болгохоор байгуулагдсан барилгын материалын үйлдэрлэлийн түүхий эд болох элс, төрөл бүрийн барилгын чулуулаг, төмрийн хүдэр, нүүрс, керамзит шаврын ордоор баялаг бүс нутаг юм

Аймгийн хэмжээнд барилгын материал үйлдвэрлэлийн ААНБ-уудын 2022 онд тусгай зөвшөөрлийн сунгалт болон шинээр авсан бүртгэлийг шинэчлэн гаргалаа. 2022 онд 28 ААНБ барилгын материал үйлдвэрлэл эрхэлж байна.






2022 оны Барилгын материалын үйлдвэрлэлийн төрөлжсөн судалгааг байнга баяжуулж албаны сайтаар нийтэд цахимаар мэдээлж байна.

Батлагдсан удирдамжийн дагуу үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж байгаа тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан ААНБайгууллагуудын хугацаа сунгуулах шаардлага тавих, чанар стандартын шаардлага хангасан тохирлын гэрчилгээний хугацаа сунгуулах, шинээр авах талаар мэдээлж, батлагдсан технологийн картыг цахимд бүртгэн мэдээллийн санг баяжуулсан. Тохирлын гэрчилгээ авах заавры танилцуулсан.






**Орон нутагт шинээр нэвтэрч буй техник технологийн талаар**

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021.03.31-ний өдрийн №1-10/249 тоот албан тоотын дагуу Хонгор сумын 2-р баг Шийрийн бригад орчмын шохойн орд бүхий үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгж байгууллага бүхий үйлдвэрүүд нь Төв суурин газрын агаар бохирдуулж байгаад хяналт шалгалт хийсэн. Ажлын үр дүнд шохой 2021 онд Тулгат шийр ХХК, Сутайн үхэр чулуут ХХК, Иннова ложистик ХХК-ууд нь шохойн үйлдвэрлэлд бүрэн шаталттай технологийн эргэх зуух шинээр ашиглалтанд оруулж шохойны чанарыг сайжруулан ажиллаж байна.


МОНГОЛ УЛС
ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГА

45059 Дархан, Дархан-Уул аймаг
Утас: 7037-8023, Факс: 7037-7121
И-мэйл: info@darkhan.gov.mn
Вэбсайт: www.darkhan.gov.mn

2021.03.31 № 1-10/249

танай ________ -ны № ________ -т

"ИДЭРХАЙРХАН" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.БАТСҮРЭН ТАНАА

Үйл ажиллагааг зогсоох тухай

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр баталсан "Төв суурин газар орчны агаар бохирдуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хамтарсан хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд Хонгор сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах шохойн чулуу шатаах танай байгууллагын үйл ажиллагаанд төрийн хяналт шалгалтын тухай, байгаль орчны багц хуулиудын хэрэгжилтэд дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, "Утаагүй Дархан" дэд хөтөлбөрийн хүрээнд хүрээлэн буй орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж буй ажилтай танилцаж, хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар:

1.Орчны агаарын шинжилгээгээр нийт тоос, тоосонцор, хүхэрлэг хий нь агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартаас давсан.

2.Орчны агаарын шинжилгээний үр дүнгээр гарсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг бүрэн авч ажиллаагүй нь агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтыг

3.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь заалтыг тус тус зөрчиж байгаа нь хүний амь, нас, эрүүл мэндэд ноцтой хор хохирол учруулж болох нөхцөл тогтоогдож байх тул байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шохой шатаах босоо зуухны үйл ажиллагааг бүрмөсөн зогсоох, үйл ажиллагаандаа дэвшилтэт технологи нэвтрүүлэх, агаарын бохирдуулагч эх үүсвэргүй болох

2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тавигдсан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

3.Хүн амын суурьшлын бүсэд ойр байршилтай тул агаар дахь түгээмэл бохирдлын агууламж ихсэх, агаарын чанарын MNS4585:2016 стандартаас давсан бохирдол хаясан тохиолдолд үйлдвэрлэлийн технологит тухай бүр анхаарч, тодорхой арга хэмжээ авах

4.Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт "иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй"-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй болно.

ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ZD-2021 A4 тоот
4521100171







БХБЯамны 2022.04.21-ны өдрийн №9/1923 тоот, БХТөвийн 2022.05.11-ны №281 албан тоотын дагуу Дархан-Уул аймгийн хэмжээнд барилгын салбарт ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын эрэлт, нийлүүлэлтийн 15 орд газрын судалгааг 2022.05.05-ны № 1/1042 тоотоор хүргүүлэв.

Үүнд: Их Булангын элс, Дархан толгой, Их булгийн хөндий-1, Их булгийн хөндий, Модот уул, Их Булан, Хадат, Цохиот толгой 2, Хараа 1, Шийрийн хөндийн адаг 4-р орд, Асгат уул, Ширээ нуруу, Дархан толгой гэх мэт 15 орд газрууд


ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2022.05.11 № 281

танай 2022.05.05 -ны № 1/1042 -т

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВД

Аймгийн хэмжээнд 2020 он, 2021 онд олборлосон орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгааг гаргаж хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА Д.БАТЧУЛУУН

452220000485





ГХБХБГ-ын дэргэдэх Барилгын материалын сорил шинжилгээний лаборатори байгуулахаар 2000м2 талбай бүхий газрыг шийдвэрлэгдсэн. 2021 онд тус лабораторийн барилгын нэг маягийн зураг төсөл /улсын хэмжээнд/ боловсруулагдаж 739.0 м$^2$ талбай бүхий Барилгын материалын сорил шинжилгээний лабораторийн барилгын зураг /7 баллд тооцсон/ зураг төслийн магадлалын багаар №1743/2021 тоот дүгнэлттэй батлагдсан. Бүсийн тулгуурт төвд баригдах лабораторийн нэг маягийн зураг төсөл, техникийн бичиг баримтуудыг бүрдүүлсэн.

Дулаан, цахилгаан, ус, мэдээлэл холбоо сүлжууний техникийн нөхцөлийг авч хүргүүлсэн. Мөн аймгийн ХОХӨЩБТХэлтэсийн холбогдох мэргэжилтэнээр 2023 оны төсөвт тусгуулах тооцоолол, асуумжийн хамт саналыг хүргүүлсэн.

Тус барилга нь анх батлагдахдаа 1,452,118,108.00 төгрөгийн төсөвт өртөгтэй болович барилгын материалын үнийн өсөлттэй холбоотойгоор 2.5 тэрбум төгрөгөөр төсөвлөж хүргүүлсэн. Мэргэжлийн байгууллагаас 4 техникийн нөхцөл авч хавсаргав.




/ Нэг маягийн зураг /
Барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори

Пресс, Конусын суулт шалгах, шигшүүр зэрэг Лабораторийн 3 төрлийн багажтай бөгөөд одоогийн байдлаар ГХБХБГ-ын Конторын барилгын зоорийн хэсэгт суурьлуулсан.





### *2.2.2.Тохирлын үнэлгээ*

Барилгын материалын үйлдвэрлэх эрх, технологийн зааврыг БМҮХолбоотой, бүтээгдэхүүнийг чанарын баталгаажуулалт, тохирлын үнэлгээнд хамруулахыг БХТөв ББА, БХҮНТөв, БАК, аймгийн Стандарт хэмжил зүйн газруудтай хамтран ажиллаж сертификацжуулж байна.


ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ


СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ


ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ


ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ
БАРИЛГА АРХИТЕКТУР КОРПОРАЦИ

2022 онд аймгийн хэмжээнд 11 байгууллага тохирлын гэрчилгээ сунгуулсан. Үүнд:

Барилгын материалын тохирлын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргасан ААНБ-ын хүсэлтээр 2022.05.02-ны өдөр БМҮНТөвтэй хамтран ажилласан. Үүнд бүтээгдэхүүний дээж сорил авахаас гадна үйлдвэрлэлийн байдал, тоног төхөөрөмжийн хэвийн байдал, баталгаажуулалт, ажиллагсдын тогтвор суурьшил, хөдөлмөр хамгаалал, нийгмийн баталгаа, бүтээгдэхүүний шинжилгээний баримт бичиг зэргийг нүдээр үзэн танилцаж хугацааг хэрхэн сунгах тухай шийдвэрлэх баримт бичгийг шалгав.

*Барилгын хөгжлийн төвийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын албаны батлагдсан удирдамжийн дагуу*







“**Мэжик Нью Уорлд”** ХХК-**барилгын хуванцар цонх, хаалга** үйлдвэр



БАТЛАВ:

ББА-ны дарга Д.Батням

"Идэр хайрхан" ХХК дүүргэгч материалын үйлдвэрт тохирлын үнэлгээ явуулах ажлын хэсгийн

УДИРДАМЖ № 66/22

2022.11.21 Улаанбаатар хот

1. Зорилго: Тохирлын үнэлгээг "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай" Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйл, "Бүтээгдэхүүнд тохирлын баталгаажуулалт явуулах журам"-ын дагуу гүйцэтгэж тус компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, тухайн бүтээгдэхүүн нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын талаарх холбогдох норматив техникийн баримт бичигт тогтоосон шаардлагыг бүрэн хангасан эсэхэд дүгнэлт гаргахад ажлын хэсгийн зорилго оршино.
Бүтээгдэхүүнийг баталгаажуулахад сорилтын болон үнэлгээний аргыг хэрэглэх болно.
2. Гүйцэтгэх ажил:
Удирдамжийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд;
a. Хүсэлт гаргасан байгууллагын удирдлагад үнэлгээ явуулах ажлыг хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг танилцуулах;
b. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, технологийн горимын мөрдөлтөд үзлэг хийх;
c. Тохирлын үнэлгээнд хамрагдаж буй бүтээгдэхүүн нь стандартын шаардлагад хэрхэн нийцэж буй талаар үнэлгээ хийж, шалгах хуудас хөтлөх;
d. Ажилчдын мэргэжил, дадлага туршлагын байдалтай танилцах;
e. Дээж авах түүнийг тамгажуулах, сорилт, шинжилгээнд хамруулах, дүгнэлт гаргах;
1. Мөрдөж буй стандарт, холбогдох баримт бичгийн мөрдөлтийг үзэх;
2. Холбогдох бүртгэл, журналтай танилцах;
3. Бүтээгдэхүүний чанар хангалтын талаарх үйл ажиллагаатай танилцах;
4. Хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн дунд санал асуулга явуулах;
5. Хүсэлт гаргагч байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, холбогдох бусад материалын нийцтэй байдлыг үнэлж, дүн шинжилгээ хийх;
6. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэрэгжилттэй танилцах;
7. Тохирлын үнэлгээний урьдчилсан дүнг байгууллагын удирдлага, хамт олонд танилцуулах;
8. Тохирлын үнэлгээний явц дахь бүх материалыг боловсруулж, үнэлгээний тайлан, дүгнэлт гаргаж "Баталгаажуулалтын зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулна.
Хугацаа: Хүсэлт гаргасан байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр ажиллана.
Хаана: Дархан-Уул аймаг, Хонгор сум Шарийн хандий Цохио толгой-2 орд газар

ББА-ны шинжээч Ч.Далгаан

Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын БМ хариуцсан мэргэжилтэн: Б.Мөнгөнтогос



“**Идэрхайрхан”** ХХК-ний Дархан Уул аймаг, Хонгор сум, 1-р баг, /4502007595/ 30.8 га талбай бүхий уурхайн зориулалттай газар **чулуу бутлан ангилах** үйлдвэр



2022 онд Тохирлын гэрчилгээ шинээр авсан болон сунгуулсан

| № | ААНБ нэр | | Олгосон байгууллага |
|---|---|---|---|
| *1* | *Чуань мон арматур ХХК* | *2022.05.06-1 жилээр сунгуулсан* | *Барилгын хөгжлийн төвийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын албанаас* |
| *2* | *Монкварц ХХК* | *сунгуулсан* | |
| *3* | *Межик нью уорлд ХХК* | *сунгуулсан* | |
| *4* | *Силикат ХК* | *2022.03.09-2 жилээр сунгуулсан* | *Барилга архитектур корпораци ХК-аас* |
| *5* | *Хасвуу ХХК* | *сунгуулсан* | |
| *6* | *Дархан карьер ХХК* | *2022.01.14-2 жилээр сунгуулсан* | *Барилгын хөгжлийн үндэсний нэгдсэн төв* |
| *7* | *Анто-Од ХХК* | *сунгуулсан* | |
| *8* | *Сонголон хайрхан ХХК* | *сунгуулсан* | |
| *9* | *Бурхант хясаат ХХК* | *сунгуулсан* | |
| *10* | *Эй эн ти хаус ХХК* | *сунгуулсан* | |
| *11* | *Сан оргиу ХХК* | *сунгуулсан* | |

### 2.2.3.Барилгын материалын тусгай зөвшөөрөл

Барилга, хот байгуулалтын сайдын 2018.12.31-ний өдрийн №217 тоот тушаалаар батлагдсан Хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын дагуу 2022 оны эхний хагас жилийн байдлаар барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт 1, сунгуулах хүсэлт 4 аж ахуйн нэгж байгууллагаас ирсний дагуу ажиллаа. Үйлдвэрлэлийн батлагдсан технологи заавар, зааврын дагуу тоног төхөөрөмжөө байрлуулсан эсэх, ажлын байрын нөхцөл байдал мөн үйлдвэрийн барилгын зөвшөөрөл, газар эзэмших эрхийн зориулалт, тоног төхөөрөмж суурилуулсан акт, аюулгүй ажиллагаа хангалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам, хэрэгжилт, мэргэжлийн технологич, тусгай зөвшөөрлийн суурь нөхцөлд шаардлагыг хангах эсэх, байвал зохих инженер техникийн ажилтны баримт бичиг шалгаж ажиллав. Үүнд:

Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гишүүний хамт барилгын материалын тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан ААНБ-ын хүсэлтээр үйлдвэрлэлийн байдал, тоног төхөөрөмжийн хэвийн байдал, ажиллагсдын тогтвор суурьшил, хөдөлмөр хамгаалал, нийгмийн баталгаа, бүтээгдэхүүний шинжилгээний бичиг зэргийг нүдээр үзэн танилцаж хугацааг хэрхэн сунгах тухай шийдвэрлэх баримт бичгийг шалгасан.

Үүнд: Анто од ХХК, Бурхант хясаат ХХК, Эко ноос ХХК, Силикат ХХК-ууд хамрагдав.



# Силикат ХК





2022 онд Тусгай зөвшөөрөл шинээр олгосон болон сунгуулсан:

| **№** | **ААНБ-ийн нэр** | **Тусгай зөвшөөрөл олгосон огноо хугацаа** |
|---|---|---|
| **1** | Да ди төмөр ХХК | 2022.03.15 /2 жил/-шинээр авсан |
| **2** | Стандарт стийл ХХК | 2022.01.08 /5 жил/-сунгуулсан |
| **3** | Мөнх Од цацрал ХХК | 2022.01.28 /5жил/-сунгуулсан |
| **4** | Эко ноос ХХК | 2022.06.07 /5 жил/-сунгуулсан |
| **5** | **Бурхант хясаат ХХК** | 2022.06.07 /5 жил/-сунгуулсан |
| **6** | **Анто-Од ХХК** | 2022.06.07 /5 жил/-сунгуулсан |
| **7** | **Силикат ХК** | 2022.06.07 /5 жил/-сунгуулсан |

### *2.2.4.Барилгын материалын үйлдвэрлэлийн мэдээ, тайлан*

Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 28 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019.12.18-ны өдрийн 206,А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2021 оны мэдээг хүлээн авсан. 2022 оны 2 сарын 08-ны байдлаар 23 байгууллага мэдээ ирүүлсэн байна.

Гялалзах гэрэл ХХК, Их торгоны зам ХХК, Мэжик нью ворлд ХХК-ууд мэдээ ирүүлээгүй болно.

Харин Гантиг өргөө ХХК, Чуань Мон арматур ХХК-иуд 2021 онд үйлдвэрлэл явуулаагүй тухай албан тоот ирүүлсэн.

Мэдээг нэгтгэн 2022.02.09-ний №58, 59, 62 албан тоотоор БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ, БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ, БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБООНД хүргүүллээ.

Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагааны тайлан мэдээг Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 206, А/184 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан маягт, маягт нөхөх зааврын дагуу хуулийн хугацаанд /2022.02.21-ны дотор/ БАРИЛГЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ-д https://mcis.gov.mn/ тайлагнах тухай мэдэгдсэн.


ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
45043 Дархан, Дархан-Уул аймаг 8-р баг
Утас/Факс: 7037-3779
E-mail: Darkhan@gazar.gov.mn
Веб хаяг: http://www.darkhan.gazar.gov.mn

2022.02.09 № 67

танай ________-ны № ________-т

Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 28 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019.12.18-ны өдрийн 206,А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2021 оны мэдээг хүлээн авсан. 2022 оны 2 сарын 08-ны байдлаар 23 байгууллага мэдээ ирүүлсэн байна.

Гялалзах гэрэл ХХК, Их торгоны зам ХХК, Мэжик нью ворлд ХХК-ууд мэдээ ирүүлээгүй болно.

Харин Гантиг өргөө ХХК, Чуань Мон арматур ХХК-иуд 2021 онд үйлдвэрлэл явуулаагүй тухай албан тоот ирүүлсэн.

Мэдээг нэгтгэн хүргүүллээ.
Хавсралт 3 хуудастай.

ДАРГА Д.БАТЧУЛУУН

452220000133

D:\Tsendee\ 2022\албан тоот\toot A5 67.doc

БМ-ын 2021 оны жилийн эцсийн мэдээ ирүүлсэн байгууллагууд:

1. Сонголон хайрхан ХХК
2. Мөнх од цацрал ХХК
3. Бурхант хясаат ХХК
4. Хасуу ХХК
5. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК
6. Эко ноос ХХК
7. Эй эн ти хаус ХХК
8. Си Эм Пи Ай ХХК
9. Хатуу төмөр ХХК
10. Стандарт стийл ХХК
11. Сан оргиу ХХК
12. Тэгшхан ХХК
13. Дашут ХХК
14. Булган инвест ХХК
15. Өөвх баян бүрд хаус ХХК
16. Дархан карьер ХХК
17. Дархан цонх констракшн ХХК
18. Идэрхайрхан ХХК
19. Тугалт шийр ХХК
20. Силикат ХХК
21. Дархан трейд ХХК
22. Инноза Ложистик ХХК
23. Анто-Од ХХК

2021 онд үйлдвэрлэл явуулаагүй тухай албан тоот ирүүлсэн:

1. Гантиг өргөө ХХК
2. Чуань Мон арматур ХХК

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН 2021 ОНЫ МЭДЭЭ

1. Сонголон хайрхан ХХК
2. Тэгшхан ХХК
3. Дархан карьер ХХК
4. Идэрхайрхан ХХК
5. Силикат ХХК
6. Инноза Ложистик ХХК
7. Анто-Од ХХК

II. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл СУНГУУЛАХ, НЭМЭЛТЭЭР хүссэн ААНБ-ууд нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл ажиллагааны тайлан мэдээг /Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 206, А/184 тоот тушаалын мэдээлэл авах холбогдох маягтаар /БМ-1, БМ-2/ тайлангаа хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлнэ гэсэн заалтын дагуу БАРИЛГЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ-д ttps://license.mcis.gov.mn/login 2022.07.20-ны дотор хагас жилийн мэдээ, 2023.02.21-ны дотор жилийн мэдээг тус тус цахимаар илгээх тухай ГХБХБГ-ын 2022.06.13-ны өдрийн №376, 2022.11.22-ны өдрийн №800 албан тоот хүргүүлж зохион байгуулж ажилласан.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2022.11.22 № 800

Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагааны тайлан мэдээг Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 206, А/184 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан маягт, маягт нөхөх зааврын дагуу хуулийн хугацаанд БАРИЛГЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ-д https://mcis.gov.mn/ 2023.02.21-ны дотор тайланг цахимаар илгээнэ үү.

Нэвтрэх нэр, нууц үгийг мартсан болон шинээр авах бол 99143658 утсаар холбогдож авна уу.

ДАРГА Д.БАТЧУЛУУН

452220001370

D:\Tsendee\ 2022\албан тоот\toot A5.800.doc

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУ…

2. Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага тайлант оны эхний хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 25-нд, жилийн мэдээг дараа оны 2 дугаар сарын 25-нд Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3. Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага тайлант оны эхний хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 30-нд, жилийн мэдээг дараа оны 3 дугаар сарын 4-нд Үндэсний Статистикийн Хороонд ирүүлнэ.



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2022.06.13 № 376

Иннова ложистик Х-д

Барилгын материалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагааны тайлан мэдээг Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 206, А/184 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан маягт, маягт нөхөх зааврын дагуу хуулийн хугацаанд БАРИЛГЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ-д https://license.mcis.gov.mn/login 2022.07.20-ны дотор цахимаар илгээнэ үү.

Нэвтрэх нэр, нууц үгийг мартсан болон шинээр авах бол 80100081, 99143628 утсаар холбогдож авна уу.

ДАРГА Д.БАТЧУЛУУН

452220000645

D:\Tsendee\ 2022\албан тоот\toot A5.376.doc

Жич: Барилгын материалын түүхий эд олборлох, боловсруулах, түүгээр төрөл бүрийн материал, хийц эдлэлийн үйлдвэрлэл эрхлэгч нарт

Тус мэдээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон борлуулалтын үнийн мэдээ, ашиглагдаж буй машин механизм, ажилчдын тоо, олгосон цалин, Барилгачдын хөдөлмөрийн багаж ажлын хувцас, хэрэгсэлд зарцуулсан зардлын хэмжээ, Барилгын талбай дахь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах зардал бүхий мэдээдэл багтана.



БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

2022-11-22 № 1/3537

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ

Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим системийн тусгай зөвшөөрлийн модулиас орон нутгийн харьяатай барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрлийн мэдээлэл, үйл ажиллагааны тайлан мэдээг харах, татаж авах, судалгаа шинжилгээнд ашиглахад зориулж, аймаг тус бүрд цахим системд нэвтрэх эрх олгохоор бэлтгэл ажлыг хангаад байна.

Иймд дээрх эрхийг авах нэг ажилтны овог, нэр, регистрийн дугаар, и-мэйл хаяг, холбогдох утас зэрэг мэдээллийг албан бичгээр болон цахим шуудан /n.enkhjargal@barilga.gov.mn/-аар 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ Ц.АМАРСАНАА

152206665

Эдгээр мэдээллийг аймгийн судалгаанд ашиглах шаардлагын улмаас нэвтрэх эрх хүссэн 2022.11.22-ны өдрийн №1/3537 албан тоот хүргүүлсэн.

Өөрсдийн лабораторигүй учир аймгийн хэмжээний барилгын материалын шинжилгээг Улаанбаатар хот болон аймгийн ШУТИС-ийн дэргэд дэх барилгын материалын итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлдэг. Дархан Төмөрлөгийн үйлдвэр шинжилгээ хийх 10 тоног төхөрөөмжтэй, харин ШУТИС-ийн дэргэдэх лаборатори нь 41 төрлийн шинжилгээний тоног төхөөрөмжтэй, бүх үзүүлэлтээр шинжилгээ гарахгүй. Иймд эдгээр лабораториудад бүтээгдэхүүний шинжилгээнд өгч, шаардлагатай тохиолдолд Улаанбаатар руу явуулж байна.



ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар TL 12-04

ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018) стандартын шаардлагыг хангасан

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн Барилгын материалын сорилтын лабораторийг

хавсралтад заасан итгэмжлэлийн хүрээнд сорилт гүйцэтгүүлэхээр итгэмжлэв.

Анх итгэмжлэл авсан огноо: 2004.12.25

Олгосон огноо: 2022.07.08

Дуусах огноо: 2026.07.07

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.СОРОНЗОНБОЛД

0000795

APAC

Барилгын материалын үйлдвэрүүд өөрсдийн лабораторид өдөр тутмын бүтээгдэхүүнд шинжилгээ хийхээс гадна ШУТИС-ийн дэргэдэх Барилгын материалын сорилтын лабораторид дээж өгч шинжлүүлж ажилладаг. 2022 онд аймгийн давхардсан тоогоор 15 үйлдвэрийн 11 нэр төрөл дээр 120 удаагийн гадаад шинжилгээ хийж дүгнэлт гарсан болно.

## Барилгын Материалын Сорилтын лабораторид
## 2022 оны 01 -р сарын 02-ээс -р 12 сарын 1 хүртэл хийгдсэн шинжилгээ

| № | он сар өдөр | Байгууллагын нэр | бетон сорьц | элс | Дүүргэгч | цемент | тоосго | тэст | [illegible] блок | шохой | хөнгөн бетон | орцын тооцоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 21-02-17 | Их Хурдатгал ХХК | 1 | | | | | | | | | |
| 2 | 21-02-28 | Сокол ХХК | | | | | | | | | | 1 |
| 3 | 21-03-04 | Гантиг Өргөө ХХК | 1 | | | | | | | | | |
| 4 | 21-03-25 | Өсөх урам ХХК | 1 | | | | | | | | | |
| 5 | 21-03-30 | Өсөх баян бүрд хаус ХХК | 1 | | | | | | | | | |
| 6 | 21-04-02 | Иргэн Тунгалаг | 1 | | | | | | | | | |
| 7 | 21-02-28 | Стандарт стийл ХХК | | 1 | 1 | | | | | | | |
| 8 | 21-05-04 | Болор гэм | 1 | | | | | | | | | |
| 9 | 21-05-11 | Стандарт стийл ХХК | 1 | | | | | | | | | |
| 10 | 21-05-11 | Тайвийн хайрхан ХХК | 1 | | | | | | | | | |
| 11 | 21-05-18 | Стандарт стийл ХХК | | | | | | 1 | | | | |
| 12 | 21-05-22 | ДЭБУТ ХХК | 1 | 1 | 1 | 1 | | | | | | |
| 13 | 21-05-24 | биг рентал ХХК | 1 | | | | | | | | | |
| 14 | 21-05-25 | Бурхант хясаат | 1 | | | | | | | | | |
| 15 | 21-05-31 | Бурхант хясаат | 1 | | | 1 | | | | | | |
| 16 | 21-05-31 | Өсөх баян бүрд хаус | 1 | | | | | | | | | |
| 17 | 21-06-02 | Дархан карьер ХХК | | 1 | 1 | | | | | | | |
| 18 | 21-06-07 | Баян өндөр булаг ХХК | | 1 | 1 | | | | | | | |
| 19 | 21-06-08 | Пимпо ХХК | | | | | | | 1 | | | |
| 20 | 21-06-08 | Биг рентал ХХК | 1 | | | | | | | | | |
| 21 | 21-06-10 | Тайвийн хайрхан ХХК | 1 | | | | | | | | | |
| 22 | 21-06-07 | Стандарт стийл ХХК | 1 | | | | | | | | | |
| 23 | 21-06-14 | Бурхант хясаат ХХК | | | | | | | 1 | | | |
| 24 | 21-06-15 | Мөнх од цацралтХХК | 1 | | | | | | | | | |
| 25 | 21-06-15 | Силикат ХК | | | | | | | | | 1 | |
| 26 | 21-06-17 | Их торгоны зам ХХК | 1 | 1 | 1 | 1 | | | | | | 1 |
| 27 | 21-06-20 | Стандарт стийл ХХК | 1 | | | | | | | | | |
| 28 | 21-06-22 | Монкон констракшн ХХК | 1 | | | | | | | | | |
| 29 | 21-06-28 | СМРI ХХК | 1 | | | 1 | | | | | | |
| 30 | 21-06-30 | Өсөх баян бүрд хаус | 1 | | | | | | | | | |
| 31 | 21-07-02 | Мөнх од цацралтХХК | 1 | | | | | | | | | |
| 32 | 21-07-10 | тэгш минж ХХК | 1 | | | | | | | | | |
| 33 | 21-07-17 | Сонголон хайрхан ХХК | 1 | | | | | | | | | |
| 34 | 21-07-28 | Сайн оршних ХХК | 1 | | | | | | | | | |
| 35 | 21-07-28 | Авто Од ХХК | 1 | | | | | | | | | |
| 36 | 21-07-29 | Хос гурвалжин ХХК | 1 | | | | | | | | | |
| 37 | 21-07-30 | Тайван хайрхан ХХК | 1 | | | | | | | | | |
| 38 | 21-08-03 | Сонголон хайрхан ХХК | 1 | | | | | | | | | |
| 39 | 21-08-13 | Хаш Эрдэнэ | 1 | | | | | | | | | |
| 40 | 21-08-13 | Мөнх од цацралтХХК | 1 | | | | | | | | | |
| 41 | 21-08-16 | Монкон констракшн ХХК | 1 | 1 | 1 | | | 1 | | | | |
| 42 | 21-08-27 | Бум констракшн ХХК | 1 | | | | | | | | | |
| 43 | 21-08-27 | Мөнх од цацралтХХК | 1 | | | | | | | | | |
| 44 | 21-08-27 | Евро стандарт ХХК | 1 | | | | | | | | | |
| 45 | 21-08-30 | БТЕГол | 1 | | | | | | | | | |
| 46 | 21-08-29 | Эй эн ти хаус | 1 | | | | 1 | | | | | |
| 47 | 21-08-30 | ДЭБУТ ХХК | | | | | | | | | | 1 |
| 48 | 21-08-31 | Конкрете бетон хийц ХХК | 1 | | | | | | | | | |
| 49 | 21-08-31 | Баттөмөр | 1 | | | | | | | | | |
| 50 | 21-09-06 | тэгш хан ХХК | 1 | | | | | | | | | |
| 51 | 21-09-07 | Эрдэнэт оргил ХХК | | | | | 1 | | | | | |
| 52 | 21-09-13 | Дэвжих таван хан ХХК | | | | 1 | | | | | | |
| 53 | 21-09-13 | Грийнресурс ХХК | 1 | 1 | 1 | 1 | | | | | | |
| 54 | 21-09-15 | Конкрете бетон хийц ХХК | 1 | | | | | | | | | |
| 55 | 21-09-16 | УВШ хаанХХК | 1 | | | | | | | | | |
| 56 | 21-09-17 | Төгс өсөх премиум ХХК | 1 | | | | | | | | | |
| 57 | 21-09-17 | Төгс өсөх премиум ХХК | | | | | | | | | | 1 |
| 58 | 21-09-20 | РЕГ ХХК | 1 | | | | | | | | | |
| 59 | 21-09-21 | Номад нэйчур ХХК | 1 | | | | | | | | | |
| 60 | 21-09-23 | Их торгоны зам ХХК | 1 | | | | | | | | | |
| 61 | 21-09-29 | Хос гурвалжин ХХК | 1 | | | | | | | | | |
| 62 | 21-10-06 | феррум металл монголия ХХК | 1 | | | | | | | | | |
| 63 | 21-10-07 | Дархан ХХК | 1 | | | | | | | | | |
| 64 | 21-10-08 | Их торгоны зам ХХК | 1 | | | | | | | | | |
| 65 | 21-10-12 | Силикат ХК | | | | | | | | 1 | 1 | |
| 66 | 21-10-12 | Гал хүдэр орд ХХК | 1 | | | | | | | | | |
| 67 | 21-10-14 | СМРI ХХК | | | 1 | | | | | | | |
| 68 | 21-10-12 | Тэгш хан ХХК | 1 | 1 | 1 | 1 | | | | | | |
| 69 | 21-10-19 | Грийн ресурс ХХК | | | | | 1 | | | | | |
| 70 | 21-10-19 | Конкрете бетон хийц ХХК | 1 | | | | | | | | | |
| 71 | 21-10-19 | Дархан трейд ХХК | 1 | | | | | | | | | |
| 72 | 21-10-20 | Дархан ХХК | 1 | | | | | | | | | |
| 73 | 21-10-27 | Тэмээн зэрэг ХХК | 1 | | | | | | | | | |
| 74 | 21-10-28 | Их торгоны зам ХХК | 1 | | | | | | | | | |
| 75 | 21-11-04 | БТЕГ ХХК | 1 | | | | | | | | | |
| 76 | 21-11-09 | Хялгант нуга ХХК | 1 | | | | | | | | | |
| 77 | 21-11-10 | Энхбат иргэн | 1 | | | | | | | | | |
| 78 | 21-11-13 | Сонголон хайрхан ХХК | | | 1 | | | | | | | |
| 79 | 21-11-14 | Мөнх од цацрал ХХК | 1 | | | | | | | | | |
| 80 | 21-11-16 | Силикат ХК | 1 | | | | | | | | | |
| 81 | 21-11-16 | Дэвжих таван ханХХК | | | | 1 | | | | | | |
| 82 | 21-11-24 | ВокомХХК | 1 | | | | | | | | | |
| | | | 65 | 8 | 10 | 8 | 3 | 2 | 2 | 1 | 2 | 4 |



Эзлэх хувиар




### *2.2.5.Хяналт шалгалт, ажлын хэсэгт ажилласан тухай*

- ✓ Түмэн зул энержи ХХК худалдан авсан /Ворлддэйнт ХХК-2020 онд 7 га газар/. Гэхдээ газраа нэр шилжүүлж аваагүй байна. 2022 онд бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй гэж, технологийн заавлыг батлуулахаар БМҮХолбоонд хүргүүлсэн байгаа.



- ✓ Дархан Эрдэс Шохойт Шийр ХХК-Ворлддэйнт ХХК-аас 3 га газар худалдан авсан ба газрын гэрчилгээ удахгүй гарна. Мөн БМҮХолбоонд хүсэлтээ өгсөн байгаа.








- ✓ Иннова ложистик ХХК-тусгай зөвшөөрөлтэй
- ✓ Мөнхболор Эрдэнэ ХХК





- ✓ Силикат ХК
- ✓ Идэрхайрхан ХХК-2021.07.27-2026.07.27 МҮ-2.1-тусгай зөвшөөрөлтэй, харин дайрга 5-20мм 2019.07.22-2022.07.22-нд тохирлын гэрчилгээ хугацаа дууссан. Сунгуулах тухай шаардлага тавьж, мэдээлэл өгсөн.
- ✓ Тулгат шийр ХХК-2021.07.27-2026.07.27 МҮ-1.3-тусгай зөвшөөрөлтэй, харин шохойн тохирлын гэрчилгээ авах тухай зөвлөсөн.
- ✓ Сутайн үхэр чулуут ХХК-иуд нь 2022 онд үйлдвэрлэл явуулаагүй, гэвч зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулах тухай зөвлөгөө өгсөн.

МҮ-1.3 Цемент, шохой, магни, гөлтгөнө болон холимог барьцалдуулагч материалын үйлдвэр (Шатаасан шохойн үйлдвэрлэл) чиглэлээр үйлдвэрлэл эрхэлж байна. ААНБ нь өөрсдөө түүхий эдээ олборлож, бутлан ангилж, шатаасан шохойг гарган ажиллаж байна.

Цаашид үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлөө шинээр болон дууссан хугацааг сунгуулж аймгийн мэдээллийн санд бүртгүүлж ажиллах, шинжилгээний бичигтэй бүтээгдэхүүнийг нийлүүлэх шаардлагатай байгааг тайлбарлан 2022.08.30 №532 албан тоотыг хүргүүлж ажилласан.




1. Очир бетон ган ХХК бетон зуурмагийн үйлдвэрийн ашиглалтанд оруулах комисст /2022.09.21/-нд ажилласан. Суурьт зуурмагийн /силос/ байрлуулсан байдал, экспертизээр батлагдсан ажлын зураг, БХТөвд магадлал хийгдсэн зураг төсөл, гүйцэтгэгч компанитай хийгдсэн гэрээ зураг баримтуудыг шалгасан.
2. 2022.08.25 Дархан хөөсөнцөрийн үйлдвэр дээр очиж зохих бичиг баримтыг үзэж шалгах, газар дээр ерөнхий технологич байхгүй тул холбогдох баримт бичигтэй ирж

уулзахыг зөвлөж үйлдвэрлэлийг цаашид үргэлжлүүлэх бол шинжилгээний бичиг, зөвшөөрөл авахыг тайлбарласан.









3. Монгол улсад цементийн импортын татвар тэглэсэнтэй холбоотойгоор 2022.10.05-ны өдөр Дархан-Уул аймгийн хэмжээнд ажиллаж буй бетон зуурмагийн 6 үйлдвэрийн силост үзлэг шалгалт хийж ажиллаа. Аймгийн МХГ-ын улсын байцаагч С.Цэвэлравжаа-ын хамт түүхий эдийг хаанаас нийлүүлэлдэг болон түүний орлогын падаан баримт бичгийг нүдээр үзэн танилцаж шалгасан.

Удаан хадгалагдсан эсвэл чулуужсан цементийг

Хятад улсаас орж ирж буй цемент нь өнжсөн, хуучин түүхий эдийг дахин нунтаглаж нийлүүлж болзошгүй, мөн ирсэн цементийг чанар стандарт шаардлагадаа хүрч буй эсэхийг шинжилдэг эсэх, өөрсдийн дотоодын лабораторидоо энэ төрлийн шинжилгээг хийж үйлдвэрлэлд оруулдаг эсэхийг шалгасан. Үүнд:

- Очир ган бетон ХХК
- Анто-од ХХК
- Сонголон хайрхан ХХК
- Стандарт стийл ХХК
- Дархан төгөлдөр ХХК



❖ Их торгоны зам ХХК
















ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

504 тоот, Ардын эрхэн чөлөөний 5 дугаар гудамж, 17 дугаар хороолол, 8 дугаар баг, Дархан сум, Дархан-Уул аймаг 45043
Утас/факс: (976) 7037-3770, 7037-6483
Цахим шуудан: Darkhan@gazar.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gazar.gov.mn

2022.09.29 № 621

танай ____ -ны № ____ -т

АНТО-ОД ХХК-д

Улсын хэмжээнд цементийн хомсдол үүсэж байгаа энэ үед дотоодын цемент болон БНХАУ-ын цементийн маркийг тодорхойлж баталгаажуулсны дараа бетон зуурмаг үйлдвэрлэж байхыг анхаарна уу.

Мөн үйлдвэрийн дэргэдэх хяналтын лабораторийн шинжилгээний үр дүнг хавсралт маягтын дагуу, хяналтын лабораторийн бетоны пресс баталгаажуулсан гэрчилгээний хуулбар, бүтээгдэхүүний чанарыг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид баталгаажуулсан баримтын хамт ирүүлнэ үү.

ДАРГА Д.БАТЧУЛУУН



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2022.09.29 № 621

ИХ ТОРГОНЫ ЗАМ ХХК

Улсын хэмжээнд цементийн хомсдол үүсэж байгаа энэ үед дотоодын цемент болон БНХАУ-ын цементийн маркийг тодорхойлж баталгаажуулсны дараа бетон зуурмаг үйлдвэрлэж байхыг анхаарна уу.

Мөн үйлдвэрийн дэргэдэх хяналтын лабораторийн шинжилгээний үр дүнг хавсралт маягтын дагуу, хяналтын лабораторийн бетоны пресс баталгаажуулсан гэрчилгээний хуулбар, бүтээгдэхүүний чанарыг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид баталгаажуулсан баримтын хамт ирүүлнэ үү.

ДАРГА Д.БАТЧУЛУУН



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2022.09.29 № 621

СТАНДАРТ СТИЙЛ ХХК

ДАРГА Д.БАТЧУЛУУН



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2022.09.29 № 621

СОНГОЛОН ХАЙРХАН ХХК

ДАРГА Д.БАТЧУЛУУН



❖ Үр дүнд дээрх үйлдвэрүүд хятад цемент үйлдвэрлэлд оруулаагүй бөгөөд Хөтөл цемент зогссонтой холбоотойгоор МАК болон Мон цементийг өндөр үнээр худалдан авч үйлдвэрлэлээ зогсоохгүй ажиллаж байна.

❖ Мөн энэ шалгалтын үеэр Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын даргын 2022 оны 621 албан тоот бичгийг Тусгай зөвшөөрөлтэй 4 ААНБ-д олгож хариуг хавсралтаар албажуулан ирүүлэх тухай дурдсан. Үлдсэн 2 ААНБ Дархан төгөлдөр ХХК, Очир ган бетон ХХК/-ийг өвлийн зогссон улиралдаа багтааж тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээг авч аймгийн мэдээллийн санд бүртгүүлэхийг даалгалаа.

❖ Өөрсдийн дотоодын лабораторидоо бетон зуурмаг үйлдвэрлэл тутамд шинжилдэг эсэх мэдээллийг марк тус бүрээр гаргах жишээ загварыг хавсралтаар хүргүүлсэн.




















4. Улсын үзлэг тооллогын дэд ажлын хэсэгт ажилласан байдал:

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022.04.12-ны өдрийн 01-А/96 захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж орон нутгийн өмчит 95 байгууллагын 245 газар эзэмших эрх болон газрын суурь үнэлгээг 2021 оны санхүүгийн тайланд үнэлсэн үнэлгээг 2022.05.10-.2022.05.30-ны хооронд шалгаж тооллоо. 245 газраас 88 газрын 33.6 тэр бум төгрөг /33 649 044 400/-ийн зөрчлийг илрүүлж ажилласан.

Үүнээс Санхүүгийн тайланд **дутуу** үнэлж оруулсан 75 газрын 9.1 тэр бум төгрөг /9 064 097 400/, **илүү** үнэлсэн 13 газрын 24.5 тэр бум төгрөг /24 584 947 000/-ийн зөрчил гарсан. Мөн 237 барилга байгууламжийн ашиглалтанд орсноос хойш хувийн хэрэг хөтлөлт, газрын гэрчилгээний цахим код авч шинэчилсэн эсэх, газрын кадастрт барилга байгууламжийн бүртгэл зэргийг хянаж шалгаж ажилласан. Барилга байгууламжийн хувийн

хэрэг хөтлөлт маш муу, зарим барилгад хувийн хэрэг нээгээгүй, барилга нь газар эзэмших эрхийн гэрчилгээний кадастрт ороогүй зөрчлүүд байсан. Эдгээр зөрчлийг арилгах зааварчилгаа өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтээр тухайн газрууд гэрээ гэрчилгээг шинэчлэн ажилласан байна. Мөн санхүүгийн тайланд тусгаагүй газрууд газрын төлбөр төлдөггүй, зарим нь ийм газартайгаа мэдэхгүй байсан.
Эх үүсвэр: МУЗГын 2018 оны 182 тогтоол, БХБСайдын 2018 оны 208 тушаал, ДУАИТХ 2018 оны 08/01 тогтоолыг үндэслэн үнэлгээг тооцсон.

-газар, QR коджуулалт, мөн Санхүүгийн тайланд зөв үнэлсэн байдал,
-барилга байгууламж, хувийн хэрэг бүртгэл хөтлөлт, баяжуулалт,
-тээврийн хэрэгсэл, торгууль татвар төлбөр төлсөн байдал зэргийг шалган түүнийг залруулах тухай зөвлөн туслаж ажиллаа.



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр Дугаар 01-А/96 Дархан

Улсын үзлэг, тооллого зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4, 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дархан-Уул аймгийн орон нутгийн өмчит 95 хуулийн этгээдийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсугай.

2.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмч, төсөв санхүү, эдийн засаг, гадаад бодлого хяналтын хорооны дарга (зөвшилцсөнөөр)

Аймгийн ерөнхий эдийн засагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Татварын хэлтсийн дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Аймгийн Авто тээврийн төвийн дарга

452201028



2

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх иргэний зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

3.Улсын үзлэг тооллого зохион байгуулах төлөвлөгөө, удирдамж боловсруулан гаргаж, мэдээ тайланг хугацаанд нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсэг (Орон нутгийн өмчийн газрын дарга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ



## 2.3 ДЭД БҮТЭЦ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ

### *2.3.1 Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл*

**ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЧИГЛЭЛЭЭР**

- Дархан-Уул аймаг, Орхон сум, 35/10кВ-ын Жимс дэд станцын шинэчлэлтийн ажил
- Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р баг, иргэн Т.Наранчимэгийн жуулчны баазын цэвэр усны худгийн 6кВ цахилгаан дамжуулах шугам
- Орхон сумын 1-р баг иргэн Ж.Отгонбаатарын төмс, хүнсний ногооны усалгаатай тариалангийн зориулалттай газрын цахилгаан хангамж
- Орхон сумын 1-р баг иргэн К.Мягмарсүрэнгийн төмс, хүнсний ногооны усалгаатай тариалангийн газрын цахилгаан хангамж
- Дархан-Уул аймаг, Хонгор сум, 2-р баг Монрок ХХК -ны уурхайн кэмпийн цахилгааны шугам, уурхайн цахилгааны шугам

- Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг 5-9-р хэсгийн гудамж, 13-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх хотын гэрэлтүүлэг /**БАГЦ -1** /
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 6, 15 дугаар багуудын нутаг дэвсгэрт хийгдэх хотын гэрэлтүүлэг /**БАГЦ -2** /
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 6-р баг, 13-р баг, Монсуль ХХК, шатахуун түгээх станцын газрын зориулалттай газарт 6кВ-ын ЦДАШ, 6/0.4кВ-ын 50кВа дэд станцын цахилгаан хангамжийн ажил
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 10-р баг, 25-р хорооллын хойно байрлах иргэн С.Ганзориг, Д.Батбаяр нарын амины орон сууцны гадна дулаан хангамжийн ажил
- Дархан-Уул аймаг, Хонгор сум, 1-р баг, 7-р бригадын ард байрлалтай Их оч ХХК-ийн Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай газарт 6кВ-ын ЦДАШ, 6/0.4кВ-ын 25кВ дэд өртөөний цахилгаан хангамжийн ажил

**ДУЛААН ХАНГАМЖ**

- Дархан сумын 13-р багт баригдах ТК-80-ТК94 дулааны худгийн ажил эхлэх зөвшөөрөл хүсэлтийн дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж зөвшөөрөл олгосон.
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 5,6,7-р багийн нутаг дэсвгэрт байрлах дулаан дамжуулах сүлжээний ТК27-ТК39 худгийн хооронд дулааны магистрал шугамын их засварын ажил
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг, Хабитат, Мангирт чиглэлийн дулаан хангамжийн 2 дугаар контурын ажил
- Дархан-Уул аймаг, Шарын гол сум, Дархан баг чиглэлийн дулааны шугамын өргөтгөлийн ажил

**УС ХАНГАМЖ АРИУТГАХ ТАТУУРГА**

- Дархан-Уул аймаг, Хонгор сум, цэвэрлэх байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 3,8,9,10,11,13,15 дугаар багийн нутаг дэвсгэрт цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил

**ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭ**

- Дархан-Уул аймгийн Хонгор суманд үерийн усны суваг угсралтын ажил
- Дархан сум 15-р багт хийгдэх үерийн усны сувгийн ажил

- Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р багийн нутаг дэсвгэрт үерийн ус зайлуулах сувгын багц ажил / **Багц 2** /
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р багийн нутаг дэсвгэрт үерийн ус зайлуулах сувгын багц ажил / багц 3 /



### *2.3.2 Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 2 гадна цахилгааны шугамыг ашиглалтад комиссыг зохион байгуулах*

- Дархан-Уул аймаг, Дархан сум, 12-р баг, Аргал Ойл ХХК -ны ШТС
- Дархан-Уул аймаг, Хонгор сумын зулзагын голд Сая сая болор ХХК амралтын газрын 6кВ цахилгааны агаарын шугам, дэд станц
- Дархан-Уул аймаг, Хонгор сумын зулзагын голд Иргэн Б.Банзрагчийн амралтын газрын цахилгааны шугам
- Дархан сумын 13-р баг үйлдвэрийн раойнд байрлах Эрд хул ХХК-ны 6кВ кабель шугам 160кВ дэд станц
- Хонгор сумын төвийн цахилгаан эрчим хүчний 35кВ агаарын шугам, дэд станцын засвар шинэчлэлтийн ажил
- Дархан сумын 10-р баг 5-р хороолол Газар буудай ХХК оффис үйчилгээний барилга
- Дархан сум 5-р баг Хүслэн төвийн өргөтгөлийн барилга комисс ажилласан.











### *2.3.3. Архитектур төлөвлөлтийн даалгавар*

- Залуус 1,2 хорооллын инженерийн шугам сүлжээний ариутгах татуурга, дулаан хангамж, ус хангамж ариутгах татуурга, мэдээлэл харилцаа холбооны шугам, цахилгаан эрчим хүчний шугамын зураг төсөл боловсруулах даалгавар
- Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт төслийн авто замын зураг төсөл боловсруулах даалгавар
- Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалга тоолуур нэвтрүүлэх төслийн цэвэр усны шугамын ажлын зураг төсөл боловсруулах даалгавар.
- Дархан сумын хэмжээнд үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар
- Дархан сумын 12,13,15-р баг Хабитат чиглэлийн дулаан хангамжийн шугам сүлжээний 2 дугаар хэлхээний ажлын зураг төсөл боловсруулах даалгавар.

### *2.3.4. Жижүүрийн хөтлөлтийн тайлан.*

- 2021 оны үйл ажиллагааны тайланг 2022.01.15-ны өдөр хүргүүлж 3 дугаар байрт дүгнэгдсэн. 2022.12.15 өдрийн байдлаар 39 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн зураг төслийг мэдээллийн санд оруулаад байна.




### *2.3.5 Газар чөлөөлөлт*

- Байгаль орчины уулзвараас Монгол банкны уулзвар хооронд авто зам өргөтгөлийн ажилтай холбогдуулан замын трассд орсон Баян бридж ХХК-ны орон сууцны гадна талд хийгдэх явган зам, Парк таун СӨХ-ны эзэмшилд байрлах автобусны зогсоолыг өргөтгөх ажлуудад тухайн хариуцагч байгууллагуудтай зөвшөлцөж саадгүй хийлгэсэн.
- Дархан суманд дугуйн зам хийгдэж байгаатай холбогдуулан Өргөө кино театрын баруун талд замын трасс дулааны шугамтай давхцал үүссэн тул Сод монгол групптэй зөвшөлцөж замын ажлыг саадгүй хийлгэсэн.

- Дархан сумын 6-р баг, 1-р сургуулийн урд талд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх авто замын 7 айлын газар чөлөөлөлтийн ажил хийгдсэн.





## ГУРАВ. ЗАХИРГАА УДИДЛАГА

### 3.1. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

#### 3.1.1. Мэдээлэл технологийн талаар үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 70376471 нээлттэй утсаар 259, Facebook хуудсанд асуусан 253 иргэн, аж ахуйн нэгжийн асуултанд байгууллагын асуултанд хариулт, зөвлөгөө өгөв. Эдгээр асуултуудын дийлэнхийг газраа шинэчилсэн бүртгэлд хамрагдсан эсэхийг хэрхэн мэдэх, шинэчилсэн бүртгэлд байгаа эсэхийг шалгуулах хүсэлт, газрын цахим системд иргэн хэрхэн нэвтэрч орох, ААНБ тоон гарын үсгээр хэрхэн нэвтэрч орох, газрын төлбөрийн мэдээллийг хаанаас авах, газар өмчлөх эрхийг шилжүүлэн авахад бүрдүүлэх материал, газар эзэмших, өмчлөх эрхтэй холбоотой аймгийн болон сумын засаг даргын захирамж гарсан эсэх, шинээр өмчлөлийн газар олгох эсэх талаарх асуулт ээлж байна.












Шинэ үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойд зориулан АЗДТГ-аас зохион байгуулсан “АХА” тэмцээнд оролцов. 2022-03-22-ны өдөр АЗДТГ-ын ХШҮХ-ийн сургалтанд хамрагдлаа. ОБГ-ын гамшгаас хамгаалах сургуулилтанд оролцов. 2022-10-25-ны өдөр Хаан банкнаас зохион байгуулсан сургалтанд хамрагдав. 2022-12-09-нд “Хуурамч мэдээллийг ялган таних” сэдэвт сургалтанд хамрагдав. ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан цахим хуралд сууж, мэдээллийг ГУХ-ийн дарга, ня-бо-д өгөв.







2022-02-02-ны өдөр байгууллагын хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэв. 2022-04-02-ны өдөр Бүх нийтийн цэвэрлэгээнд оролцов.




2022-02-15, 2022-03-03, 2022-03-25, 2022-04-15, 2022-04-28, 2022-05-24, 2022-06-10, 2022-06-29, 2022-08-12, 2022-08-25, 2022-09-08, 2022-09-20, 2022-10-06, 2022-10-26, 2022-11-11, 2022-11-23, 2022-12-09-ний өдрүүдэд Цахим төвд жижүүрлэн газартай холбоотой хүсэлт өгөхөөр ирсэн иргэдэд Газрын цахим системийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.






Дархан сумын ЗДТГ дээр багийн Засаг дарга нарт нээлттэй хаалганы өдөрлөг, гаражийн хаягжуулалтын талаар мэдээлэл хийв. 2022-04-09-нд 9,10-р багийн төв дээр, 2022-04-10-нд 11, 12-р багийн төв дээр нээлттэй хаалганы өдөрлөг хийхэд оролцов.





Байгууллагын архивт байгаа 4, 5, 7, 8, 9, 10, 11, 12, 14, Өргөө багт байрлах гаражийн зориулалттай газруудын нэгж талбарын хувийн хэргийн баяжуулалтыг хийж, цэгцэлж янзлахад туслав. Нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж буйтай холбогдуулан гаражийн

зориулалттай 9-р багийн 361, 12-р багийн 182 ширхэг нэгж талбарын хувийн хэргийг архиваас татаж аван шинэчилсэн бүртгэлд хамрагдсан эсэхийг шалгаж хугацаа нь дууссан, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй нэгж талбарын хувийн хэргүүдийг хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэж өгөв. Архив, бичиг хэргийн ажилтанд 15 ширхэг нэгж талбарын хувийн хэрэг сканердаж өгөв.





2022-08-29-ний өдөр АЗДТГ-т болсон e-darkhan цахим хуудас, аппликейшны сургалтанд хамрагдаж, байгууллагын хэрэглэгч үүсгүүлэн, өөрийн мэдээллийг засварлаж, 2 хүсэлт ирсэний хариуг өгөв. E-Khutuch.mn платформд оруулах байгууллагын мэдээллийг нэгтгэн АЗДТГазар руу цахим шуудангаар илгээв. Байгууллагын 12 албан хаагчийн гар утсан дээр E-Darkhan, Ersdel Darkhan аппликейшнуудыг суулгаж, аппликейшны ач холбогдол, хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөө өгч ажиллав. “Цахим Дархан” төслийн хүрээнд хийгдсэн E-Darkhan, Ersdel Darkhan аппликейшнуудыг хэрхэн сурталчилсан талаарх тайланг хийж албан тоотоор илгээв. Smart city төсөлд зориулсан цахим шилжилтийн танилцуулгыг хийж, АЗДТГ-т очин танилцуулав. Илтгэлийн файлыг засварлан АЗДТГ-ын мэргэжилтэн Чинбилэг рүү илгээв. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг илгээв.










Байгууллагын номын сангаас шаардлагагүй номуудыг /198 ширхэг/ устгаж, агуулах руу зөөж тавив. Шинээр 13 ширхэг ном бүртгэж, бар кодыг хэвлэж наан, хураав. Номын сангийн номын судалгааны мэдээллийг шинэчлэн өөрчлөв.





Монгол бичгийн контентод зориулан албан хаагчдаас монгол бичгийн мэдлэгийн төвшин тогтоох шалгалт авч, бичлэг хийв. Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулав. Монгол бичгийн контентод зориулан Монгол бичгийн уран бичлэгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг Оюуны ирээдүй цогцолборын Монгол бичгийн багш Түмэндэмбэрэл багштай хамтран зохион байгуулав.







Мэдлэг чадвартай төрийн албан хаагч уралдааны техникийн зөвлөгөөнд суув. Ухаалаг хотын танилцуулга, бодлого, төлөвлөгөө, зарчимын талаар мэдээлэл бэлтгэв. Мэдлэг чадвартай төрийн албан хаагч тэмцээнд багийн гишүүдийн хамт оролцов.



**Мэдээлэл технологийн чиглэлээр:**

Байгууллагын цахим хуудасны өгөгдлийн сангийн нөөцлөлт хийв. Цахим хуудасны мэдээнүүдийн цэсний дугаарлалтыг засварлаж, өгөгдлийн санд нь байгаа хэрэггүй файлуудыг устгаж цэвэрлэв. Байгууллагын цахим хуудсанд дараах өөрчлөлтүүдийг хийв. Үүнд:

*Ил тод байдал цэсэнд*

1. Санхүүгийн мэдээ хэсэгт 2021 оны 12-р сар, 2022 оны 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2021 оны санхүүгийн тайлан

2. Санхүүгийн мэдээ хэсэгт Байгууллагын цахим хуудсан дээр Санхүүгийн мэдээг 2016-2020, 2021-2025 оны хооронд харагдахаар салгаж, мэдээллийг зөөж байрлуулав.
3. Үйл ажиллагааны тайлан хэсэгт 2021 оны 12-р сар, 2022 оны 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11-р сарын 7 хоногийн үйл ажиллагааны тайлан, сарын тайлан, 2021 оны байгууллагын бичмэл тайлан
4. Үйл ажиллагааны төлөвлөгөө хэсэгт Байгууллагын 2022-2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр 3ш, Авлигатай тэмцэх 2022 оны төлөвлөгөө, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөө, Ёс зүйн зөвлөлийн 2022 оны төлөвлөгөө
5. Авлигатай тэмцэх хэсэгт Авлигаас урьдчилан сэргийлэх нэртэй холбоос үүсгэн Авлигын эсрэг соён гэгээрүүлэх чиглэлийн 24 ширхэг шторк
6. Хүний нөөц хэсгийг 3 хэсэг болгож хуваан мэдээлэл нэмж оруулав
7. Хүний нөөцийн Нээлттэй ажлын байр хэсэгт Архив, бичиг хэргийн ажилтан ажилд авах тухай зар

*Төрийн үйлчилгээ цэсэнд*

8. Газрын харилцаа хэсэгт Хянан баталгаа хийлгэх тухай мэдээлэл нэмэв.
9. Цахим системээр илгээх боломжтой хүсэлтүүдийн цэсийг үүсгэж, мэдээлэл оруулав.

*Түгээмэл асуулт цэсэнд*

10. Суурь судалгаа, мониторинг хэсэгт Хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын мэдээллийг шинэчлэв.

*Бидний тухай цэс*

11. Байгууллагын түүхэн замнал хэсэгт шинэлэлт хийв.

*Нүүр хуудсанд:*

12. Санал гомдол хүлээн авах хэсгийн кодыг шинээр бичиж, тестлэн ажиллагаанд оруулав.
13. Зарлал хэсгийг Санал хүсэлт болгон өөрчилж санал гомдол хүлээн авах зурган линк үүсгэн байрлуулав.
14. Санал гомдол хэсэгт санал ирсэн огноог бүртгэхээр програмчлав.

*Хууль эрх зүй цэсэнд*

15. Дүрэм, журам хэсэгт Байгууллагын албан хаагчдын шинэчилсэн ёс зүйн дүрэм

*Мэдээ, мэдээлэл цэсэнд:*

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт хэсэгт дараах мэдээллүүдийг оруулав.

1. Нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж буй талаарх мэдээлэл
2. Барилгын салбарын ХАБ-ын сургалтын зар  мэдээллийг байрлуулав.
3. “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд ГХБХБГ-ын хамт олон нэгдсэн тухай мэдээлэл
4. Дархан суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааны зар
5. АЗДТГ-ын ХШҮХ-ийн сургалтанд хамрагдсан талаарх мэдээлэл
6. Нээлттэй хаалганы өдөрлөгийн зар
7. Гаражийн хаягжуулалтын мэдээлэл, нээлттэй хаалганы өдөрлөгийн тайлан
8. Дархан-Уул аймагт баригдаж буй барилгуудын үнийн  мэдээ
9. “Төвийн бүсийн барилга expo 2022 зохион байгуулагдах талаар мэдээлэл
10. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны талаарх мэдээлэл
11. 2022 оны бэлчээрийн фотомониторинг хийгдэж буй тухай мэдээ
12. 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авч буй тухай зар, санал өгөх QR код
13. 2023 онд Дархан суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын тогтоол батлагдсан тухай мэдээ
14. Дархан-Уул аймгийн хэмжээнд баригдаж буй барилгуудын үнэ ханшийн мэдээ
15. Мэргэжилтнүүдийн танилцуулгын QR кодоор нэвтрэх холбоосууд
16. Шарын гол суманд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгийн мэдээ
17. Орхон суманд баригдаж буй ногооны зоорьны барилга угсралтын ажилд хяналт тавьсан тухай мэдээ

18. Ногоо савлах цехийн барилга угсралтын ажилд хяналт тавьсан тухай мэдээ
19. Ган бүтээц /БНбД53-03-22/ норм ба дүрэм шинэчлэгдэн батлагдсан тухай мэдээ
20. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг бүрдүүлэх ажлаар Шарын гол суманд ажилласан талаар мэдээ
21. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт /БНбД31-24-22/ норм ба дүрэм батлагдсан тухай мэдээ
22. Орхон суманд баригдаж буй ногооны зоорьны барилга угсралтын ажилд хяналт тавьсан тухай мэдээ
23. Орхон суманд баригдаж буй ногоо савлах цехийн барилга угсралтын ажилд хяналт тавьсан тухай мэдээ
24. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай мэдээлэл
25. Нээлттэй дуудлага худалдааны зар
26. Шарын гол суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдаа зарласан тухай мэдээлэл
27. Орхон суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааны зар
28. Хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаар хяналт хийсэн талаарх мэдээлэл




ГХБХБГ-ын Facebook хуудсан дээр БХБЯ, БХТ-ийн мэдээлэл 10, ГЗБГЗЗГ-ын мэдээлэл 61, Орон нутгийн ТВ-ын мэдээлэл 16, Дархан-Уул ЗДТГ-ын мэдээлэл 36, бусад төрийн байгууллагын мэдээлэл 19, нийт 142 удаагийн мэдээллийг хуваалцаж, өөрийн болон сумдын даамлуудын фэйсбүүк хуудсан дээр дараах мэдээллүүдийг оруулж, олон нийтэд сурталчлав. Үүнд:

1. Шинэ жилийн видео болон зурган мэндчилгээ
2. Байгууллагын 2021 оны онцлох 5 ажлын постер
3. Цагаан сарын мэндчилгээний постер
4. Нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж буй талаарх мэдээлэл
5. Барилгын салбарын ХАБ-ын сургалтын зар байрлуулав.
6. “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд ГХБХБГ-ын хамт олон нэгдсэн тухай мэдээлэл
7. Байгууллагын цахим хуудасны санал, гомдол хүлээн авах хэсгийн холбоосыг QR код үүсгэн байрлуулав.
8. Дархан суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааны зар
9. АЗДТГ-ын ХШҮХ-ийн сургалтанд хамрагдсан талаарх мэдээлэл
10. “Эрсдэлгүй Дархан” аянд ГХБХБГ-ын хамт олон нэгдсэн тухай мэдээлэл
11. Нээлттэй хаалганы өдөрлөгийн зар
12. Гаражийн хаягжуулалтын мэдээлэл

13. Нээлттэй хаалганы өдөрлөгийн мэдээг 3 удаа
14. Газрын кадастрын системийн нөхөн бүрдүүлэлтийн ажил дуусахад 12 хоног үлдсэн тухай мэдээ
15. Дархан-Уул аймагт баригдаж буй барилгуудын үнийн мэдээ
16. “Төвийн бүсийн барилга expo 2022 зохион байгуулагдах талаар мэдээлэл
17. “Шинэ иргэний төгөл”-д мод тарьсан тухай мэдээ
18. Хараа голын эрэг дээр мод тарьсан талаарх мэдээлэл
19. Байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийг шүдний эрүүл мэндийн үзлэгт оруулсан тухай мэдээлэл
20. Гэр бүлийн явган аялал зохион байгуулсан талаарх мэдээлэл
21. Музейд очиж монгол үндэсний тоглоомоор тоглож сурсан талаарх мэдээлэл
22. Эх үрсийн баярын мэндчилгээ
23. Эх үрсийн баяраар зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээ
24. Архив, бичиг хэргийн ажилтан ажилд авах тухай зар
25. Төрийн албан хаагчийн тангараг өргөх ёслол болсон тухай мэдээлэл
26. Орхон сумын газрын даамлын фэйсбүүк хуудсанд 2022 онд олгох АОС-ны газрын өргөдөл хүлээн авах тухай зар
27. 2022 оны бэлчээрийн фотомониторинг хийгдэж буй тухай мэдээ
28. Дархан-Уул аймгийн хэмжээнд баригдаж буй барилгуудын үнэ ханшийн мэдээ
29. сумдын даамлуудын фэйсбүүк хуудсанд 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авч буй тухай зар, санал өгөх QR код
30. 2023 онд Дархан суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын тогтоол батлагдсан тухай мэдээ
31. Хонгор суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдсан тухай мэдээ
32. Ган бүтээц /БНбД53-03-22/ норм ба дүрэм шинэчлэгдэн батлагдсан тухай мэдээ
33. Хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын мэдээлэл
34. ААНБ тоон гарын үсгийн төхөөрөмж ашиглан egazar.gov.mn цахим хуудас руу хэрхэн нэвтрэх тухай зааврын видео
35. Шарын гол суманд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгийн мэдээ
36. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт /БНбД31-24-22/ норм ба дүрэм батлагдсан тухай мэдээ
37. Орхон суманд баригдаж буй ногооны зоорьны барилга угсралтын ажилд хяналт тавьсан тухай мэдээ
38. Орхон суманд баригдаж буй ногоо савлах цехийн барилга угсралтын ажилд хяналт тавьсан тухай мэдээ
39. Нийгмийн хариуцлагын хүрээнд Дархан сумын иргэн Сольхүүд өмчлөх эрхтэй газар олгосон тухай мэдээ
40. Цахилгааны хамгаалалтын зурвасын талаарх мэдээ
41. egazar.gov.mn цахим хуудаснаас Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрхэн харах тухай зааврын видео
42. “Цахим Дархан” төслийн хүрээнд хийгдсэн E-Darkhan, Ersdel Darkhan аппликейшнуудын талаарх мэдээлэл
43. Залуус 1, 2 хорооллын зураг төсөл хийгдэж байгаа тухай мэдээлэл
44. “Барилгын салбарт ажиллагсдын бүртгэл”-ийн линк
45. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг цахимаар хэрхэн авах тухай заавар
46. Сумдын газрын даамлуудад газрын төлбөр, татварын мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн тухай мэдээлэл
47. Агентлагийн нээлттэй утас 1900-0101-ийн талаар мэдээлэл
48. Газрын тухай хууль, газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөхийг уриалсан мэдээлэл

49. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай мэдээлэл
50. Газрын төлөв байдал чанарын хянан баталгааг ямар тохиолдолд хийлгэх тухай мэдээлэл
51. Дархан-Уул аймгийн Барилгын салбарын спортын их наадмын зар
52. Сумдын газрын даамлуудад ГЗБТ, кадастр, мониторингийн чиглэлээр сургалт хийсэн тухай мэдээлэл
53. Монгол хэл, бичгээ өв тэгш эзэмшицгээе челленжийн пост
54. Монгол бахархлын өдөрт зориулан хүндэтгэл үзүүлсэн тухай мэдээ
55. Шарын гол суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдаа зарласан тухай мэдээлэл
56. Орхон суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдаа зарласан тухай мэдээлэл
57. Хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаар хяналт хийсэн талаарх мэдээлэл



25 удаа цахим хурал болон сургалтын бэлтгэл ажлыг хангаж, хурлын веб камер залгаж, хуралтай холбож өгөв.





Мэргэжилтнүүдийн QR кодыг хэлтэс тус бүрээр нь байрлуулан постерын эх, Мэргэжилтнүүдийн хаягийн эх дээр QR код нэмж дахин өөрчилж бэлтгэн хэвлэв. Захиргааны хэргийн шүүхэд өгөх Миракл лэнд ХХК, Жоконди ХХК, иргэн Ч.Чинбаатарын эзэмших эрхийг цуцалсан газрын ашиглалтгүй байгааг харуулсан зургийг кадастрын хэмжилт хийж, баталгаажуулсан зургийг авч эргэн тойрны байршлыг харуулсан тайлбарын хамт хийж өгөв.



























Нээлттэй хаалганы өдөрлөг болох багуудын төвүүд дээр очиж интернэтийн холболт, цахилгааны эх үүсвэрийг үзэж шалгав. /7 газар/ Мэдээллийг хэвлэж мэргэжилтнүүдэд өгөв. Нээлттэй хаалганы өдөрт хэрэглэх брошур, постеруудын эхийг бэлтгэж, брошурыг 700 хувь хэвлэж, хувааж багуудад хуваарилж өгөв. Нээлттэй хаалганы өдөрлөгт явах багуудын компьютерууд дээр VPN-ий тохиргоог хийж, кодыг өгөв. Нээлттэй хаалганы өдөрлөг дээр 2022-04-09, 2022-04-10, 2022-05-28-ны өдөр ажиллав.

9, 10-р сард Хонгор суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдах болсон тул шаардлагатай брошуруудыг, Орхон суманд зохион байгуулагдах нээлттэй хаалганы өдөрлөгт хэрэглэх 45 ширхэг брошур, Дархан суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдах үед 40ширхэг брошурыг хэвлэж, зүсэн өгөв.












Серверийн өрөөний кондишны усыг 11 удаа асгаж цэвэрлэн, серверийн өрөөнд цэвэр агаар оруулж цэвэрлэгээ хийв. Байгууллагын бүх компьютерт агентлагаас хорт кодоос сэргийлэх програмыг автоматаар шинэчлэн уншуулахад алдаа гарч уншаагүй 5 компьютерт гараар суулгав.







Цахим шилжилтийн сарын аяны онцлох ажлуудын агентлагын хурал дээр танилцуулах тайланг бэлтгэв. Агентлаг руу байгууллагын компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмжийн судалгааг цахим шуудангаар болон албан тоотоор илгээв. Байгууллагын Фэйсбүүк групп болон чатад “Байгууллагын мэдээлэл, технологийг ашиглах журам”-ын төслийг байрлуулж, албан хаагчдаас санал авч, нэгтгэн албан тоотоор илгээв. Агентлагаас зарласан Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 2 сарын аяны үеэр хийх ажлуудын саналыг алба хаагчдаас авч нэгтгэн, хуваарийн дагуу мэдээллийг оруулж, тайланг илгээв. Байгууллагын Google group үүсгэн, бүх албан хаагчийг бүртгэн, 3 албан хаагчид manager-н эрх олгож, хэрхэн ашиглахыг зааж өгөв.





| | |
|---|---|
| Хариу өгсөн огноо | 2022/07/07 Пүрэв гариг |
| Хариулсан хэлбэр | Албан бичгээр 456/0 Хариу бичгийн дугаар |
| Хамаарах эрхийн акт | ЕТГ Албан тоот |
| Хэрхэн шийдвэрлэсэн | Төсөлд өгөх саналыг албан хүргүүлэв. |
| Бичгийг хаасан | Б.Батбаяр - Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн |



## 3.2. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

### 3.2.1. Өргөдөл шийдвэрлэлт

2022 оны 1 сарын 01-ний өдрөөс 12 сарын 12-ны өдрийн хооронд абле программд нийт 1305 албан бичиг /хариутай 1015/, 340 өргөдөл /хариутай 288/ ирсэнээс 788 албан бичиг, 257 өргөдөл шийдвэрлэн, 227 албан бичиг, 31 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

ГХБХБГ-аас 2021 оны 1 сарын 01-ний өдрөөс 12 сарын 12-ны өдрийн хооронд нийт 860 албан бичиг явуулж, 61 даргын тушаал батлагдсан байна.*Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:*

**График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл**







Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг 1-р улиралд аймгийн ЗДТГ-н ТЗУХ-т 2022.03.23-ны өдрийн 152 албан бичгээр хүргүүлсэн. 2-р улирлын мэдээг 6 сарын 25-ны дотор хүргүүлнэ. Мөн сар тутмын мэдээг байгууллагын тайланд нэгтгэж байна.

- Үндэсний архивын газрын даргын 2007 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ыг ишлэл болгон 2022 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг боловсруулан ББНШК-оор хэлэлцүүлж, газрын даргаар батлуулсан.
- Баримт бичгийн MNS5140 - 2021 стандартын 3 ботийг авч албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд хэрэглэж байна.



- Дархан-Уул аймгийн Архивын тасагт 2022.05.12-ны өдрийн 284 албан бичгээр ГХБХБГ-ын хэвлэмэл хуудас хянуулах хүсэлт хүргүүлсний дагуу 015 хувийн дугаартай

Улсын байцаагч Н.Баярбаатараар хэвлэмэл хуудасны эх загварыг хянуулж, хэвлүүлэх зөвшөөрөл авсан. Аймгийн Архивын тасгийн 2022.05.24-ны өдрийн Зохион байгуулалтын баримт бичгийн нэр төрлийн 054, 055, 056 дугаарын бүртгэлд бүртгэгдсэн байна.


ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
АРХИВЫН ТАСАГ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРТ

Танай байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсыг "Зохион байгуулалт, захиргаажуулалын баримт бичиг MNS 5140:2021" стандартын шаардлагад нийцүүлэн эх загварыг баталгаажуулж хүргүүллээ.
Хавсралт: Хэвлэмэл хуудасны эх загвар.... хуудас.

ДАРГА Н.БАЯРБААТАР





## 3.2.2 Архивын үйл ажиллагаа

Байгууллагын архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 заалттайгаар 2022.03.01-нд газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу архивын баримт цахимжуулах, нөхөн бүрдүүлэлт хийх, бүртгэл хөтлөх, архивын баримтаар үйлчлэх, хадгаламжийн сангийн ариун цэврийг хангах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.


БАТЛАВ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Д.БАТЧУЛУУН
20... оны ... дугаар сарын ... өдөр

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2022 ОНЫ АРХИВЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
/2022.01.02 - 2022.12.31/

Дархан хот

| № | Ажлын төрөл | Хэмжих нэгж | Ажлын хэмжээ | Ажлын цагийн тооцоо | Гүйцэтгэх хугацаа | Гүйцэтгэгч | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Удирдлагын баримтаас скайнердах ажлыг гүйцэтгэнэ | ХН / х | 15 ХН, ойр 3000 х | - | 2022.01.02-2022.12.10 | Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан, бусад алба хаагч | |
| | Цахим мэдээллийн сангийн тоо бүртгэл, жагсаалтыг гаргах /mb/-аар, бүртгэл хөтлөх журмыг хэрэгжүүлнэ | mb | 1 бүртгэл | | | | |
| 2 | Архивын үйл ажиллагаанд шинээр хөгжүүлсэн архивын программыг нэвтрүүлэх | | 1 программ | - | 2022.01.03-2022.12.10 | Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан | |
| 3 | Байгууллагын ББНШК-ын хурлыг зохион байгуулж архивын баримтын бүртгэлийг батлуулах | Тоо/ш | 1-2 удаа | - | 2022.01.03-2022.12.10 | Хариуцсан мэргэжилтэн; ББНШК-ын гишүүд | |
| 4 | Архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, өөрчлөлт хөдөлгөөний мэдээ гаргах, холбогдох газруудад хүргүүлэх | Тоо/ш | 1 мэдээ | - | 2022.01.03-2022.12.20 | Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан | |
| 5 | Хадгаламжийн сангийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм баримталж ажиллах | | тухай бүр | - | 2022.01.02-2022.12.20 | Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан | |
| 6 | Архивын баримт ашиглуулах, төлбөрт үйлчилгээ явуулах журам, түүнийг хэрэгжүүлж ажиллана. - Байгууллагын хэрэгцээнд архивын баримтыг ашиглуулна | Тоо/х | 2 бүртгэл /тухай бүрт/ | - | 2022.01.02-2022.12.20 | Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан | |


ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: Ц.ЦЭНД-АЮУШ /АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АРХИВЫН АЖИЛТАН/

2020 оны архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын талаарх мэдээг 2022.01.10-ны 09 тоот бичгээр ГЗБГЗЗГ-т, 10 тоот бичгээр аймгийн Архивын тасагт хүргүүлсэн. 2021 оны архивын баримтын бүрэлдэхүүн, хөдөлгөөний мэдээг 2023.01.10-нд багтаан ГЗБГЗЗГ-т хүргүүлэхээр төлөвлөсөн.


ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2022.01.10 № 09

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАРТ

Архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын талаарх мэдээг хавсралтаар хүргүүлэв.
Хавсралт 7 хуудастай.

ДАРГА Д.БАТЧУЛУУН


Хавсралт 6

Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

БАРИМТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ТОО ХЭМЖЭЭ, ХАДГАЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ
/2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/

1. Ерөнхий мэдээлэл
Архив байгуулсан эрх зүйн актын нэр, огноо, дугаар: Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын архив Дархан-Уул аймгийн Архивын тасгаас 2015.09.16-нд 08 дугаартай байгууллагын "Архивын гэрчилгээ"-г олгосон.

Харьяалах төрийн архив: Дархан-Уул аймгийн Архивын тасаг

Ажилтны тоо: 1 Үндсэн:1 Өөр ажилтай хавсран гүйцэтгэж буй- Бичиг хэрэг, Нярав

2. Баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ: Хөмрөг 115 ХН - 1163

2.1. Үндсэн хөмрөгийн баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ

| Үзүүлэлт | | Хөмрөгийн тоо | Хадгаламжийн нэгжийн тоо: Нийт | Эхэлсэн он | Дууссан он | Үнэ цэнэ: Нууц | Үнэ цэнэ: Хосгүй үнэт | Тухайн онд бүрдүүлсэн ХН-ийн тоо | Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан: Төрийн архивт шилжүүлэх | Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан: Устгах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. | 9. | 10. |
| Цаасан суурьтай баримт | | | | | | | | | | |
| Удирдлагын баримт | Байнга | 1 | 680 | 2003 | 2020 | 0 | 0 | 32 | - | - |
| | Түр | 1 | 465 | 2009 | 2020 | 0 | 0 | 48 | - | 9 |
| | 70 жил | 1 | 18 | 2011 | 2020 | 0 | 0 | 2 | - | - |
| Хувийн гаралтай | | 0 | - | - | - | - | - | - | - | - |
| Зураг төслийн баримт | | 0 | - | - | - | - | - | - | - | - |
| Кино, дуу дүрсний баримт | | 0 | - | - | - | - | - | - | - | - |

2021 онд хөтөлж дууссан ГУХ-ээс ГНС, ГЗБТөлөвлөгөө, түүний хэрэгжилт, дуудлага худалдааны тайлан гэсэн нийт 7 баримт, БХБХ-ээс ашиглалтад хүлээн авсан барилгын 25 баримт, Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнээс 6 баримт, Нягтлан бодогчоос 9 баримт, бичиг хэргээс 5 баримт, няраваас 22 баримтыг нийт 74 баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн






Мөн дотоод хэрэгцээнд мэргэжилтнүүдэд 2022 онд өөрчлөлт орсон 252 хувийн хэрэг ашиглуулж, нөхөн бүрдүүлэлт хийгдсэн байна. Архивийн 5 дугаар заагуур болох Гаражийн хувийн хэрэг байдаг заагуурын бүх хувийн хэргийг авч нөхөн бүрдүүлэлт хийсэн.


Хувийн хэрэг захиалга Ц.Чулуунцэцэг 2022.03.16


2022-03-14 өдөр 30 ш газар эзэмшүүлэх гэрээ хүлээлгэн өгөв

- Хадгаламжийн сангийн чийг, дулааны үзүүлэлтийг сард 2 удаа хөтөлж байна. Мөн хадгаламжийн санд чийгтэй цэвэрлэгээг нийт 6 удаа хийсэн.



**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хадгаламжийн сангийн чийг, дулаан хэмжилтийн тэмдэглэл**

| Д.Д | Огноо | Чийг /%/ | Дулаан /C/ | Ажилтны нэр, гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2022.01.04 | 35 | 15 | | |
| 2 | 2022.01.26 | 50 | 12 | | |
| 3 | 2022.02.01 | 45 | 14 | | |
| 4 | 2022.02.24 | 40 | 14 | | |
| 5 | 2022.03.10 | 50 | 16 | | |
| 6 | 2022.03.25 | 55 | 16 | | |
| 7 | 2022.04.04 | 45 | 16 | | |
| 8 | 2022.04.21 | 50 | 16 | | |
| 9 | 2022.05.05 | 50 | 15 | | |
| 10 | 2022.05.27 | 45 | 10 | | |
| 11 | 2022.06.06 | 40 | 18 | | |
| 12 | | | | | |
| 13 | | | | | |
| 14 | | | | | |
| 15 | | | | | |
| 16 | | | | | |
| 17 | | | | | |
| 18 | | | | | |
| 19 | | | | | |
| 20 | | | | | |

➕ Энэ оны 3-р сард газрын даамлуудад тус бүр ГЗБГЗЗГ-аас өгсөн нэгж талбарын хувийн хэргийг аймагт төвлөрүүлэх талаар танилцуулж, сум тус бүрийн нэгж талбарын хувийн хэргийн тоон мэдээллийг гаргуулж, нэгтгэсэн. Үүнд аймгийн хэмжээнд өмчлөлийн 13756 /Дархан 9564, Орхон 2104, Хонгор 1173, Шарын гол 915/, эзэмших болон ашиглах эрхийн 7197 нэгж талбарын хувийн хэрэг байна. Газрын даамлууд нь ГЗБГЗЗГ-ын даргын 2016 оны А/169 тушаалын дагуу нэгж талбарын хувийн хэргийг хөтөлж ажиллаж байна.

Орхон сумын хувийн хэргийг татахаар төлөвлөсөн болович нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн ажлаас шалтгаалж хойшилсон.

**Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын Цаасан суурьтай нэгж талбарын хувийн хэргийг цахимжуулах ажлын төсөл**

Дархан сум 2022.03.02

➕ Цахимжуулах шаардлагатай цаасан суурьтай нэгж талбарын хувийн хэргийн нийт дүн:

| № | НТХХ-ийн төрөл | Дархан | Орхон | Хонгор | Шарын гол | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Иргэн /эзэмших/ | 762 | 621 | 1108 | 140 | **2631** |
| 2 | АОС | 1500 | 0 | 0 | 0 | **1500** |
| 3 | ААНБ /эзэмших/ | 680 | 48 | 393 | 76 | **1197** |
| 4 | Гараж /эзэмших/ | 1340 | 0 | 20 | 209 | **1569** |
| 5 | Төрийн байгууллага /эзэмших/ | 209 | 20 | 15 | 18 | **262** |
| 6 | Ашиглах | 34 | 0 | 1 | 3 | **38** |
| 7 | Өмчлөх | 9564 | 2104 | 1173 | 915 | **13756** |
| | **Нийт** | **14089** | **2793** | **2710** | **1361** | **20953** |

➕ ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, эрх зүйн акт” сэдэвт сургалтанд 2022.03.22-нд, аймгийн Төрийн архиваас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “Баримт бичгийн стандарт” сэдэвт сургалтад 2022.04.28-нд, “Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, “Баримт бичгийн стандарт”, “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүй” сэдэвт сургалтад 2022.05.13-нд тус тус хамрагдсан.





Мөн ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан сургалтын материалыг ашиглан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” сэдвээр албан хаагчдын өдөр тутмын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд анхаарах асуудал болон дутуу хэрэглэгдэж буй журмын заалтуудыг тайлбарлахаар 49 хуудастай PP бэлтгэсэн. Сургалтыг 4-р сард зарласан боловч бүрэлдэхүүн дутуу тул хойшлогдсон, энэ 6-р сард сургалт өгөхөөр төлөвлөсөн.

# 3.3 САНХҮҮ ТӨСӨВ

Энэхүү тайлангаар 2022 оны 1 сарын 1-ээс 2022 оны 12-р сарын 31-ний хоорондох санхүүгийн тайлант жилийн ГХБХБГазрын санхүүгийн байдал, үйл ажиллагааг харуулсан болно.

Аймгийн ГХБХБГазрын дарга Д.Батчулуун, нягтлан бодогч Б.Мөнхзул нар 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд 1, 2-р гарын үсэг зурж, 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг байдлын хувьд үнэн зөв илэрхийлж, “Төсвийн тухай” хуулийн заалтын дагуу үнэн зөв тусган, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэн ажиллаа. Тус байгууллага нь тайлант жилийн хугацаанд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 18, үйлчлэх ажилтан 2 нийт 21 орон тооны бүрэлдэхүүнтэй албан үүргээ гүйцэтгэлээ.

### 3.3.1. Үйл ажиллагааны зардал

*Үйл ажиллагааны зардлын 100190029001 дансны тухай*

- 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн Улсын төсвөөс 310,1 сая төгрөгийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулсан.

- 2022 оны олгогдсон 310,1 сая төгрөгийн санхүүжилтын **79,4%** нь цалингийн сан, **9,9%** нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, **10,6%** нь тогтмол зардал болон бусад зардлууд эзэлж байна.




Батлагдсан төсвийн хуваарийн дагуу Төрийн сангийн 100190029001 дансаар 310,1 сая төгрөгийн санхүүжилт авч 320,0 сая төгрөг зарцуулж ажиллаа.







2022 оны 1-12-р сарын Төсвийн санхүүжилт, зарцуулалтын тайланг өссөн дүнгээр сар бүрийн 01-ны байдлаар гаргаж тогтмол боловсруулж САРЫН мэдээг ГЗБГЗЗГазарт цахимаар хэлбэрээр хүргүүлэн зардал болон үлдэгдлийг баталгаажуулж ажилласан.

Сарын мэдээнд:

- Үндсэн үйл ажиллагааны дансны
- Нэмэлт санхүүжилтын дансны
- Авлага өглөгийн дэлгэрэнгүй мэдээ зэргээс бүрдэн тайлагнадаг. **Нийт 12 удаа мэдээлсэн.**

- Төсвийн ил тод, Шилэн дансны хуулийг мөрдөж сар бүрийн 2-ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn сайтад нийт 12 удаа шивж оруулсан. Үүнээс гадна Төсвийн ил тод хуулийг мөрдөж сар бүрийн 2 дансны орлогыг ангилж боловсруулсан мэдээ, эхний хагас жилийн тайланг төрийн сангаар баталгаажуулан ГЗБГЗЗГазарт цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлсэн. Санхүүгийн тайланг санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан нийтэд тогтмол шинэчилэн ил тод мэдээлж байна. Албаны сайтад сарын мэдээг скайнердан pdf файлаар хавсаргаж мэдээлсэн.

Цаг үеийн мэдээ тайлангуудыг заагдсан хугацаанд багтааж гүйцэтгэлийн тайлан, хугацаат мэдээ, судалгаануудыг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь олгож ажилласан бөгөөд батлагдсан төсвийн хүрэлцээгүйгээс хоол унааны хөнгөлөлт, томилолтын зардлуудыг бүрэн олгож чадаагүй. ГЗБГЗЗГазрын даргын 2019 оны Б/123 дугаар тушаалыг үндэслэн 2022.01.02-ний өдрөөс нийт 21 ажилтан албан хаагч ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын цалинг сард 2 удаа тогтоосон хугацаанд /Сар бүрийн 10, 25-нд/ олгож, албан хаагчдын сарын цалин, тэтгэмж, урамшуулал, хоол унааны хөнгөлөлтийг олгож ажиллаж байна. Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр олгодог бөгөөд ТАЦНС нь Хүний нөөцийн удирдлагын системтэй нягт холбоотой бөгөөд албан хаагчдын мэдээллийг бүрэн агуулсан систем юм. Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу батлагдсан төсвийн хүрээнд ажилласан.




Мөн жилийн эцсийн байдлаар байгууллагын албан хаагчдын буюу даатгуулагч нарын цалингийн НДШимтгэлд өссөн дүнгээр 30,8 сая төгрөг шилжүүлсэн. НДШимтгэлийн тооцоо тайланг сар бүр даатгуулагч бүрийн мэдээллийг www.ndaatgal.mn сайтад бүртгэлийн дагуу онлайнаар тайланг шивж тоон гарын үсгээр баталгаажуулж илгээдэг болсон мөн цаасан хэлбэрээр баримтжуулж тайлагнасан. Сар бүрийн 5-ны дотор ажилтан бүрийн цалингийн нийгмийн даатгалын шимтгэлийг Маягт НД-7, НД-8–ын дагуу **12 удаа** хийж гүйцэтгэсэн.

Татварын хэлтэст цахим тайлангийн системээр заагдсан хуулийн хугацаанд илгээж ажилласан. Үүнд:

a. Цалин хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан /Улирал бүр нийт **4** удаа/

b. Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайлан /Улирал бүр нийт **4** удаа/

ТАЦНСистемээс татварын тайланг онлайнаар илгээдэг болсон нь цаг хугацаа, бичиг хэргийн зардал хэмнэдэг болсон. 2022.12.31-ний гүйцэтгэлээр **17.3 сая** төгрөгийн цалингийн ХХОАТатвар шилжүүлсэн байна.




Татвар, нийгмийн даатгал болон дансны өр авлагагүй ажилласан.

Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Тоёото Бервис маркийн суудлын автомашин нь 2021 оны 9 сараас эвдэрч зогссон бөгөөд ТӨБЗГазарт хүсэлт хүргүүлсний дагуу дуудлага худалдаагаар худалдахаар дуудлага худалдааг зарласан. Дархан-Уул аймгийн ЗДТГазраас үнэ төлбөргүй ашиглах гэрээгээр Прадо-120 маркийн машиныг байгууллагын хэрэгцээнд ашиглаж шатахууны тооцоог хийж байгаад 2022 оны 9 сард ашиглах гэрээ дуусгавар болж автомашиныг буцааж хүлээлгэн өгсөн. 2022 оны 8 сар хүртэл жолоочтой шатах тослох материалын тооцоог дараа сарын нэгнээр тасалбар болгон замын хуудас холбогдох материалыг хүлээн авч тооцоо бодож түүнийг үндэслэн ирэх сарын гүйлгээний баримтыг цаг тухайд нь хийж шатахуун олгох ажлыг зохион байгуулж, автомашины хувийн хэрэг хөтөлж ажилласан. Мөн шаардахаар жолооч болон байгууллагын албан хаагчдад шатах тослох материалын 4,7 сая төгрөгийн талон олгож гүйцэтгэлийг сар бүрийн эцсээр тайлан гаргуулсан. Шунхлай петролиум ХХК тай гэрээний дагуу шатахууны талон авч ажилласан.

Албан томилолтыг Төрийн хэнмнэлтийн хуультай холбоотойгоор 2022 оны 5 сарын тодотголоор төсвийн хуваарьт өөрчлөлт хийгдэж тухайн зардлыг тэвчиж болох зардалд тооцон тодорхой хэсгийг буцаан татсан.

Газрын даргын 2022 оны А/03 дугаар тушаалын хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлэхээр нийт 22 албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг тухай бүр нь олгосон байна. Амралт авахын өмнө орлон гүйцэтгэх ажилтантай ажлаа хүлээлцэх тойрох хуудас бөглөн ээлжийн амралтын цалинг олгодог.

### 3.3.3. Үйл ажиллагааны орлого

*Үндсэн үйл ажиллагааны орлогын 100190029003 дансны тухай*

Төрийн сан банкны 100190029003 тоот дансаар орох Төсвийн орлогын төлөвлөгөө 2022 онд газрын болон барилгын техник хяналтын үйл ажиллагааны орлогоос 60,0 сая төгрөгийн төлөвлөгөөтэй. Газрын харилцаа цахим хэлбэрт шилжсэн.

Үнээс: 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Газрын хуульд заасан хэлбэрээр эзэмших

- Кадастрын мэдээллийн санд баталгаажуулалт хийх – 5,2 сая төгрөг,
- нэгж талбарын хувийн хэрэг - 7,8 сая төгрөг,
- Барилга захиалагчийн хяналтын орлого – 27,9 сая

Нийт 60,0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон.

Дээрх нийт үйл ажиллагааны орлогыг сар бүрээр ангилан төсвийн ил тод самбарт шинэчилэн мэдээлж байна.

*Нэмэлт санхүүжилтын 100190029401 дансны тухай*

Аймгийн Төрийн сан банкны 100190029401 тоот нэмэлт санхүүжилтийн дансаар 2022.12.31-ны байдлаар 3,8 сая төгрөгийн орлого орж тухайн орлогоор байгууллагын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс байгууллагын үүдний гонхыг засварласан.

*Газрын дуудлага худалдааны орлогын 100190000967 дансны тухай*

2022 онд Дархан сумын хэмжээнд газар эзэмших эрхийн ДУУДЛАГА ХУДАЛДАА зохион байгуулагдаагүй бөгөөд дуудлага худалдааны анхны үнийн 363,5 сая төгрөгийн орлогыг аймгийн орлогын дансанд төвлөрүүлж аймгийн орлогыг бүрдүүлж ажилласан.

### 3.3.3. Шилэн данс

ГХБХБГ-аас төрийн үйлчилгээг ил тод болгох Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж тухай бүр болон сар улирал, жилийн мэдээ тайланг www.shilendans.gov.mn сайтад хуулийн хугацаанд нь байршуулж, ГХБХБГ-ын төсвийн ил тод самбарт болон www.darkhan.gazar.gov.mn цахим хаягт мэдээлж байна. Мөн албаны сайтад шилэн дансыг холбон мэдээлэв.




Байгууллагын төв хаалганы дэргэд санхүүгийн ил тод байдлын самбар ажиллуулж сар бүр орлого зардлын мэдээг шинэчилж байршуулсан. Шилэн дансны хуулийн дагуу иргэдэд долоо хоног, сар, улирал, жилийн төсөв мөнгө хөрөнгөтэй холбоотой тушаал, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг шинэчилж шивэн оруулж файлаар хавсаргасан.

2022 оны жилийн эцсийн байдлаар 68 удаагийн мэдээллийг мэдээллийн самбарт байршуулж иргэдэд мэдээлсэн байна.

2022 оны жилийн байдлаар 145 удаагийн мэдээллийг шилэн дансанд оруулж иргэдэд мэдээлсэн байна.




| Нэр | Мэдээлэл оруулах давтамж | Нийт мэдээллэх | |
|---|---|---|---|
| **Дараа жилийн төсвийн төсөл** | Бүтэн жил | 2 | Хуулийн хугацаанд нь мэдээлсэн. |
| **Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт** | Тухай бүр | 12 | Хуулийн хугацаанд нь мэдээлсэн. |
| **Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл** | Тухай бүр | 12 | Тендерийн арга хэмжээ байхгүй байхгүй тухай мэдээлсэн. |
| **Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл** | Тухай бүр | 12 | Тендерийн арга хэмжээ байхгүй байхгүй тухай мэдээлсэн. |
| **Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг** | Тухай бүр | 12 | Хуулийн хугацаанд нь мэдээлсэн. |
| **Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ** | Тухай бүр | 12 | Цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого зарлагыг мэдээлсэн. |
| **Санхүүгийн тайлан** | Хагас жил | 2 | Хагас жилийн тайланг шилэн дансанд мэдээлсэн. |
| **Худалдан авах ажиллагааны тайлан** | Хагас жил | 6 | Худалдан авах ажиллагаа байхгүй тухай мэдээлсэн. |
| **Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт** | Сар бүрийн 8-ны дотор | 6 | 8 удаа шилэн дансанд мэдээлсэн. |

Байгууллагын ЭБАТ-аас- Ашиг сонирхолын зөрчилгүй гэсэн мэдэгдлийг хүлээн авч шилэн дансанд PDF файлаар **12 удаа** мэдүүлэв.



Тухай бүр:



Сар бүр:



Улирал бүр:




Хагас жил бүр:




Бүтэн жилээр:



Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт, ГХБХБГ-ын даргын өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай үед нь хэрэгжүүлэн, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хугацаатай, хариутай албан бичиг, мэдээ тайланг тухайн цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн.

ГЭРЭЭТ АЖИЛ:

Тэнгэрийн бүргэд ХХК-тай 2022 оны 01-р сарын 10-ний №2203, 2205 тоот харуул хамгаалалтын гэрээгээр харуул Р.Цэнгэлсайхан ажиллаж байна.

Шунхлай Петролиум ХХК-тай 2022 оны 01-р сарын 01-ний №Да/21-61 тоот гэрээгээр шатахууны мөнгөн талоны зээлээр худалдах, худалдан авах гэрээгээр ажиллаж байна.

### 3.4.4. Санхүү нягтлан бодох бүртгэл

*Санхүү нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр*

Санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг хэрэглэсэн болно.

Улирал жилийн тайлан, тэнцлийг хийж гүйцэтгэн хянуулах, гүйлгээ баланс, журнал, дэлгэрэнгүй бүртгэл, хөрөнгийн тодруулгыг гарган тулган шалгуулж баталгаажуулсны дараа нэгтгэлийн тайланд өгдөг.

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан маягт зааврын дагуу хөтөлж байгаа. Санхүү төсвийн сахилгын зөрчилгүй ажилласан.

Бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартад нийцсэн нэгдсэн программд оруулж тайлагнадаг. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан тэнцэл гаргахад санхүүгийн “ACOLOUS” программыг үр дүнтэй ашиглан ажиллаж байна.






Төрийн сангийн үйл ажиллагааны
журмын 1 дүгээр хавсралт
Маягт №ТТ-1

ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № 152

2016 оны 9 сарын 28 өдөр

| | | |
|---|---|---|
| Байгууллагын нэр: **Дархан-Уул аймгийн ГХБХБГазар** | *Дансны дугаар* | **2,098,960.00** |
| *Регистрийн дугаар:* **9025049** | **190029001** | |
| Хүлээн авагчийн нэр: **Нийгмийн Даатгалын хэлтэс** | *Дансны дугаар* | |
| *Регистрийн дугаар:* **9023194** | **190090000** | |
| *Хүлээн авагчийн банк:* **Төрийн сан банк** | | |
| *Мөнгөн дүн үсгээр:* *Хоёр сая ерэн найман мянга есөн зуун жаран төгрөг 00 мөнгө* | Ангилал | |
| Гүйлгээний утга: *9-р сарын цалингийн НДШ* | 71504 - Газрын зураглал, кадастр | |
| | 80103 - Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | |
| | *210105 - Гэрээт ажлын цалин* | 203,836.00 |
| | *210201 - Тэтгэврийн даатгал* | 224,220.00 |
| | 80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал | |
| | *210101 - Үндсэн цалин* | 822,277.00 |
| | *210201 - Тэтгэврийн даатгал* | 848,627.00 |

*Хяналтын хуудас №: 152*

| Үндэслэх бичиг баримтын нэр | | Он сар, дугаар | Төрийн сангийн тэмдэглэгээ |
|---|---|---|---|
| 1 | 9-р сарын цалингийн дунгээр | 2016,09,22 | |

Тамга

Дарга: ................................ /Д.Ганбаяр/

Нягтлан бодогч: ...................... /Б.Мөнгөнтогос/

Төрийн санд гүйлгээ хийсэн

...... оны .... сарын .... өдөр

тэмдэг, гарын үсэг

2022 оны 04 сарын 29-ний өдрөөс 2022 оны 06 сар хүртэл Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажил явагдсан бөгөөд тооллогын ажлыг ГХБХБГазрын даргын 2022 оны А/09 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хийж гүйцэтгэн мэдээ тайланг цахимаар илгээж ажилласан. Төрийн өмчийг эзэмших 2022 оны гэрээг байгуулан 2021 оны гэрээг 94% тай дүгнүүлж ажиллалаа. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч завсарлах, ашиглагдах боломжгүй хөрөнгүүдийн жагсаалтыг гарган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүсэлт илгээн зөвшөөрлийг авч 14 нэр төрлийн 8,8 сая төгрөгийн хөрөнгийг акталж устган тайланг хугацаанд нь гарган хүргүүлсэн. Мөн байгууллагын гадна автозогсоол, маргаантай газрын асуудлыг ТӨБЗГазарт хүсэлт хүргүүлж шийдвэрлэсэн. Бараа материалын хувьд эхэлж авсанаа эхэлж зарлагадах аргыг ашиглаж байна. Бараа материалын оны эхний үлдэгдэл 35,2 сая төгрөг ба өөрийн санхүүжилтээр авсан бараа материал 11,4 сая төгрөгийн орлого авч,

шаардах хуудсаар олгосон бараа материал 14,4 сая төгрөгийн зарлага, 32,2 сая төгрөгийн үлдэгдлээр данс бүртгэлтэй байна.

2022 оны 6 сард төлбөрийн цахим портал системийн хөгжүүлэлтэнд туршилтын байгууллагаар оролцож төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Мөн шилэн дансны шинэ цахим системд бүртгүүлж, баталгаажилт хийгдэж 2023 оны 01 сарын 01-ээс ашиглахаар бэлдэж байна.

### 3.4.5. Нярав

325 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж, газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. 1 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас гологдол байсан тул Цэндээд буцааж өгөв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 925 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 1070 ширхэгийг хүлээж авч бүртгэв.






Шаардах хуудсаар 81 төрлийн 816 ширхэг бараа материал олгов. 2021 оны 12-р сар, 2022 оны 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11-р сарын бараа материалы, нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайланг нэгтгэж ня-бод өгөв. Агентлагаас ирсэн 10 ширхэг тусгай хэрэгцээний газар ашиглах гэрчилгээг хүлээж авав. 2021 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын мэдээлэл дээр үндэслэн албан хаагчдын үндсэн хөрөнгө, бараа материалын картын мэдээллийг засварлав. Иргэн, ААНБ, ТБ-ын газар эзэмших гэрчилгээ, ААНБ, Иргэний газар ашиглах гэрчилгээний 2021 оны зарцуулалтын нэгтгэлийг гаргаж, үлдэгдлийг тоолж, хүлээлгэн өгөхөд бэлтгэв.

Хонгор сумын газрын даамлаас 2021 оны Нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайлан, 2022 оны 1-9-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайлан, 2021 оны 11, 12-р сарын, 2022 оны 1-9-р сарын кадастрын өөрчлөлтийн төлбөрийн баримтын тайланг шалгаж, хүлээн авав.

2021 оны 1-3 сар, 9-10 сарын кадастрын үнэт цаас, 2021 оны 1-2 сар, 6-8 сар, 9-10-р сарын газар эзэмших эрхийн гэрчилгээ /Иргэн/, 2021 оны газар эзэмших, ашиглах гэрчилгээ /ААНБ, ТБ/ зарцуулалтын тайлан, 2021 оны ААНБ-ын Улсын тэмдэгтийн хураамжийн тайлан, 1-4 сар, 5-7 сарын Иргэний Улсын тэмдэгтийн хураамжийн тайлан, 2021 оны 9-12-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн хавтасны зарцуулалтын тайлан, 2021 оны 8-10-р сарын Улсын тэмдэгтийн хураамж /Иргэн/-ийн нэгтгэлийн тайлан, 2022 оны 1-4-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайлан, 2022 оны 5-8-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайлан, 2022 оны 1-5-р сарын Кадастрын өөрчлөлтийн төлбөрийн баримтын тайланг үдэж, хавтаслан, хуудсыг дугаарлаж архивт хүлээлгэн өгөв. г үдэж, хавтаслан, хуудсыг дугаарлаж архивт хүлээлгэн өгөв.






ДОТООД ТОВЪЁОГ
ГХБХБГ-ын Иргэний
Улсын тэмдэгтийн хураамжийн тайлан

2021 оны 5-7-р сар

| № | Үнэт цаасны дугаар | Сумын нэр | Огноо | Тоо | Хуудасны дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 140431-140440 | Дархан | 2021-05-07 | 10 | | |
| 2 | 140441-140510 | Хонгор | 2021-05-07 | 70 | | |
| 3 | 140511-140540 | Дархан | 2021-05-14 | 30 | | |
| 4 | 140541-140610 | Хонгор | 2021-05-14 | 70 | | |
| 5 | 140611-140630 | Дархан | 2021-05-18 | 30 | | |
| 6 | 140631-140700 | Орхон | 2021-05-18 | 70 | | |
| 7 | 140701-140749 | Дархан | 2021-05-31 | 49 | | |
| 8 | 140750-140770 | Дархан | 2021-06-04 | 21 | | |
| 9 | 140771-140840 | Хонгор | 2021-06-08 | 70 | | |
| 10 | 140841-140900 | Дархан | 2021-06-23 | 60 | | |
| 11 | 166001-166011 | Дархан | 2021-06-23 | 11 | | |
| 12 | 166012-166081 | Хонгор | 2021-06-25 | 70 | | |
| 13 | 166082-166088 | Дархан | 2021-06-25 | 7 | | |
| 14 | 166089-166116 | Дархан | 2021-07-09 | 28 | | |
| 15 | 166117-166186 | Хонгор | 2021-07-09 | 70 | | |
| 16 | 166187-166226 | Дархан | 2021-07-31 | 40 | | |
| 17 | Нийт | | | 706 | | |

Дүн ______________________ баримт бичиг бүртгэв.

Дотоод товъёог үйлдсэн: Э.Түмэнжаргал




Мониторингийн ажилд зориулан агентлагаас ирүүлсэн аппаратыг Суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэж өгөв.

## 3.4. ХҮНИЙН НӨӨЦ, ДОТООД АЖИЛ

### 3.4.1 Сургалт, зөвөлгөөн

Дархан_Уул_аймгийн_Газрын_харилцаа_Барилга_хот_байгуулалтын_газар "Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2022", "Дархан барилга экспо-2022" боллоо

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2022" Дархан-Уул аймагт боллоо. Зөвлөгөөнд Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, аймаг орон нутгийн удирдлагуудыг хамруулсан 60 гаруй төлөөлөл оролцож, салбарын бодлого, хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, хэрэгжиж буй төсөл хөтөлбөр зэрэг өргөн сэдвийн хүрээнд зөвлөлдөв. Мөн зөвлөгөөний үеэр "Дархан барилга экспо-2022" үзэсгэлэнг зохион байгууллаа.

Барилга угсралт, бүтээн байгуулалт, материал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 26 иргэн, хуулийн этгээд оролцож, Дархан-Уул аймгийн иргэдэд орон сууцны үнэ ханш, барилгын материалын үнийн мэдээллийг хүргэж ажиллав.

Төр, хувийн хэвшлийн оролцоотой хамтран "Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2022", "ТӨВИЙН БҮСИЙН БАРИЛГА EXPO 2022" зохион байгуулсан.

Зөвлөгөөнд Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, аймаг орон нутгийн удирдлагуудыг хамруулсан 60 гаруй төлөөлөл оролцож, салбарын бодлого, хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, хэрэгжиж буй төсөл хөтөлбөр зэрэг өргөн сэдвийн хүрээнд зөвлөлдсөн. Мөн зөвлөгөөний үеэр "Дархан барилга экспо-2022" үзэсгэлэнг зохион байгуулагдсан.

Барилга угсралт, бүтээн байгуулалт, материал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 26 иргэн, хуулийн этгээд оролцож, Дархан-Уул аймгийн иргэдэд орон сууцны үнэ ханш, барилгын материалын үнийн мэдээллийг хүргэж ажиллав. Арга хэмжээний үеэр байрны хөнгөлөлт эдлэх 34 иргэнд эрхийн бичиг гардуулсан.//2022.04.16 болон 2022.05.28-29-ны өдрүүд/

- Орхон аймгийн Засаг даргын санаачилгаар "Дахин төлөвлөн барилгажуулах дэд бүтэцжүүлэх төслүүд" улсын анхдугаар зөвлөгөөнд 1 өдөр оролцсон.






- Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулсан Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан 2022.10.27-29 өдрүүдэд оролцсон.



- Барилгын салбар дахь авилгын эрсдэл ба инженерийн ёс зүйн хэлэлцүүлэгт 2022.11.23 оролцсон.






2022.02.25-нд Жайка /Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага/-аас зохион байгуулсан Барилгын салбар дах **Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мөчлөг ба өндөр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа** сэдэвтэй 8 цагийн сургалтанд хамрагдсан.



Гэрчилгээ

Батбаяр овогтой Монгонтогос нь

Монгол Улсын засгийн газар болон Жайка (Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага)-ийн хамтран хэрэгжүүлж буй "Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Барилгын Хөгжлийн төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулсан "ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ МӨЧЛӨГ БА ӨНДӨРТ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА" сэдэвтэй 8 цагийн сургалтанд хамрагдсан тул энэхүү гэрчилгээг олгов.

Т. ТҮВШИНЗУЛ
ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦЛИЙН МЭРГЭЖИЛТЭН, ХАБЗА-Н СУРГАГЧ БАГШ

Ч. ЧИНЗОРИГ
ТӨСЛИЙН СУРГАГЧ БАГШ, МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

2022 он



Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө

Нэг. Сургалтын нэр

Хоёр. Сургалтын үндэслэл

Гурав. Сургалтын зорилго

Дөрөв. Сургалтанд хамрагдах хүмүүс

Тав. Сургалтын төлөвлөгөө:



2022 он



2022.03.11 нд Салбарын бүтэц тогтолцоог оновчтой тогтоох, хууль эрхзүйн орчин, норм нормативын баримт бичгийг боловсронгуй болгох цахим сургалтанд оролцов.




2022.03.18-нд Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулсан Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр цахим сургалтанд оролцов.


















ТЕХНОЛОГИЙН ЗААВРЫН БҮТЭЦ, ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

| Д/д | Технологийн заавраын бүтэц |
|---|---|
| 1 | Гарчиг |
| 2 | Тухайн үйлдвэрийн товч танилцуулга |
| 3 | Зорилго |
| 4 | Тухайн үйлдвэрлэлийн хамрах хүрээ |
| 5 | Бүтээгдэхүүний техникийн шаардлага |
| 6 | Бүтээгдэхүүний тодорхойлолт-тухайн бүтээгдэхүүний стандартад нийцүүлэн тодорхойлох |
| 7 | Үндсэн түүхий эд материалын физик-механик, химийн шинж чанарын үзүүлэлт, техникийн шаардлага-/хүснэгтээр/ |
| 8 | Үйлдвэрлэлийн дотоод хяналт /Бүтээгдэхүүн болон түүхий эдийг өөрийн болон хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид давтан шинжлүүлэх хугацаар тодорхойлох/ |
| 9 | Технологийн дамжлагын бүдүүвч зураг |
| 10 | Технологийн үйл ажиллагаа-бүдүүвч зургийн дагуу тодорхойлох |
| 11 | Дулаан боловсруулалтын үндсэн тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны горим-графикаар харуулах |
| 12 | Үйлдвэрлэлийн бүтэц бүрэлдэхүүн, хүний нөөцийн мэдээлэл-схемлэх |
| 13 | Бүтээгдэхүүний чанарт гарч болзошгүй үл тохирол болон залруулах арга зам |
| 14 | Лабораторийн тоног төхөөрөмжийн тодорхойлолт, жагсаалт, фото зураг |
| 15 | Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, үйлдвэрлэлийн технологийн үндсэн тоног төхөөрөмжийн фото зураг |
| 16 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн /ХАБЭА/-ны арга техникийн үндсэн шаардлага |
| 17 | Түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүний мөрдөгдөх стандарт, нормативын бичиг баримтуудын жагсаалт |
| | Хавсралт материалууд |
| 18 | Түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ, орд газар эзэмшдэг бол түүний холбогдолтой материалын хуулбар |
| 19 | Технологийн заавар боловсруулсан болон технологийн үйлдвэрлэл хариуцсан инженерийн дипломын хуулбар |
| 20 | Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар |



ОРОН НУТГИЙН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ "ТОХИРЛЫН БАТАЛГААНД" ХАМРУУЛАХ ТАЛААР ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хэзээ: 2022оны 03сарын 18-ны өдөр 14:00 цагт цахимаар

Zoom ID: 933 444 9090

Zoom code: 123456

Хаана: Барилгын хөгжлийн төвийн хурлын заланд

ХӨТӨЛБӨР

| № | Хэлэлцэх асуудал | Хугацаа | Илтгэгч/ чиглүүлэгч |
|---|---|---|---|
| | Нээж үг хэлнэ | 5 мин | БХТ-ийн БМҮХ-ийн хэлтсийн дарга Д.Батням |
| 1 | Барилгын материалын үйлдвэрлэл, чанар хяналт | 20 мин | БХТ-ийн БМҮХ-ийн бүтээгдэхүүний баталгаажуулалт тохирлын үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Ундрам<br>БХТ-ийн БМҮХ-ийн технологийн заавар хариуцсан мэргэжилтэн Ч.Делгеен |
| | Асуулт, хариулт | | |
| 2 | "Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан" цахим системийн товч танилцуулга | 20 мин | БХТ-ийн БМҮХ-ийн барилгын салбарын технологи, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Н.Энхжаргал |
| | Асуулт, хариулт | | |

Жич: Аймгуудын барилгын материалын хэлтсийн дарга нар болон барилгын материал хариуцсан мэргэжилтэн нар хамрагдах боломжтой.

Сургалтанд хамрагдаж буй албан хаагч нар бүгд камераа өгч оролцох




Эрчим хүчний хэмнэлттэй, дасан зохиох чадвартай орон сууцны стратегийг хөгжүүлэх сэдэвтэй 2022 оны 9 сараас зохион байгуулсан Дэлхийн банкны цахим сургалтанд оролцсон.






Монгол Улсын засгийн газар болон “ЖАЙКА”/Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага/-ийн хамтран хэрэгжүүлж буй “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Дархан-Уул аймгийн ГХБХБГазраас төслийн баг болон Барилгын хөгжлийн төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтран “Аюулын дүн шинжилгээ хийх Япон маягийн тэргүүн туршлага” сэдэвт 8 цагийн сургалтыг Дархан хотноо 2 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтад Дархан-Уул аймгийн барилгын салбарын төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөл болсон 80 гаруй (ажил олгогч, менежер, ИТА, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан зэрэг) хүмүүс хамрагдлаа.





Барилгын хөгжлийн төвөөс аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нартай зөвлөлдөх уулзалтад оролцсон.




Орхон аймгийн Засаг даргын санаачилгаар “Дахин төлөвлөн барилгажуулах дэд бүтэцжүүлэх төслүүд” улсын анхдугаар зөвлөгөөнд 1 өдөр оролцсон.






Орон нутагт эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сэдэвт 2 өдрийн сургалтад хамрагдсан.





2022-03-16-аас 2022-03-18-ны хооронд Улаанбаатар хотод Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Орон зайн мэдээллийн технологийн хэлтсээс зохион байгуулсан Active directory, Domain control-ийн сургалтанд хамрагдлаа.








И-Монгол академийн цахим ур чадвар хөгжүүлэлтийн алба, Үндэсний дата төвөөс хамтран зохион байгуулж байгаа Мэдээллийн аюулгүй байдлын 3 хоногийн онлайн сургалтанд 2022-06-20-2022-06-22-ны хооронд хамрагдаж, шалгалтыг өгч, сертификат авлаа.







Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын Ерөнхий газар, Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хүрээнд Орхон аймагт 10-р сарын 1-9-ний өдрүүдэд “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль” нэгдсэн арга хэмжээнд Аймгийн Онцгой байдлын газар, сумын ЗДТГ нартай хамтран туршлага солилцсон.





Газар Зохион байгуулалт геодези зураг зүйн газраас зохион байгуулсан 21 аймгийн газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан.

Газрын нэгдмэл сангийн цахим систем, Төрийн өмчийн газрын мэдээллийн сан, хаягжуулалтын мэдээллийн системийн талаарх чадавхжуулах сургалтанд 2022.03.09-2022.03.11ны хооронд хамрагдсан.

Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сургалтанд сууж гэрчилгээ авсан.2022.07 сард Газрын кадастрын мэдээллийн сангийн “Ленд менежер” плограм хангамжийн сургалтанд хамрагдсан


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР
ГЭРЧИЛГЭЭ
№ГКМС 011-2022-3(018)
Мандах овогтой Дарьсүрэн нь
“Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийн” сургалтанд амжилттай суралцаж
“Газрын кадастрын мэдээллийн системийг эрхлэх” чадавхийг эзэмшсэн тул энэхүү гэрчилгээ олгов.
Хүчинтэй хугацаа:
ЦАХИМ ШИНЖИЛГЭЭ, ГАЗРЫН ХАРИЛЦАА
ГЭРЧИЛГЭЭ
овогтой
MERIT
Canada
ГЭРЧИЛГЭЭ
Дарьсүрэн Мандах
ТАНД
Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ
ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ОРОЛЦСОН ТУЛ ЭНЭХҮҮ ГЭРЧИЛГЭЭГ ОЛГОВ.
У. БЯМБАСҮРЭН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДЭД ДАРГА
ЖЕННИФЕР АДАМС
MERIT ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

## 3.5 БУСАД АЖИЛ

Цахим газрын харилцаа ажлын хүрээнд БАТЛАГДСАН ХУВААРЬ-ийн дагуу цахим системийн egazar.gov.mn сайтыг хэрхэн хэрэглэх талаар иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ хүргэж ажилласан.



БАТЛАВ.
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.БАТЧУЛУУН

Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системд цахимаар хүсэлт илгээх, танилцуулах мэдээлэл хийх хуваарь

| | Нэрс | 11-р сарын 8 өдөр | 11-р сарын 9 өдөр | 11-р сарын 10 өдөр | 11-р сарын 11 өдөр | 11-р сарын 12 өдөр | 11-р сарын 15 өдөр | 11-р сарын 16 өдөр | 11-р сарын 17 өдөр | 11-р сарын 18 өдөр | 11-р сарын 19 өдөр | 11-р сарын 22 өдөр | 11-р сарын 23 өдөр | 11-р сарын 24 өдөр | 11-р сарын 25 өдөр | 11-р сарын 29 өдөр | 11-р сарын 30 өдөр | 12-р сарын 01 өдөр | 12-р сарын 02 өдөр | 12-р сарын 03 өдөр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ч.Анхбаяр | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Ц.Чулуунцэцэг | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Б.Баярмаа | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Э.Гурханд | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Б.Төмөр | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Ц.Цэнд-Аюуш | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Э.Түмэнжаргал | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 8 | Б.Золбаясах | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 9 | С.Үндрах | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 10 | С.Дарханбаатар | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 11 | Б.Мөнхзул | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 12 | Б.Мөнгөнтогос | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 13 | Г.Нямдорж | | | | | | | | | | | | | | | | | | | |

Хуваарь гаргасан: Г.Нямдорж /Газрын удирдлагын хэлтсийн дарга/





*Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд*

2022 оны 05 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд Дархан сумын Уужим булагт Хараагийн эрэг дагуу нийт 160 ширхэг 5 төрлийн мод тарьсан. Мөн Монгол улсын ерөнхийлөгчийг Дархан хотод ирэхэд шинэ иргэний төгөлд 20 нарс, аймгийн Ногоон Дархан 2032 дэд хөтөлбөрийн хүрээнд байгууллагын гаднах талбайд 5 ширхэг нарсыг тарилцсан.









*Намрын ногоо хураалтанд хамт олноороо явж нэг өдөр ажилласан.*





Мал бүхий иргэдийг төвөөс гадагш нэг цэгт төвлөрүүлж Төмсний бригадад 6 га газар олгосон. энэ ажилтай холбоотой 2022.04.27-28-ны өдрүүдэд ДарханЭрдэс Шохойт Шийр ХХК, Силикат ХК –уудаас тус тус 5 тн нунтаг шохой авч 60 айлын хашааны газрыг нунтаг шохойгоор шугам татан тэмдэгжүүлсэн. Нийгмийн хариуцлагын үүднээс дээрх 2 компани үнэ төлбөргүй нунтаг шохойг машинаар хүргэж бидний ажилд тусалсан.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

45025 Хонгор сум, Дархан-Уул аймаг

2022.05.07 № 1/202

танай ______ -ны № ______ -т

ИДЭР ХАЙРХАН ХХК-НИЙ ЗАХИРГААНД

Дархан-Уул аймгийн Дархан сумын мал бүхий иргэдийг тус сумын 1 дүгээр баг талын толгой төмсний бригад орчимд 16.6 га буюу 116 мал бүхий иргэдэд шинээр газар эзэмшүүлэхээр төлөвлөөд байна.

Иймд дээрх газрын улаан шугамыг тавихад 2 тн шохой шаардлагатай байгаа тул шийдвэрлэж өгнө үү.

ДАРГА Д.ЧАГНААДОРЖ

А5Албан тоот-2022

- Дархан сумын мал бүхий иргэдийг төвөөс гадагш нэг цэгт төвлөрүүлж Хонгор сумын 1-р баг Талын толгой төмсний бригад орчимд 11.2 га буюу 78 айл өрх, мал бүхий иргэдэд шинээр газар эзэмшүүлэх, газрын байршил, хил заагийг газар дээр нь шохойгоор тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Мөн гахайн аж ахуйн эрхэлж буй 33 иргэн, 14 ААНБ-ууд 14.8 га газар Орхон сумын Ноёнхонгорт төлөвлөж олгохоор бэлтгэл ажлыг хангаад байна.
- Тус ажлын хүрээнд хамтран ажилласан **Силикат ХК**, **Дархан Эрдэс Шохойт Шийр ХХК**, **Сутайн ухэр чулуут ХХК**, **Тулгат шийр ХХК**-иудад бидний ажилд тусалж, дэмжиж аймаг, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулж хамтран ажилласан.



Барилгын 96 жилийн ойн баярын хүрээнд шилдэг 10 барилгын шалгаруулалтанд “Баян Бридж” ХХК-ний барилга шилдэг барилгаар тодорсон.



Дархан хотын барилгын салбарын захирал,гүйцэтгэх албан тушаалтан, инженер техникийн ажилтан нарт мэргэжлийн заавар зөвлөгөө, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор "The future of construction" уулзалтыг зохион байгуулж барилгын салбарт түгээмэл тохиолдолж байгаа асуудлаар талаар нээлттэй хэлэлцүүлэгийг явуулсан.




Барилгын салбарын 96 жилийн ойн баярыг тохиолдуулан зохион байгуулсан БАРИЛГАЧДЫН СПОРТЫН ИХ НААДАМ-д Дархан-Уул аймгийн барилгын салбарын 18 байгууллагуудыг оролцуулан 2022.11.29-2022.12.01-ны өдрүүдэд 4 төрөлт тэмцээнийг зохион байгуулж ажиллсан.

